

Mongolian Economy

2025 оны 10 сар (201)

www.mongolianeconomy.mn

Өвлийн аялал жуулчлал

Монголын өвлийн аяллын
шинэ зүрх-Хөвсгөл

Бүсчилсэн хөгжил

Бүсчилсэн хөгжлийн бодлого
аялал жуулчлалд

ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ





TEGRI
GOBI
RESORT

"Тэгри Говь" - Монголын говийн онгон байгальд, аниргүй орчин дунд Марс гарагт хөл тавьсан мэт гайхалтай мэдрэмжийг тансаг тав тухтай хамт нэгтгэсэн өвөрмөц резорт юм.

Өмнөговийн элсэн манхан дунд орших энэхүү цогцолбор нь аялал жуулчлал, амралт, сувиллыг нэг дор багтаасан төгс хослол. "Тэгри Мэд" амралт, сувиллын салбар болох "Тэгри Говь" нь говийн байгалийн эрч хүчийг сансар огторгуйн уур амьсгал, үлэг гүрвэлийн ертөнцийн дүрслэлтэй интерьер, эрүүл мэнд ба архитектурын ухаалаг шийдэлтэй хослуулсан орчин үеийн тансаг резорт юм.

Гэвч энэ бол Монголын говь — **Үлэг гүрвэлийн мөр**, түүхийн нууцыг хадгалсан газар. Хэдэн арван сая жилийн өмнө энэ нутагт аварга биет амьтад алхаж байсан гэхэд итгэмээргүй. Харин өнөөдөр тэр мөрийг даган "Тэгри Говь"-д хүрч ирэх бүрт түүх, байгаль, орчлонгийн уялдаа танд мэдрэгдэнэ.

Түүхэн цаг мөч, үлэг гүрвэлийн мөрөөр алхаж,
Марс гарагийн мэдрэмж
Дахин давтагдашгүй дурсамж.



Капсул хаус

Ариун цэврийн өрөө, шүршүүр, цэвэр бохирын бие даасан шийдэл, АС болон шалаар халах боломжтой, 2-4 хүн багтаамжтай.

Сувилал

Дорнын уламжлалт анагаах ухааны зүү засал, бариа засал, элсэн эмчилгээ



Спа

Ядаргаа алжаал тайлах бүтэн биеийн болон хэсгийн бариа, үсний спа, нүдний спа

Аялал

Тэгри говь ресортын онцгой үйлчилгээ +Говийн үзэсгэлэнт газруудын аялал



Ресторан

Ази болон европ, уламжлалт монгол хоолны дээд зэрэглэлийн рестораны үйлчилгээ



Мэндчилгээ 04
ITM-2025 "Тогтвортой аялал жуулчлал-Төв Ази" зорилго дор болж байна

Мэндчилгээ 07
Хоёр их эзэнт гүрний түүх нь өв соёлын гүн гүнзгий уялдаа холбоог илтгэнэ

Онцлох 08
Монголын аялал жуулчлалын үнэ цэн

НҮБ 14
Яап ван Хиердэн: Хариуцлагатай аялал жуулчлалыг бодлоготой хэрэгжүүлвэл экосистемд ирэх дарамт буурна

Монголын аялал жуулчлалын холбоо 18

Тогтвортой аялал жуулчлалын манлайлал

Хүннү Эйр 20
П.Мөнхжаргал: Төв Азийг маш ирээдүйтэй зах зээл гэж харж байгаа

COP17 22
Ирээдүйн төлөө нэгдэх цаг-COP17

Нью жуулчин турс 24
Д.Наранцэцэг: Манай салбарт болзошгүй эрсдэлээс хамгаалах бодлого дутагдалтай

Бүсчилсэн аялал жуулчлал 26
Бүсчилсэн хөгжлийн бодлого АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛД

Түнш аймаг 30
Монголын баруун хязгаар нутаг Баян-Өлгийд зочлоорой

Baruun Beach Resort 34
Ц.Анхбаяр: Далайн эргийн орнууд руу үрсах валютыг эх орондоо үлдээх зорилготой

Архангай 38
Архангайн аялал жуулчлалын хамтын хүч "АРА"

Монгол Номадик 40
Д.Энхбаатар: Монголчуудын нүүдлийн соёл, аж ахуйг нэг дор харах боломжийг бүрдүүлсэн

Өвлийн аялал жуулчлал 42
Монголын өвлийн аяллын шинэ зүрх-Хөвсгөл

Gobi Caravanseraï Lodge: The Ultra Escapist Destination 48
Хязгааргүй говийн гүнд орших Говь Каравансерай лодж

Дотоодын аялал жуулчлал 50
Дотоодын аялал жуулчлал эдийн засгийг тэтгэгч том салбар байх ёстой

Хүний нөөц 52
Дотоод нөөц боломжоо эхлээд харцгаая

Мэндчилгээ

ITM-2025 "Тогтвортой аялал жуулчлал-Төв Ази" зорилго дор болж байна



ДАМБЫН ГАНТӨМӨР
Др.(Sc.D)
 Монголын Аялал
 Жуулчлалын Холбооны
 Ерөнхийлөгч

Хүндэт зочид төлөөлөгчид, түнш байгууллагууд, салбарын эрхэм хамт олон, Монголын Аялал Жуулчлалын хамтрагчид, найзууд аа,

Аялал жуулчлалын салбарын жил бүрийн нэгэн чухал үйл явдал “International Tourism Mart-2025” уламжлал ёсоор 26 дахь удаагаа зохион байгуулагдаж байна. Энэхүү арга хэмжээ нь Монголын аялал жуулчлалын салбар өмнө жилийнхээ алдаа оноо, амжилт ололтыг дүгнэн хэлэлцэх, ирэх он жилүүдэд хэрэгжүүлэх шинэ санаа оноо, бүтээгдэхүүн үйлчилгээгээ дэлгэн танилцуулах, интеграци хөгжүүлэлтийг хэлэлцэх, хүндрэл бэрхшээлийг даван туулах, харилцан суралцаж, хамтын ажиллагаагаа илүү мэргэжлийн, хариуцлагатай чиглэлээр оновчтой бодлого, төлөвлөлтэйгээр ажиллах боломж нөхцөлийг хангах салбарын нийт оролцогчид, үйлчлүүлэгч, түншүүдийн төвлөрсөн уулзалт платформ юм.

Олон дэд үйлчилгээ, нэгжээс бүрддэг аялал жуулчлалын салбарын амжилтын үндсэн зарчим нь хамтын ажиллагаа гэдгийг бид бүрнээ мэдэрч ойлгож буй. Зөвхөн дотооддоо төдийгүй олон улсын хэмжээнд ялангуяа бүс нутаг, соёл гарвал ижил, ойр зах зээлийн зорих газруудтай хамтын бүтээлч, идэвхтэй хамтран ажиллах нь манай улсын аялал жуулчлалын салбарыг бүс нутгийн хамтын интеграци, дэмжлэг дунд олон улсын нэгдмэл маркетинг, бүтээгдэхүүн үйлчилгээний даацтай нөлөөллийг бий болгон ахиулахад чухал ач холбогдолтой.

Төв Азийн бүс нутгийн аялал жуулчлалын нийтлэг онцлог болсон эмзэг онгон байгаль, нүүдэлчдийн бүтээсэн дэлхийд гайхагдах түүх соёлын амьд өв уламжлал тэргүүтэн салбарын нөөц, нийлүүлэлт, үйлчилгээг Тогтвортой Хөгжлийн үндсэн үзэл баримтлалтай уялдуулан уян хатан, шинэ түвшинд гарган, идэвхтэйгээр манлайлан ажиллахад Монгол Улсын үүрэг оролцоо, бүтээлч алхам чухал. Тиймээс энэ жилийн манай арга хэмжээ нь “Тогтвортой Аялал Жуулчлал-Төв Ази” хэмээх чиглэл, зорилго

дор зохион байгуулагдаж буй. Бид аялал жуулчлалын тоон статистик ба чанарын өгөөжийг хамтад нь харах шаардлагатай. Жуулчдын дагуул дансны аргыг нэвтрүүлэх нь бодлогын зайлшгүй чиглэл.

Гадаа хэрээр аялал (outdoor activity) нь голлон явагддаг манай улсын хувьд аялал жуулчлалын масс тоон үзүүлэлтийг ажлын байр, хөрөнгө оруулалт, сонирхол, аж ахуйн нэгжийн өсөлт чадамж, бүс нутгийн даац, байгаль-соёлд үзүүлэх нөлөөлөл, орон нутгийг эдийн засагжуулах зэрэг микро-месо-макро үзүүлэлтэйгээр тооцон аялал жуулчлалын бүтэн систем-анатоми бүтцээр нь цогц төлөвлөн, салбарын бодлогыг тодорхойлох нь чухал.

Монголын Аялал Жуулчлалын Холбоо нь төр, хувийн хэвшил, олон улсын түншүүдтэй хамтран хүртээмжтэй, хариуцлагатай, тогтвортой өсөлтийг тууштай дэмжин ажиллахыг эрмэлзэн ажилладаг.

Ингээд Холбооны нэрийн өмнөөс салбарын хөгжлийг бодитоор дэмжин хамтран ажиллагч бүхий л байгууллага, аялал жуулчлалын төлөө зүрх сэтгэлээ зориулж ажил үүргээ чимээгүй гүйцэтгэж яваа ажилтан, албадууд, аж ахуйн нэгж, гишүүд дэмжигч, хамтрагчиддаа чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлж байгааг минь хүлээн авна уу.

Ялангуяа “International Tourism Mart 2025” арга хэмжээг хамтран зохион байгуулж буй ССАЖЯ, Нийслэлийн АЖГ, Түнш аймаг Баян-Өлгий аймгийн ЗДТГ, Дэмжигч Турк улсын “GML Tour” Компани, Эвент, мэдээллийн түнш байгуулагууддаа болон үзэсгэлэнд оролцож буй бүхий л байгууллага, компаниуд, 21 аймгийнхаа аялал жуулчлалын цогтой мэргэжилтэн, холбоодууддаа гүн хүндэтгэл, талархалаа илэрхийлж хөгжил дэвшлийн хамтын ажиллагаа, амжилт бүтээлийг хүсэн мэндчилж байна!

ITM-2025 шинэ санаа шийдэл, баяртай уулзалт, үр дүнтэй түншлэл, аялал жуулчлалын ирэх хөгжлийн нэгэн хөтөч- шинэ цэнэг болохын ерөөл өргөө! Аялал жуулчлал тогтвортой хөгжих болтугай! ■





МӨНХ УНДРАХ ӨГИЙ



ЖИЛИЙН ДӨРВӨН УЛИРАЛД
ТАСРАЛТГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЯВУУЛДАГ ЖУУЛЧНЫ БААЗ

Утас: 99058699, 80272299, 80812299
www.uginuur.mn

Мэндчилгээ

Хоёр их эзэнт гүрний түүх нь өв соёлын гүн гүнзгий уялдаа холбоог илтгэнэ



АЙБЕК АРТЫКБАЕВ
Бүгд Найрамдах Киргиз
Улсаас Монгол Улсад
суугаа Онц бөгөөд Бүрэн
эрхт Элчин сайд

Өнөөгийн дэлхий ертөнцөд Бүгд Найрамдах Киргиз улсыг “залуу орон” хэмээн үздэг ч, агуу Киргизийн ард түмэн бол 3000 гаруй жилийн түүхтэй, өөрийн гэсэн төр улсаа байгуулж, хүн төрөлхтний түүхэнд тод мөр үлдээсэн эртний үндэстэн юм. Манай өвөг дээдэс олон зууны турш сорилт, ялалтыг даван туулж, хэл, соёл, уламжлал, оюун санааны арвин өвийг хадгалан, хойч үедээ ариун нандин өв болгон өвлүүлж чадсан билээ.

Киргиз, Монголын ард түмэн олон мянган жилийн турш мөр зэрэгцэн оршиж, ижилсэл хувь заяа, үзэл санааг хуваалцаар ирсэн. МЭ VII–X зууны үед оршин тогтнож байсан Киргизийн Их хаант улс, мөн Чингис хааны Их эзэнт гүрний түүх нь хоёр ард түмний өв соёлын гүн гүнзгий уялдаа холбоог илтгэх тод жишээ юм. Энэхүү түүхэн ойр дотно харилцаа, оюун санааны нэгдмэл байдлыг ухамсарлан, Бүгд Найрамдах Киргиз Улс Монгол Улстай ах дүүгийн найрамдалт харилцааг бэхжүүлэхэд онцгой ач холбогдол өгч байна.

Өнөөдөр Киргиз Улсад 80 гаруй үндэстний төлөөлөл эв найрамдалтай, харилцан хүндэтгэлтэй, амар амгалан амьдарч байна. Ард түмний эв нэгдэл, нягтрал, сайхан сэтгэл бол бидний хамгийн үнэт баялаг юм.

Ардчилсан, нэр хүндтэй, эрчимтэй хөгжиж буй улсын хувьд Киргиз дэлхийн бүх улс оронтой баг бөх харилцаа тогтоож, олон улсын тавцанд өөрийн байр суурийг тууштай бэхжүүлж байна. Манай гадаад бодлого олон талт, харилцан ашигтай хамтын ажиллагаа, найдвартай түншлэлийг бүх салбарт хөгжүүлэхэд чиглэгддэг.

Бид ногоон технологийг хөгжүүлэх, аялал жуулчлалын орчин үеийн дэд бүтцийг бий болгох, гадаадын хөрөнгө оруулалтыг татахад онцгой анхаарч байна. Стратегийн ач холбогдол бүхий “Хятад–Киргизстан–Узбекистан” төмөр замын төслийг хэрэгжүүлснээр Зүүн Азийг Европтой холбосон хамгийн богино тээврийн коридор нээгдэж, тивийн хойд ба өмнөд хэсгийг холбох шинэ гарц бий болж, бүс нутгийн

хамтын ажиллагаа, аялал жуулчлалын шинэ боломжуудыг бүрдүүлнэ.

Сүүлийн жилүүдэд Киргиз, Монгол хоёр улсын улс төрийн яриа хэлэлцээ эрчимтэй хөгжиж, хамтын ажиллагааг бүх чиглэлд өргөжүүлэх таатай нөхцөл бүрдэж байна. Энэ замналын чухал үйл явдлуудад Бүгд Найрамдах Киргиз Улсын Ерөнхийлөгч ноён Садыр Нургожоевич Жапаровын 2023 оны долдугаар сард Монгол Улсад хийсэн төрийн айлчлал, мөн Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн 2025 оны долдугаар сард Киргиз Улсад хийсэн хариу айлчлал багтана. Эдгээр харилцан айлчлал нь хоёр орны дээд болон парламентын түвшний харилцааг гүнзгийрүүлж, цаашдын иж бүрэн түншлэлийн баг бөх суурийг тавьсан юм.

Хоёр орны харилцаанд аялал жуулчлал онцгой байр суурь эзэлдэг. Улаанбаатар, Бишкек хотуудад зохион байгуулагдсан аялал жуулчлалын танилцуулга, B2B уулзалт нь хоёр улсын аялал жуулчлалын салбарын төлөөлөгчдийн харилцан туршлага солилцох, мэргэжлийн харилцаа холбоог бэхжүүлэх, аялал жуулчлалын чиглэлүүдийг сурталчлахад чухал хувь нэмэр оруулж байна.

Киргиз, Монгол хоёр улс соёл, түүх, экологийн аялал жуулчлалыг хамтран хөгжүүлэх асар их нөөц бололцоотой. Бид Монгол дахь Киргиз үндэстний түүх, өв уламжлалтай холбоотой аялал жуулчлалын маршрутыг зохион байгуулах сонирхолтой. Монголын анд нөхдөө Төв Азийн сувд хэмээн алдаршсан Иссык-Куль нуур болон Киргизийн үзэсгэлэнт байгаль, түүхэн дурсгалт газруудаар аялахыг урьж байгаадаа баяртай байна.

Аялал жуулчлалын хөгжил нь Киргиз, Монголын ард түмний найрамдлын баг бөх гүүр болж, харилцан ойлголцол, итгэлцэл, түншлэлийг бүх салбарт бэхжүүлнэ гэдэгт гүнээ итгэж байна. Киргиз болон ахан дүүс Монголын ард түмэнд амар амгалан, хөгжил дэвшил, цэцэглэлтийг хүсэн ерөөе! ■

Онцлох

Монголын аялал жуулчлалын үнэ цэн

“Ковид-19” гэх урилгагүй зочноос болоод тэг зогсож, уналтад ороод байсан аялал жуулчлал сүүлийн хоёр жилийн хугацаанд эрчимтэй сэргэж салбарынхан тун завгүй ажиллаж байна. НҮБ-ын Аялал жуулчлалын байгууллага (UNWTO)-ын мэдээлснээр 2024 онд олон улсад 1.4 тэрбум жуулчин зорчсон нь 2019 оны түвшнээс 99 хувиар сэргэсэн гэж дүгнэсэн. Үүнээс харахад тус салбар цар тахлын өмнөх түвшиндээ бүрэн эргэн орж эдийн засгийг тэтгэгч чухал “байр суурь”-аа эргүүлэн авчээ.

Жуулчдын зочид буудал, тээвэр, хоол хүнс, худалдан авалт зэрэгт зарцуулж буй мөнгө бүр ажлын байр бий болгож, жижиг дунд бизнесийг дэмждэг. НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын мэдээллээр, тус салбар нь дэлхий даяар 300 гаруй сая хүнийг ажлын байраар хангаж байна. Мөн өнгөрсөн онд аялал жуулчлалын салбар ойролцоогоор 10.9 их наяд ам.долларыг дэлхийн эдийн засагт оруулсан гэх Дэлхийн банкнаас гаргасан судалгаа энэ бүхнийг нотолж байна. Түүнчлэн 2024 онд аялал жуулчлалын салбар дэлхийн ДНБ-ий ойролцоогоор 10% буюу 11.1 их.наяд ам.долларыг бүрдүүлсэн хэмээн Дэлхийн аялал жуулчлалын зөвлөлөөс (WTTC) мэдээлсэн.

Испани, Франц, Япон, Тайланд зэрэг улс орон аялал жуулчлалаа эдийн засгийн гол хөдөлгүүр болгож чадсан. Тухайлбал, Франц улс жил бүр 80 сая гаруй жуулчин хүлээн авч, 60 тэрбум ам.долларын орлого олдог бол Тайландын ДНБ-ий 20 хувь нь аялал жуулчлалаас бүрддэг байна. Эдгээр улс байгаль, соёл, технологи гурвыг уялдуулсан ухаалаг бодлого хэрэгжүүлж чадсан юм.

Дэлхийн Эдийн Засгийн Форумын гаргасан

Аялал жуулчлал нь дэлхий даяар 300 гаруй сая хүнийг ажлын байраар хангаж байна



“Аялал жуулчлалын өрсөлдөх чадварын индекс-2024”-т Монгол Улс 3.57 оноогоор 119 орноос 85-р байрт жагссан. Харин “Ковид-19” цар тахлын өмнө буюу 2019 онд 140 орноос 93-р байрт эрэмблэгдэж байсантай харьцуулахад манай аялал жуулчлалын салбарт ч ахиц гарчээ.

Аялал жуулчлал зөвхөн гаднаас хүн татаж, мөнгө олох бизнес бус, тухайн улс орны байгаль орчин, соёл уламжлалаа дэлхий дахинаа түгээн дэлгэрүүлэх, сурталчлах бас нэг боломж юм. Олон улсад аялал жуулчлалын хөгжлийн үзүүлэлтээ сайжруулах, цаашлаад эдийн засгийн гол салбар болгохын тулд бид өөрсдийн боломж, давуу талаа ашиглах ёстой. Монголыг дэлхийд онцгой болгодог зүйл бол онгон зэрлэг байгаль, эртний түүх, нүүдлийн соёл, уламжлал юм.

“Монголд цаг удааширч, энерги сэргэж, сэтгэл амгалан болдог” хэмээн хэлсэн гадаадын жуулчинтай ч таарч байлаа. Нүүдлийн соёл ►



► бол зөвхөн амьдралын хэв маяг биш, харин байгальтайгаа холбогдож тэнцвэртэй орших ухаан, философи юм. Монгол гэр, морин хуур, хөөмий, уртын дуу, цагаан идээ, тал дүүрэн бэлчих таван хошуу мал, монгол наадам бол дэлхийд дахин давтагдашгүй, соёлын үнэт өв билээ.

Говийн халуун элсэн дунд тэмээн жингийн цуваа гэлдэрч, Хангайн уулсын дунд морин хуурын аялгуу, уртын дуутай эгшиглэнэ. Хөвсгөлийн тунгалаг ус, Хэнтийн ногоон хөндий, Алтайн сүрлэг оргилууд гээд бүгд нэгэн цул мэт оршдог. Энэ бол жуулчдын сэтгэлийн гүнд хүрэх Монголын аялал жуулчлалын хүч юм.

Гэвч бид энэ үнэт зүйлийг дэлхийд бүрэн дүүрэн таниулж чадахгүй байгаа гэж хэлэхэд хилсдэхгүй биз ээ. Эко аялал, адал явдалт аялал, соёлын аялал, уламжлалт ахуйг танин мэдэх аялал зэрэг чиглэлээр бид дэлхийд өрсөлдөх

**Жуулчдын
76 хувь нь
Монголын
уламжлалт
зан заншил,
нүүдэлчин
соёл,
үзэсгэлэнт
байгальд
татагддаг**

бүрэн боломжтой.

Дэлхийн хүн амын дөнгөж нэг хувь нь нүүдлийн мал аж ахуйтай холбоотой гэсэн тоо байдаг. Гэхдээ тэдний арга ажиллагаа, ахуй амьдрал Монголын нүүдлийн соёлтой адил биш. Хэдийгээр нийгмийн хөгжлийг дагаж багагүй өөрчлөгдөж байгаа ч нүүдэлчдийн уламжлалт соёлоо өдий хүртэл хадгалсаар буй орон бол Монгол. Тиймээс нүүдлийн өв соёл нь аялал жуулчлалын маш сонирхолтой бүтээгдэхүүн юм. Харин юуг нь онцолж, яаж үзүүлэх вэ гэдэг нь маш чухал.

Монголбанк, Аялал жуулчлалын үндэсний төв хамтран 2015 онд “Монгол Улсад аялж буй гадаадын жуулчдын зардлын түүвэр судалгаа”-г хийж байсан. Уг судалгаанд оролцсон жуулчдын Монгол Улсад аялсан шалтгаан, сэтгэл ханамжийг дүгнэхэд жуулчдын дийлэнх буюу 76 хувь нь уламжлалт зан заншил, нүүдэлчин соёл болон ►

Аялал жуулчлалын олон улсын өрсөлдөх чадварын индекс 2024

Зэрэглэл	Оноо	2019 оноос хойшхи өөрчлөлт		TTDI-ийн дундажаас зөрүүтэй (%)	Зэрэглэл	Оноо	2019 оноос хойшхи өөрчлөлт		TTDI-ийн дундажаас зөрүүтэй (%)	Зэрэглэл	Оноо	2019 оноос хойшхи өөрчлөлт		TTDI-ийн дундажаас зөрүүтэй (%)			
		Зэрэглэл	Оноо				Зэрэглэл	Оноо				Зэрэглэл	Оноо				
1	АНУ	5.24	0	-0.5%	32.3%	41	Саудын Араб	4.23	9	5.7%	6.7%	81	Танзани	3.65	7	4.5%	-7.9%
2	Испани	5.18	0	0.9%	30.6%	42	Словени	4.22	-9	-1.2%	6.4%	82	Марокко	3.64	-12	-3.2%	-8.2%
3	Япон	5.09	0	-0.3%	28.5%	43	Рум	4.19	2	0.8%	5.7%	83	Тунис	3.60	2	1.0%	-9.2%
4	Франц	5.07	2	0.8%	28.0%	44	Литва	4.17	4	1.4%	5.2%	84	Ямайка	3.59	-1	-0.1%	-9.5%
5	Австрали	5.00	2	0.8%	26.0%	45	Гүрж	4.14	4	1.0%	4.4%	85	Монгол	3.57	-6	-2.0%	-9.8%
6	Герман	5.00	-1	-0.8%	26.0%	46	Хорват	4.13	-2	-0.7%	4.3%	86	Камбож	3.57	4	2.5%	-10.0%
7	Англи	4.96	-3	-2.4%	25.2%	47	Тайланд	4.12	-6	-2.5%	3.9%	87	Хойд Македон	3.53	-5	-1.9%	-10.9%
8	Хятад	4.94	1	1.0%	24.6%	48	Израил	4.10	-5	-1.6%	3.4%	88	Молдав	3.53	1	1.0%	-11.1%
9	Итали	4.90	3	2.1%	23.5%	49	Аргентин	4.10	-2	-0.6%	3.4%	89	Тринида ба Тобаго	3.52	-5	-2.1%	-11.3%
10	Швейцарь	4.81	-2	-2.3%	21.3%	50	Колумб	4.08	6	2.3%	3.0%	90	Босни Герцеговина	3.51	1	1.1%	-11.5%
11	Канад	4.81	-1	-1.1%	21.2%	51	Коста Рика	4.08	4	2.2%	2.9%	91	Лаос	3.48	2	1.7%	-12.1%
12	Португал	4.78	1	-0.1%	20.6%	52	Казахстан	4.07	6	3.7%	2.6%	92	Парагвай	3.47	0	0.8%	-12.5%
13	Сингапур	4.76	-2	-1.7%	19.9%	53	Катар	4.02	-7	-3.3%	1.3%	93	Руанда	3.45	6	2.6%	-12.9%
14	Солонгос	4.74	0	1.1%	19.6%	54	Бүгд Найрамдах Словак	4.00	-2	-0.2%	0.8%	94	Болив	3.45	3	2.1%	-12.9%
15	Австри	4.65	0	-0.5%	17.4%	55	Өмнөд Африк	3.99	7	3.4%	0.7%	95	Намиби	3.45	-8	-1.7%	-13.0%
16	Нидерланд	4.64	1	0.1%	17.0%	56	Азербайжан	3.98	-5	-0.6%	0.3%	96	Кувейт	3.44	-10	-2.9%	-13.2%
17	Денмарк	4.63	-1	-0.9%	16.8%	57	Маврики	3.98	-4	-0.7%	0.3%	97	Эль Сальвадор	3.43	4	4.0%	-13.4%
18	Арабын нэгдсэн Эмират улс	4.62	7	4.4%	16.5%	58	Бахрейн	3.96	3	2.1%	-0.1%	98	Алжир	3.42	2	2.6%	-13.6%
19	Швед	4.57	0	0.7%	15.4%	59	Вьетнам	3.96	4	3.2%	-0.2%	99	Тажикстан	3.42	-3	0.7%	-13.7%
20	Финланд	4.52	-2	-1.7%	14.0%	60	Монтенегро	3.96	-1	0.9%	-0.2%	100	Гватемал	3.42	-5	0.5%	-13.8%
21	Грек	4.52	5	2.6%	13.9%	61	Египет	3.96	5	4.3%	-0.2%	101	Пакистан	3.41	3	3.6%	-14.0%
22	Индонез	4.46	14	4.5%	12.4%	62	Перу	3.90	7	3.5%	-1.5%	102	Киргиз	3.38	1	2.8%	-14.7%
23	Белги	4.45	0	-0.5%	12.2%	63	Панам	3.90	-6	-1.2%	-1.6%	103	Венесуэл	3.34	-5	-0.9%	-15.7%
24	Ирланд	4.44	-3	-1.5%	12.0%	64	Доминикан	3.88	1	1.8%	-2.0%	104	Замби	3.34	-2	1.4%	-15.7%
25	Шинэ Зеланд	4.41	-5	-2.6%	11.3%	65	Латви	3.88	-11	-3.0%	-2.1%	105	Непал	3.34	0	2.8%	-15.7%
26	Бразил	4.41	8	3.3%	11.2%	66	Албани	3.87	12	5.9%	-2.4%	106	Гана	3.28	1	1.5%	-17.2%
27	Польш	4.40	3	2.0%	11.1%	67	Оман	3.87	-7	-1.2%	-2.5%	107	Сенегал	3.24	2	2.5%	-18.2%
28	Люксембург	4.40	-4	-0.9%	10.9%	68	Серби	3.86	3	2.7%	-2.8%	108	Никарагуа	3.24	-2	0.0%	-18.3%
29	Турк	4.39	8	3.1%	10.6%	69	Филиппин	3.84	-2	1.7%	-3.1%	109	Бангладеш	3.19	2	3.0%	-19.5%
30	Кипр	4.37	-3	-0.4%	10.4%	70	Жордан	3.81	2	2.0%	-4.0%	110	Зимбабве	3.19	0	2.5%	-19.6%
31	Чили	4.33	4	1.4%	9.2%	71	Уругвай	3.79	-3	0.4%	-4.3%	111	Гондурас	3.19	-3	-1.4%	-19.6%
32	Исланд	4.32	-10	-3.4%	9.0%	72	Армен	3.73	-8	-2.4%	-5.9%	112	Нигери	3.18	1	4.2%	-19.8%
33	Чех	4.31	-2	0.3%	8.8%	73	Иран	3.72	4	1.5%	-6.3%	113	Бенин	3.16	-1	3.3%	-20.4%
34	Мальта	4.30	4	1.1%	8.4%	74	Барбадос	3.71	-1	-0.4%	-6.5%	114	Кот-д'Ивуар	3.13	2	6.4%	-21.0%
35	Малайз	4.28	-7	-2.2%	7.9%	75	Ботсвана	3.71	6	2.5%	-6.5%	115	Малави	3.06	0	2.8%	-22.8%
36	Эстони	4.28	4	0.7%	7.8%	76	Шри Ланка	3.69	-1	0.0%	-6.8%	116	Ангол	3.05	-2	1.3%	-22.9%
37	Унгар	4.27	5	1.7%	7.7%	77	Кени	3.68	-1	0.1%	-7.1%	117	Камерун	2.99	0	3.1%	-24.6%
38	Мексик	4.26	-6	-0.6%	7.4%	78	Узбекистан	3.68	16	7.8%	-7.3%	118	Сьерра Леон	2.89	0	2.7%	-27.1%
39	Энэтхэг	4.25	-10	-2.1%	7.1%	79	Ливан	3.66	1	0.8%	-7.6%	119	Мали	2.78	0	-0.4%	-30.0%
40	Болгар	4.25	-1	0.0%	7.1%	80	Эквадор	3.66	-6	-1.0%	-7.6%						

● Америк тив ● Ази-Номхон далайн ● Европ ба Еврази ● Ойрхи Дорнод ба Хойд Африк ● Сахарын цөлөөс Өмнөх Африк

Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн форум

► үзэсгэлэнт байгаль, зэрлэг ан амьтанд татагдсан гэжээ. Зөвхөн байгаль үзүүлэх биш, туршлага, мэдрэмж, оролцоог бий болгох нь хамгийн чухал. Гадаадын жуулчин монгол гэр барих, айраг, цагаан идээ боловсруулах, морь унах, хонь хариулах, тугал хаших зэрэг Монголын мал аж ахуй, нүүдэлчин ардын амьдралыг өөрийн биеэр мэдрэхийг хүсдэг. Энэ л үед жуулчин Монголыг зүгээр нэг үзээгүй, харин “амссан, амьсгалсан, мэдэрсэн” байдаг.

Үүний тулд нутгийн иргэдийн оролцоо

хамгийн чухал. Учир нь жуулчдын үзэж харах, мэдэрч турших бүхий л туршлага тухайн нутгийн иргэдийн оролцоотойгоор бүтнэ. Өөрсдийн уламжлалт соёлыг, аж ахуй, амьдралын хэв маягийг жуулчдад танилцуулснаар аяллын үнэ цэн нэмэгдэж, зөвхөн эдийн засгийн бус соёлын ач холбогдолтой.

НҮБ-ын ДАЖБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын алба хашиж байсан Талеб Рифай 2019 онд манай улсад айлчлах үеэрээ “Монгол Улсын аялал жуулчлалын салбарт нүүдлийн буюу “nomad-►

► ic” брэнд томоохон байр суурь эзэлдэг. Тиймээс энэхүү брэндээ дэлхийд сурталчлан таниулж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өмчилж авах хэрэгтэй” хэмээн онцлон хэлсэн.

Энэ бүхний хэрэгжүүлэхэд үндэсний хэмжээний бодлого, дэд бүтэц, хууль, эрх зүйн таатай орчин, мэргэшсэн, чадварлаг хүний нөөц бидэнд маш чухал. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”-ийг хэрэгжүүлэх, эдийн засгийг солонгоруулах, аялал жуулчлалын салбарыг тэргүүлэх чиглэл болгох, цаашид Монгол Улсад дөрвөн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэхтэй уялдуулан 2023-2028 оны Монголд зочлох жил болгон зарласан. Түүнчлэн 2030 он гэхэд бид хоёр сая жуулчин хүлээн авах зорилт тавьсан. Ингэснээр Монгол Улсын ДНБ-ий 10 орчим хувийг аялал жуулчлалын салбараас бүрдүүлэх, цаашид эрчимтэй хөгжиж буй олон улсын зах зээлийг Монголд илүү төвлөрүүлэх шаардлагатай гэж үзсэн. Үүний тулд энэ салбарт ойролцоогоор 11 орчим их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай гэж тооцоод байгаа юм.

Түүнчлэн Монголын аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэхэд хөдөө, орон нутгийн иргэдийн оролцоо маш ач холбогдолтой. Учир нь жуулчдын үзэж харах, мэдэрч турших бүхий л туршлага тухайн нутгийн иргэдийн оролцоотойгоор бүтдэг. Иргэд өөрсдийн уламжлалт соёл, аж ахуй, амьдралын хэв маягийг жуулчдад танилцуулснаар аяллын үнэ цэн нэмэгдэнэ. Орон нутгийн иргэд гар урлал, аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэхдээ зөвхөн орлого олох төдийгүй байгаль, соёлоо хамгаалах ухамсартай болж, нутгийнхаа өвөрмөц соёлыг хадгалан түгээнэ. Иймд Монголын аялал жуулчлалын бодлогыг төлөвлөх, бүтээгдэхүүн хөгжүүлэхдээ орон нутгийн иргэдийг идэвхтэй оролцуулах, тэдний ур чадвар, уламжлалыг дэмжих системийг бий болгох шаардлагатай. Аялал жуулчлал зөвхөн жуулчдын үзэж харах зүйл биш, орон нутгийн иргэдийн сэтгэл, бүтээмж, соёлын амьдралтай салшгүй холбоотой билээ.

Засгийн газраас аялал жуулчлалыг бүс, орон нутгийн онцлогт нийцүүлж, байгаль, түүх, соёлын өвд түшиглэн Баруун бүсэд адал явдалт, тусгай сонирхлын, Хангайн бүсэд-байгалийн, амралт

**Монгол Улс
2030 он
гэхэд хоёр
сая жуулчин
авах зорилт
тавьсан.
Үүний тулд
энэ салбарт
ойролцоогоор
11 орчим
их наяд
төгрөгийн
хөрөнгө
оруулалт
шаардлагатай**


зугаалгын, Говийн бүсэд палеонтологийн, Төвийн болон Улаанбаатарын бүсэд соёл бизнесийн, Зүүн бүсэд түүхэн төрөлжсөн аялал жуулчлал, түүнийг дагасан жижиг, дунд үйлдвэрлэл, үндэсний брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж хөгжүүлэхээр төлөвлөж байгаа.

Ямартаа ч бид жуулчдыг эх орон руугаа татаад эхэлсэн. 2024 онд манай улс түүхэн дээд амжилт тогтоож хамгийн олон жуулчин хүлээн авсан. Цаашид ч энэ тоог өсгөхийн тулд аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, Монголын нүүдлийн соёлын онцлогт тохирсон үндэсний шинэлэг, сор бүтээл, брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих шаардлагатай.

Гэвч сайны хажуугаар саар зүйл ч олон байна. Монголын зам тээвэр, дэд бүтэц муу, зочид буудал, жуулчны баазын стандарт жигд бус, төр-хувийн хэвшлийн уялдаа сул зэрэг бодит байдал дээр салбарыг хөгжүүлэхэд тулгамдсан асуудал олон бий. Олон улсын аялал жуулчлалын өрсөлдөх чадварын индексээр манай хамгийн их оноо алдсан үзүүлэлт нь агаар болон газрын дэд бүтцийн сул хөгжил. Цаашлаад 21-р зууны технологийн эрин үед бид модон жорлонгоосоо салаагүй байгаа. Модон жорлонгийн асуудал Монголыг зорьж ирсэн гадаадынхны нүдийг бүлтийлгэхэд хүргэдэг нь үнэн. “Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т аюулгүй байдал, даатгал, стандартчиллын асуудлыг тусгасан ч хэрэгжилт, хяналт нь бодит байдал дээр хангалтгүй байна. Ялангуяа адал явдалт аяллын төрөлд хамаарах шүхрийн нислэг, уулын спорт, морин болон мотоциклын аялал зэрэг нь онцгой эрсдэл дагуулдаг тул өндөр зохицуулалт шаарддаг. Гэвч эдгээр үйл ажиллагаа ихэнхдээ стандартгүй, даатгалгүй, мэргэшсэн боловсон хүчингүй, зөвшөөрөлгүй явагдаж байна. Үүний улмаас жуулчид осолдох, гэмтэж бэртэх, бүр амь насаа алдах эрсдэл үүсэж буй. Иймд төрийн бодлого нь зөвхөн тоо хэмжээг нэмэгдүүлэхэд бус чанарыг сайжруулахад чиглэсэн, жуулчдын эрхийг хамгаалах хууль эрх зүйн орчныг бэхжүүлэх, хяналт шалгалт, хариуцлага тооцох механизмыг шуурхай хэрэгжүүлэх нэн шаардлагатай байна.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын ►

Аялал жуулчлалын хөгжлийн үзэл баримтлал ба кластерууд



► сайд Ч.Ундрэм Азийн Хөгжлийн Банкны “КАРЕК” хөтөлбөрийн дарга Лазиза Сабирова тэргүүтэй төлөөлөгчдийг энэ сарын 8-нд хүлээн авч уулзжээ. Уулзалтаар тус хөтөлбөрийн хүрээнд Төв Азийн 11 орны аялал жуулчлалын салбар дахь хамтын ажиллагааг өргөжүүлэх шинэ санаачилгуудыг хэлэлцсэн байна. “КАРЕК” хөтөлбөрийн хүрээнд манай улс нүүдэлчин аялал жуулчлалын коридор байгуулахаар төлөвлөж байгаа гэдгийг салбарын сайд онцолсон. түүнчлэн Чингис хааны түүхэн газруудаас эхлэлтэй аяллын маршрут гаргах, аялал жуулчлалын салбарыг түшиглэсэн Зүүн бүсийн агаарын төв болох, сургалт, хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэхэд хамтран ажиллах зэрэг санаачилга гаргалаа. АХБ-ны “КАРЕК” хөтөлбөрийн дарга Лазиза Сабирова “Төв Азийн орнуудын хооронд хамтарсан визний хөнгөвчилсөн нөхцөл бий болгох, аялал жуулчлалын урсгалыг нэмэгдүүлэх нь бүс нутгийн эдийн засгийн өсөлтөд чухал ач холбогдолтойг онцоллоо. Мөн ирэх сард Бүгд Найрамдах Киргиз Улсын нийслэл Бишкек хотод болох “КАРЕК”-ийн гишүүн орнуудын сайд нарын уулзалтад Монгол Улсын төлөөлөгчдийг оролцохыг урьж, 2026 онд Монгол Улсад аялал жуулчлалын чиглэлд онцлох арга хэмжээ хамтран


зохион байгуулах санал гаргасан.

“КАРЕК” хөтөлбөрийн хүрээнд Төв Азийн 11 орон 2030 он хүртэл хэрэгжүүлэх аялал жуулчлалын стратегийг батлан хэрэгжүүлж байгаа. Тус стратегийн зорилго нь тогтвортой, аюулгүй, хялбар зорчих нөхцөл бүхий бүс нутгийг бий болгож, торгоны зам дагуу өвөрмөц, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ санал болгож, жилийн дөрвөн улиралд аялал жуулчлалын үйл ажиллагааг тогтвортой хөгжүүлэхэд чиглэж байна. Энэхүү хамтын ажиллагаа нь бүс нутгийн орнуудыг олон улсад танигдсан аялал жуулчлалын бүс нутаг болгон төлөвшүүлэх, иргэдэд хүртээмжтэй эдийн засгийн ашиг бий болгоход чухал түлхэц болох юм.

Уул уурхай дуусдаг баялаг, харин аялал жуулчлал хэзээ ч дуусахгүй баялаг юм. Аялал жуулчлал байгалиа хамгаалдаг, соёлоо түгээдэг, иргэддээ ажлын байр, амьдралын чанарыг дээшлүүлдэг. Монголчууд бид хайрлаж, соёлоо нандигнаж, бусдаас ялгарах ондоошлоо тунхаглаж чадвал аялал жуулчлал ирээдүйд уул уурхайг орлох хамгийн том баялаг болно. Түүнийг зөв ухаж гаргаж чадвал уул уурхайн орлогоос илүү үүрдийн баялаг бүтээх боломж бидэнд бий. ■


Инфо

Монгол Улсад ирсэн гадаад жуулчдын тоо
/мянган хүн, жилээр/




Эх сурвалж: 1212.mn

Аялал жуулчлалын салбараас олсон орлого
/тэрбум ам.доллар/



Эх сурвалж: ССАЖЯ

Монгол Улсад хамгийн их ирсэн орны жуулчид
/улсаар/



Эх сурвалж: 1212.mn

Монгол Улсад ирсэн гадаад жуулчид-бүс нутгаар
/мянган хүн, 2024 он/



Эх сурвалж: ССАЖЯ

НҮБ

Яап ван Хиердэн: Хариуцлагатай аялал жуулчлалыг бодлоготой хэрэгжүүлвэл экосистемд ирэх дарамт буурна

Байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар НҮБ-ын Монгол дахь Суурин зохицуулагч Яап ван Хиердэнтэй ярилцлаа.



-Энэ өдрүүдэд Нэгдсэн Үндэсний Байгууллага 80 жилийн түүхэн ойгоо тэмдэглэж байна. Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилт, цаашдын үйл ажиллагааны чиглэлээр НҮБ-ын Ерөнхий ассемблейгээс гаргасан шийдвэрүүдийн талаар та манай уншигчдад товч мэдээлэл өгнө үү? Тогтвортой хөгжлийн зорилт, ногоон хөгжлийн асуудлууд бол төрийн ажил гэсэн түлхүү ойлголт манайханд байдаг. Та энэ талаар ямар байр суурьтай байна вэ?

-НҮБ-ын 80 жилийн ой бол Монгол Улс болон НҮБ-ын хоорондох хамтын хөгжил дэвшил болон баг бөх хамтын ажиллагааг дүгнэх түүхэн мөч юм. Энэхүү хамтын ажиллагаа маань олон арван жилийн хугацаанд институцүүдийг бэхжүүлж, хүний хөгжлийг урагшлуулж, хүн төрөлхтөн болон дэлхий гарагийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулжээ. 2030 он ойртож буй энэ үед Тогтвортой хөгжлийн зорилгуудыг (ТХЗ) улам шуурхай хэрэгжүүлэх хүсэл эрмэлзлээ НҮБ-ын Ерөнхий ассемблей саяхан дахин нотолсон.

Үүнтэй холбоотой нэн чухал шийдвэрүүдийн тоонд хөгжлийн санхүүжилт, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үйл ажиллагааг сайжруулах, салбар болон улс хоорондын хүртээмжтэй хамтралыг нэмэгдүүлэх багтаж байна. Гол нь ТХЗ-ыг хэрэгжүүлэх нь зөвхөн засгийн газрын үүрэг

Гадаадын жуулчдыг татсанаар уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтөд өртсөн хөдөө нутгуудад тогтвортой амьжиргааг бий болгох боломжтой

хариуцлага биш юм. Үүнд бүхий л талуудын хүчин чармайлт хэрэгтэй бөгөөд иргэд, иргэний байгууллага, боловсролын байгууллага, хувийн хэвшил ихээхэн үүрэг гүйцэтгэнэ. Бизнесийн байгууллагууд нь инновац, хөрөнгө оруулалт, ажил эрхлэлтийг дэмждэг. Тэд бол ногоон технологи нэвтрүүлэх, хүртээмжтэй өсөлтийг дэмжих, хариуцлагатай аялал жуулчлалыг хөгжүүлэх зэргээр тогтвортой хөгжлийн зорилгуудтай нийцсэн өөрчлөлтийг авчрах хүчирхэг үндэс суурь юм. ТХЗ бол зөвхөн хяналтын хуудас бөглөх үйл хэрэг биш. Энэ бол илүү сайхан ирээдүйг бүтээх гарын авлага мөн. Гэхдээ тэрхүү ирээдүйд хүрэх эсэх нь хамтын үүрэг хариуцлага, үйлдлээс шалтгаална.

-Монгол Улсын Засгийн газраас уул уурхайгаас хэт хамааралтай эдийн засгийн төрөлжүүлэх, экспортыг нэмэгдүүлэх хүрээнд аялал жуулчлалыг тэргүүлэх салбар гэж үзэж, бодлого хөтөлбөрөө чиглүүлж байгаа. Та үүнтэй санал нэгдэх үү?

-Тийм ээ, санал нийлж байна. ДНБ-ий 30 орчим хувь, экспортын 94 хувь, улсын төсвийн 33 хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 79 хувийг бүрдүүлдэг уул уурхайн салбараас Монголын эдийн засаг ихээхэн хамаардаг. Тиймээс урт хугацаанд тогтвортой хөгжихийн тулд эдийн засгаа төрөлжүүлэх нь нэн чухал юм. Үйлчилгээний ►

► салбар, нэн ялангуяа аялал жуулчлал ихээхэн ирээдүйтэй харагдаж байна. Монголын өвөрмөц байгаль, нүүдэлчин өв уламжлал, биологийн баялаг төрөл зүйл нь эко аялал жуулчлал, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх нэн таатай суурь болж чадна. Гадаадын жуулчдыг татсанаар Монгол Улс үйлчилгээний салбараа өргөжүүлэн тэлэхээс гадна хөдөө орон нутагт, тэр дундаа уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтөд өртсөн нутгуудад тогтвортой амьжиргааг бий болгох боломжтой юм.

-Энэ жилийн “ITM Mongolia 2025” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнг “Тогтвортой аялал жуулчлал-Төв Ази” сэдвийн дор зохион байгуулж байгаа. Аялал жуулчлалын салбарын тогтвортой хөгжлийг хангах, бүс нутгийн эдийн засгийн интеграцийг нэмэгдүүлэх чиглэлээр Монголын аялал жуулчлалын холбоо санаачилга гаргаж энэхүү үзэсгэлэнг зохион байгуулж байна. Хувийн хэвшлийн энэхүү санаачилгыг та бүхэн хэрхэн хүлээн авч байгаа вэ?

-“Тогтвортой аялал жуулчлал-Төв Ази” сэдвийн хүрээнд ITM Mongolia 2025 арга хэмжээг зохион байгуулж байгаа Монголын Аялал жуулчлалын холбоонд баяр хүргэе. Тогтвортой хөгжлийг бий болгоход хувийн хэвшил тэргүүлэгч үүрэг гүйцэтгэж буйн нэг тод жишээ нь энэхүү арга хэмжээ болж байна. НҮБ-ын Даян дэлхийн гэрээ, НҮБ-ын Бизнес ба Хүний Эрхийн Удирдах Зарчмууд зэрэг санаачилгаар дамжуулж НҮБ бизнесүүдтэй идэвхтэй хамтран ажилладаг юм. Жишээлбэл, байнгын ажлын байраар хангах, хүртээмжтэй бизнесийн арга барил хэрэгжүүлэх зэргээр ядуурлыг устгах ТХЗ 1-ийг хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн үүрэг роль нэн чухал. Хариуцлагатай аялал жуулчлалыг бодлоготой хэрэгжүүлвэл экосистемд ирэх дарамт буурч, орон нутгийн эдийн засгийг дэмжиж, байгаль орчны хамгааллыг сайжруулах бүрэн боломжтой. Энэ нь хүн төрөлхтөн, байгалийн аль алинд ач тустай гэдэг нь гарцаагүй.

-Хөгжлийн стратеги, бодлогоо бид зөв төлөвлөж, удирдахгүй бол хог хаягдал, орчны бохирдол зэрэг сөрөг асуудал гардаг. Тиймээс байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд гол анхаарах асуудлуудыг юу гэж үзж байна вэ? Энэ чиглэлд НҮБ хэрхэн хамтран ажиллах боломжтой вэ?

-Хог хаягдал, бохирдол, экосистемийн доройтол

Хариуцлагатай аялал нь хариуцлагатай аялагчаас эхэлдэг

зэрэг таагүй үр дагавраас зайлсхийхийн тулд тогтвортой аялал жуулчлалыг маш зөв төлөвлөж, хэрэгжүүлэх хэрэгтэй. Эдгээрээс хамгийн чухал нь:

Байгаль орчныг хамгаалах: Бүсчлэл, хог хаягдлын менежмент, нөлөөлөл багатай дэд бүтэц зэргээр дамжуулж эмзэг байгаль орчин, биологийн олон янз байдлыг хамгаалах.

Иргэдийн оролцоо: Аялал жуулчлалаас орон нутгийн иргэд эдийн засаг болон соёлын хувьд ашиг шим хүртдэг байх.

Мэдлэгжүүлэх: Хариуцлагатай аялах зан үйл болон байгаль орчинд бага нөлөө үзүүлэх соёлыг дэмжин сурталчлах.

НҮБ техникийн тусламж, бодлогын зөвлөгөө, чадавхыг сайжруулах замаар Монгол Улсыг дэмжиж ажилладаг. Аялал жуулчлалын төлөвлөлтөд тогтвортой хөгжлийг багтаах, эко аялал жуулчлал, орон нутагт тулгуурласан аялал жуулчлал зэрэг загварыг хөгжүүлэхэд туслахын тулд бид үндэсний болон орон нутгийн хэмжээний оролцогч талуудтай нягт хамтран ажиллаж байна.

-Байгальд ээлтэй, ногоон технологийг нэвтрүүлэх нь аж ахуйн нэгжүүдэд өндөр өртөгтэй тусдаг. Нөгөө талдаа санхүүгийн зах зээл дээр ногоон санхүүжилтийн хэмжээ ихсэж байна. Тэгвэл санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ногоон хөрөнгө оруулалтыг дэмжих олон улсын сайн жишиг, оновчтой механизм юу байна вэ? Монголд нэвтрүүлэх боломж бий юу?

-Ногоон технологийг ашиглахад эхэндээ хөрөнгө оруулалт, зардал их шаарддаг ч олон улсын туршлагаас харахад санхүүгийн зорилтот механизмууд нь хөрөнгө оруулалтын шинэ боломжуудыг нээж, санхүүгийн хүртээмжийн сайжруулж эхэлсэн. Энэ талын сайн жишээнүүдээс дурдвал:

Ногоон ангиллын тогтолцоо: Санхүүжилт авах боломжтой төслийг тодорхойлоход нь санхүүгийн байгууллагуудад туслах зорилгоор өөрийн гэсэн ногоон ангиллын тогтолцоо зэрэг ангиллын тодорхой системийг бий болгох.

Хосолмол санхүүгийн загварууд: Концесс, баталгаа зэргийг ашиглах, эрсдэлийг бууруулахын тулд төрийн болон хувийн хөрөнгийг хослуулан ашиглах.

Ногоон бонд, тогтвортой хөгжилтэй холбоотой зээл: Санхүүгийн шалгуурыг байгаль орчны гүйцэтгэлтэй холбохын зэрэгцээ хөрөнгө татан төвлөрүүлэх. ►

► Монгол Улс эдгээр чиглэлд ихээхэн ахиц дэвшил гаргаж байна. Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг, Ногоон ангиллын тогтолцоо болон Монголын тогтвортой санхүүжилтийн холбооны ажлууд нь тун сайн суурь болж эхэлсэн. Олон улсын тусламж дэмжлэг, дэлхийн стандартуудтай нийцүүлэх замаар Монгол Улс ногоон санхүүжилтээ улам нэмэгдүүлж, тогтвортой хөрөнгө оруулалтаас хүртэх боломжтой. Ялангуяа байгаль орчны болон эдийн засгийн үр ашиг бүхий хариуцлагатай аялал жуулчлалд энэ нь бүр их хамаатай.

-Тогтвортой хөгжлийн чиглэлд орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх гэж бий. Цөлжилт, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой уламжлалт аж ахуйгаас гадна малчдын орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх шаардлага гарч байна. Аялал жуулчлал шийдэл нь байх боломжтой юу?

-Тийм ээ, боломжтой. Хэрэв зөв бодлоготой хэрэгжүүлэх юм бол аялал жуулчлал нь Монголын соёлын өв, гайхамшигт байгалийг улам үнэ цэнтэй болгох орлогын маш боломжийн эх үүсвэр болж чадна. Орон нутагт түшиглэсэн аялал жуулчлал нь уламжлал соёлоо сурталчлах, жуулчид хүлээж авах, газар нутгаа доройтуулалгүй орлого олох зэргээр малчид, орон нутгийн иргэдийг дэмжих маш зөв зүйтэй арга юм. Газарчилж аялуулах, гэртээ жуулчин хүлээж авах, эко аялал жуулчлал зохион байгуулах зэргээр хариуцлагатай аялал жуулчлалыг дэмжих замаар Монгол Улс бэлчээрийн даац хэтрэлт, хөрсний доройтол зэргээс үүдэж буй ихээхэн дарамтыг бууруулж чадна. Хөгжлийн хөтөлбөрүүд хэрэгжүүлэх, чадавхыг дэмжих, орон нутгийн иргэд, байгууллагыг тогтвортой жуулчлалын зах зээлтэй холбох зэргээр НҮБ эдгээр хүчин чармайлтыг дэмжин ажиллаж байна.

-Хариуцлагатай аялал, аялагчийн талаар ярих нь зүйтэй байх. Зөв дадал, зуршлыг хэвшүүлэх, түгээх, сурталчлах зэргээр иргэдэд чиглэсэн ямар ажлуудыг аль түвшинд хийвэл үр дүнтэй вэ?

-Хариуцлагатай аялал нь хариуцлагатай аялагчаас эхэлдэг. Олон нийтэд мэдлэг мэдээлэл олгох кампанит ажлууд, зан авирыг өөрчлөх санаачилга зэрэг нь байгаль, соёл, орон нутгийг хүндлэх сэтгэлийг суулгахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Дараах аргуудыг хэрэгжүүлбэл тун үр дүнтэй байдаг.

Үндэсний хэмжээний кампанит ажил: Хэвлэл



мэдээлэл, сургууль, олон нийтийг хамарсан арга хэмжээ зэргээр дамжуулан хариуцлагатай аялал жуулчлалыг сурталчлах.

Орон нутгийн оролцоо: Хөтөч, хост айл, орон нутгийн удирдлагуудад тогтвортой аялал жуулчлалын практикийг бий болгох, хэрэгжүүлэх арга замуудыг таниулах.

Дижитал платформууд: Байгальд ул мөр үлдээхгүй аялах талаарх зөвлөгөө, түүх, зааврыг нийгмийн сүлжээ болон апп ашиглах түгээх.

Олон улсын тэргүүн туршлагаар хангах, хамтын ажиллагааг дэмжих, ялгаатай оролцогч нарт зориулсан мессежийг бий болгох зэргээр НҮБ эдгээр санаачилгыг дэмжиж ажилладаг юм.

-ЮНЕСКО “Рио Тинто” Монгол компанийн дэмжлэгээр Өмнөговь аймагт Геопарк байгуулах төслийг эхлүүлсэн. Энэ төслийн ач холбогдлын ►

► талаар мэдээлэл өгнө үү?

-“Рио Тинто” компанитай хамтран хэрэгжүүлж буй “ЮНЕСКО-гийн соёлын болон геологийн өвд тулгуурлан Монгол Улсад тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нь” төсөл бол маш ач холбогдолтой санаачилга юм. Уг төсөл нь Монгол Улсын соёлын болон геологийн өвд тулгуурлан Ковид-19 цар тахлын дараа аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, дэмжихэд чиглэж байна. Монгол Улсад ЮНЕСКО-гийн Олон улсын геопаркт багтсан газар байхгүй. Харин уг төсөл нь ийм газрыг бий болгоход зориулж чадавхийг нэмэгдүүлэх, олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой юм. Геопаркууд нь тогтвортой хөгжлийг дэмжиж, геологийн өвийг хадгалж, орон нутгийн эдийн засгийг хөгжүүлдэг. Үүний зэрэгцээ боловсрол, уур амьсгалын дасан зохицох чадвар, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлж байдаг юм. Геопарк нь байгаль хамгаалал, орон нутгийн хөгжил, Монголын өвөрмөц ялгарлыг сурталчлахад аялал жуулчлал ямар үүрэг гүйцэтгэж болох вэ гэдгийг харуулсан бэлэн загвар болох юм.

-Хувийн хэвшлийн томоохон аж ахуйн нэгжүүдийн зүгээс энэхүү геопарк шиг байгаль хамгаалал, аялал жуулчлалын хөгжлийн чиглэлээр санал, санаачилга гаргавал НҮБ-аас дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах боломжтой юу?

-Тийм ээ, тогтвортой хөгжлийн зорилгуудтай нийцсэн хувийн хэвшлийн аливаа шинэлэг санаа саналыг НҮБ дуртайяа дэмжинэ. Учир нь инновац бий болгох, технологийг хөгжүүлэх, дэлхийн хэмжээний сорилттой тэмцэх эх үүсвэрийг бий болгож ашиглахад бизнесүүд чухал үүрэг гүйцэтгэдэг гэж НҮБ үздэг. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг тухайн улсын хөгжлийн бодлогуудтай уялдуулахын тулд бид Засгийн газруудтай нягт хамтран ажиллахын зэрэгцээ тогтвортой хөгжлийг бизнесийн үндсэн үйл ажиллагаандаа шингээхэд нь компаниудад туслахыг зорьж байна. Үүний нэг тод жишээ бол НҮБ-ын Геопарк төсөл юм. Уг төсөл нь төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны нөлөөг тод томруун харуулж байгаа гэж бодож байна. Байгаль орчны хамгаалал, тогтвортой аялал жуулчлал, хүртээмжтэй өсөлтийг дэмжсэн аливаа хамтын ажиллагаанд бид үргэлж нээлттэй байдаг.

-Ирэх жил “СОP17” олон улсын хурлыг Монгол Улс зохион байгуулах гэж байна.

СОP17-гын үеэр Монгол Улс эко аялал жуулчлалын гол төв гэдгээ дэлхийд харуулах таатай боломж

Дэлхийн 170 гаруй улсын төрийн тэргүүн, өндөр дээд хэмжээний албан тушаалтнууд, 10 гаруй мянган хүн оролцоно. Үүнээс гадна эдгээр хүмүүсийг дагаад олон улсын хэвлэл мэдээллийн агнетлагууд ирнэ. “СОP17”-г Монгол Улс зохион байгуулах нь ямар ач холбогдолтой вэ? Хурлын бэлтгэл ажлын үеэр бид юун дээр илүү анхаарах хэрэгтэй вэ?

-СОP17 олон улсын хурлыг зохион байгуулах нь Монгол Улсын хувьд түүхэн боломж юм. Уг арга хэмжээ Монгол Улсыг дэлхийн уур амьсгалын хэлэлцүүлгийн төвд авчирч, тогтвортой хөгжил, газрын доройтлыг нөхөн сэргээх чиглэлд манлайлж байгааг харуулах юм. Төрийн тэргүүн, өндөр дээд түвшний албаны хүмүүс, олон улсын хэвлэл мэдээлэл зэрэг нийт 7000 гаруй зочин хүрэлцэн ирнэ. Энэ бол хөрөнгө оруулалт татах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийг тэсвэрлэх, газрын доройтлыг сэргээх чиглэлд Монгол Улсын дуу хоолойг хүргэх арга хэмжээ юм. Энэхүү арга хэмжээний бэлтгэлд дараах зүйлс багтаж байна.

Дэд бүтэц, логистик: Арга хэмжээг саадгүй явуулах, хүртээмжийг хангах.

Бодлого, мэдээлэл: Монгол Улсын уур амьсгалын тэргүүлэх чиглэлүүд болон ололт амжилтыг тодорхой мэдээлэх.

Оролцогч талуудын оролцоо: Иргэний нийгэм, залуучууд, хувийн хэвшлийг “СОP17”-ийн бэлтгэл ажил болон үлдээх өвд багтаах.

Тогтвортой аялал жуулчлал нь уур амьсгалын зорилгуудыг дэмжиж, байгалийг хамгаалж, иргэдийг чадавхжуулахад чухал учраас хариуцлагатай аялал жуулчлал нь уг арга хэмжээний нэг гол сэдэв байх боломжтой. Дэлхийн өнцөг булан бүрээс олон мянган зочин төлөөлөгч ирэх учраас эко аялал жуулчлалын гол төв гэдгээ харуулах таатай боломж энэ удаад Монгол Улсад гарч ирж байна. Аялал жуулчлалын оновчтой зөв багцийг гаргаснаар гадаадын зочид танай улсын байгалийн болон соёлын баялаг өвийг өөрийн биеэр мэдрэх боломжтой болно. Үүнд бэлдэхийн тулд хуванцар хог хаягдлыг цэвэрлэх кампанит ажил, зам харгуйг засаж янзлах зэрэг ажлыг хийх ёстой болов уу. Мөн хогийн цэгийн зөв оновчтой менежмент нь салхиар хийсэж ирэх хог зэрэг бохирдлоос сэргийлэх, Монголын онгон дагшин байгалийг хамгаалахад тун чухал гэж бодож байна. ■

Монголын аялал жуулчлалын холбоо

Тогтвортой аялал жуулчлалын манлайлал



Аялал жуулчлалын салбарын маань жил бүрийн нэгэн чухал үйл явдал “International Tourism Mart-2025” уламжлал ёсоор 26 дахь удаагаа Улаанбаатар хотноо энэ сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулагдаж байна. Энэхүү арга хэмжээгээр Монголын аялал жуулчлалын салбар өмнө жилийнхээ алдаа оноо, амжилт ололтыг дүгнэн хэлэлцэх юм. Түүнчлэн ирэх он жилүүдэд хэрэгжүүлэх шинэ санаа оноо, бүтээгдэхүүн үйлчилгээгээ дэлгэн танилцуулах, интеграци хөгжүүлэлтийг хэлэлцэх, хүндрэл бэрхшээлийг даван туулах, харилцан суралцаж, хамтын ажиллагаагаа илүү мэргэжлийн, хариуцлагатай чиглэлээр оновчтой бодлого, төлөвлөлтэйгээр ажиллах боломж нөхцөлийг хангах салбарын нийт оролцогчид, үйлчлүүлэгч, түншүүдийн төвлөрсөн уулзалт платформ юм.

Энэ жилийн онцлог

Монгол Улсын аялал жуулчлалын салбар нь зөвхөн үндэсний эдийн засаг, соёл, байгаль хамгааллын олон талт эерэг өгөөж, тулхтай түншлэлийг бий болгох стратегийн чиглэл төдийгүй, монголчуудын бүтээсэн их түүх соёлын үр хөврөл болсон Төв Азийн нүүдэлчдийн бүтээсэн өвөрмөц онцлог ахуй, аж амьдрал, технологийн орон зайд өөрийн гэсэн өвөрмөц аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг тодорхойлж дэлхийн зах зээлд хөгжүүлж, нэрийн хуудсаа тамгалж явна. Тиймээс ч манай улстөдийгүй,

Өнгөрсөн онд 1.4 тэрбум жуулчин дэлхий даяар аялжээ

Төв Азийн улс орнууд буюу бидний түүхийн нэгэн хэсэг болсон улс орнууд маань бүгд өнөөг хүртэл Гэр хэлбэрийн нүүдлийн аяллыг дэлхий дахинаа сурталчлан таниулж ялгарахын хамт, цаг үедээ нийцсэн шинэ инноваци бүхий хөгжүүлэлтийг эрэн хайж, харилцан суралцах, бүтээгдэхүүн үйлчилгээ, хүний нөөц, аяллын техник хангамж, маркетинг, борлуулалтын өгөөжийг нэмэгдүүлэх зайлшгүй оролдлого, хайгуул дунд ажиллаж байна.

Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал

Ковид цар тахлын үед хамгийн хүчтэй нэрвэгдэж, уналтад орсон аялал жуулчлалын салбар эдүгээ нэн эрчимтэйгээр эргэн ирж, сэргэж буй нь өнгөрсөн онд дэлхий даяар аялсан хүмүүсийн тоо болох 1,4 тэрбум аялагч Ковидын өмнөх дээд амжилтдаа дүйцэж, жуулчид 1,9 их наяд ам.долларыг аялалдаа зарцуулсан байна. Эдгээр үзүүлэлт 2025 онд 3-5% өсөлттэйгээр нэмэгдэж байгаа. Манай улс 2024 онд 809 000 орчим гадны зорчигчдыг хүлээн авч, 1.6 сая орчим ам.долларыг энэ салбараас ДНБ-д үлдээсэн нь хэдийнээ өмнөх жилүүдийн статистикаас илүү гарч, салбарын гүйцэтгэл 60 илүү хувьтай явжээ. Дотоодын аялал ч мөн идэвхжиж, 1.6 сая гаруй аялал бүртгэгдсэн байгаа нь манай дотоод аялал үндэсний аялал жуулчлалын хөгжилд даацтай нөлөөлж байгааг анхаарууштай. Эдгээр тоон үзүүлэлтийн цаана чанар, бизнесийн шууд өгөөж, маржин, аялал жуулчлалын бизнес эрхлэх ээлтэй, аюулгүй орчны асуудлыг бид эдүгээ нягтлан тооцох нь чухал. Импортын аялал жуулчлал буюу аутбаунд чиглэл хурдтайгаар өсч, 3,4 сая монголчуудаа гадаад улсууд руу аялуулж буй нь аялал жуулчлалын салбарын экспорт-импортын тэнцлийн төдийгүй нийгэм-эдийн засгийн анхаарууштай үзэгдэл мөн. Салбарын хэмжээнд нийт 80 гаруй мянган ажилтан албан хаагч улирлын хийгээд улирлын бус цагт ажилладаг хэмээдэг ч бидний өмнө тулгарч буй нэгэн сорилт бол чадварлаг, мэргэжлийн хүний нөөцийн дутагдал, сургалт, давтан сургалтын цогц асуудал байгаа. ▶



► Дэлхий нийтээрээ унаган байгалийг шүтэж эрэлхийлсэн, соёлын язгуур өв, бодитой уламжлалт ахуй туршлагыг мэдэрч суралцах, цэнэгжих, алжаал тайлахын хамт орчин цагийн техник технологи, хиймэл оюун ухаан, дижитал ололт амжилтад тулгуурласан аялал жуулчлал, амралт, гадагш зорих чиглэлийн цоо шинэ эрэлт нийлүүлэлт дор манай салбарын өрсөлдөөн, инноваци, чиг хандлага тодорхойлогдож байна. Монгол Улс ийм эрэлт хэрэгцээг хангах хамгийн онцгой боломж, язгуур нөөц, нууцлагдмал соронзон хүчийг агуулсан дэлхийн жуулчдын нэгэн өвөрмөц аяллын газар.

Гэсэн хэдий ч эдийн засгийн бодит эргэлтэнд орж чаддаггүй нөөц, байгаль түүх соёлын үзэсгэлэн төдийгөөр аялал жуулчлалын салбар тодорхойлогдож чадахгүй, харин ч стратегийн удирдлага, мэргэжлийн чанар, хариуцлагатай өсөлт, бизнесийн бодит өгөөж, оновчтой түншлэл дээр үндэслэгдсэн хувийн хэвшлийн манлайлал гүйцэтгэлийн дагуу аялал жуулчлалын салбар хөгжин цэцгэлдэг. Ингэхдээ төрийн оновчтой хийгээд тогтвортой дэмжлэг, хамтын ажиллагаанаас салбарын хувийн хэвшлийн бодит гүйцэтгэл, үр дүн илэрхийлэгддэг нь дэлхийн жишиг бөгөөд бидэнд ярилцах нэгэн асуудал мөн.

Дэлхийн Эдийн Засгийн Форумас гаргадаг “Аялал Жуулчлалын Хөгжлийн Индекс” (Travel Tourism Development Index, 2024)-ийн 2024 оны байдлаар Монгол Улс нь 119 орноос 85-р байрт орж буурсан цаад шалтгаан, анхаарах чиглэлүүдийг бид тухайлан хэлэлцэж шийдэл, гаргалгааг олох ёстой.

Эрэлт ба чадавхийн уялдаа

Манай улсын экспортын чиглэлийн аялал жуулчлалын (inbound tourism) уламжлалт эх үүсвэрийн зах зээл болсон хоёр хөрш гүрнүүд, БНСУ, Япон, Европ болон Хойд Америкийн орнуудын аялагчдын сонирхол, эрэлт хэрэгцээг цаашид баттай сайжруулан үргэлжлүүлэх, мөн уламжлалт бус улс орнуудаас ирэх жуулчдын тоо, хэлбэр, аяллын эрэлтэнд дүйцэхүйц бүтээгдэхүүн үйлчилгээг жуулчдын сегмент бүрээр нарийвчлан судалж, бүс нутгийн интеграци, аяллын чиг хандлагатай уялдуулсан шинэчлэлийг явуулах зүй ёсны шаардлага бидэнд тулгарч байна. Аяллын нийлүүлэлтийн сүлжээ, бүтээгдэхүүний чанар, үйлчилгээний түвшин, бизнесээ тогтвортой, баттай явуулах аюулгүй байдал, тав тух, жишиг удирдамж-стандарт

Дотоодын аялал идэвхжиж 1.6 сая гаруй аялал бүртгэгдсэн

зэрэг асуудал тодорхой ойлгомжтой, мэргэжлийн бодлого, акцыг явуулж, олон улсын түвшинд хөл нийлэн шилжих гарцаагүй цаг үе ирснийг ч бид ухамсарлаж, ажиллахаас өөр аргагүй болжээ.

Аялал жуулчлалын салбарт жижиг, стартап компаниудын оролцоо нэн чухал, органик хөгжлийн суурийг бүрдүүлэгч болохын хамт Үндэсний томоохон хувийн хэвшлийг хөхүүлэн манлайлуулах, олон улс бүс нутгийн хэмжээний тоглогчдыг төрүүлэх соёл-бодлогыг мөн хэрэгжүүлэх шаардлагатай. Хувийн хэвшил бизнесээ явуулахад санхүү татварын бодлого, хүний нөөц, хөрөнгө оруулалт зэрэг олон чиглэл дээр хууль эрхзүй, бодлогын тууштай шинэчлэл дэмжлэг, уян хатан, мэдрэмжтэй алхмууд илтэд үгүйлэгдэж байна. Аялал жуулчлалын салбарын дэд бүтэц, хүний нөөц, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, үнийн бүтэц, дижитал маркетингийн чадавхийг хувьсан өөрчлөгдөж буй эрэлттэйгээ уялдуулахаас өөр аргагүй байна.

Дэлхийн хүлээлт–Монголын хариуцлага

Байгаль орчноо хамгаалдаг, соёлоо хүндэлдэг, орон нутгийн иргэдэд өгөөжтэй, ногоон хөрөнгө оруулалтыг баталгаажуулдаг тогтвортой аялал жуулчлалыг дэлхий нийтийн үзэл баримтлал хэмээн нийтээрээ үзэж байна. Тэр хирээрээ салбарын тооны үзүүлэлтийн ар дахь бодит өгөөж, хувийн хэвшлийн тогтвортой баттай өсөлт, өрсөлдөх чадвар, хэрэглэгчээс хүсэмжлэх чанартай, үнэ цэнтэй, шинэлэг үйлчилгээ улам бүр хөгжлийн трэнд үзүүлэлт болжээ. Монгол Улсаас дэлхий нийтээр хүлээн харж буй чиглэл нь нүүдэлчдийн өвөрмөц онцлог ахуй дээр тулгуурласан байгаль соёлд ээлтэй аяллын шинэлэг хэлбэр, чиглэлүүд төдийгүй тогтвортой аялал жуулчлалын зүй ёсны манлайлал, хэрэгжилт билээ. Монголчуудын найрсаг зочломтгой байдал, манай өвөрмөц-жинхэнэ язгуур ахуйг өнөө цагийн залуус, идэвхтэй аялагчид, үнэ цэнтэй хэрэглэгчдийн өвөрмөц онцлог эрэлтийн дагуу сонирхолтой, давтамжтай, борлогдохуйц болгон хөгжүүлэх, сайжруулан сонирхуулах бизнесийн коуч програм, ашиг маржин дээр суурилсан бизнесийн түншлэл, үл өөрчлөгдөн солигдох төрийн бодлого дэм, эрсдэлийг сагааруулах тогтвортой бодлогуудаар тэнцвэржүүлсэн тэсвэртэй аялал жуулчлалыг (resilience in tourism) бүтээх нь бидний хариуцлага гэж үзнэ. ■

Хүннү Эйр

П.Мөнхжаргал: Төв Азийг маш ирээдүйтэй зах зээл гэж харж байгаа



“Хүннү Эйр” ХХК-ийн Гүйцэтгэх захирал П.Мөнхжаргалтай ярилцлаа.

-П.Мөнхжаргал захирлыг агаарын тээврийн салбарт төр, хувийн хэвшлийн аль алинд нь ажилласан, туршлагатай удирдлагуудын нэг гэдгээр нь андахгүй, та эхлээд манай уншигчдад өөрийнхөө салбарт ажилласан туршлагын талаар танилцуулаач?

-Миний хувьд иргэний нисэхийн салбарт 34 жил ажиллалаа. Мэдээж төр, хувийн, Засгийн газрын тохируулагч агентлаг гээд аль алинд нь л ажилласан. Өнгөрсөн жилүүдэд туршлага хуримтлуулалгүй яхав. Өөрийн сурсан мэдсэн, хуримтлуулсан туршлагаараа салбартаа зүтгэж, зорьсон ажлынхаа ард гарахыг хичээж ажиллаж байна даа.

-“Хүннү Эйр” компани сүүлийн үед олон шинэ чиглэлд нислэгүүд нэмж, үйл ажиллагаагаа өргөжүүлж байна. Танай компанийн тээврийн үйлчилгээ, ойрын зорилтын талаар сонирхвол?

-Бидний хувьд нислэгүүдийнхээ тоог нэмж, үйл ажиллагаагаа өргөжүүлэх тал дээр ажиллаж байна. Бидний эхний зорилт Дундад Азийнхаа нислэгийг тоог нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа. Өнгөрсөн хугацаанд Манжуурыг Улаанбаатартай холбож байнгын тогтмол явдаг нислэгийн цэг болгосон. Манай ажилчид маш их хичээсэн. Энэ бол сайн жишиг болсон. Мөн Улаанбаатарыг Казакстаны Алматы хоттой холбосон. Алматы бол Казакстаны

Солонгос-Мөрөнгийн шууд нислэгийн тоог нэмэгдүүлэхээс гадна Солонгосоос Даланзадгад руу нислэг эхлүүлэх төлөвлөгөөтэй байна

бизнесийн төв. Бид иймэрхүү маягаар нислэгийн шинэ цэгүүдийг бий болгохоор ажиллаж байна. Ирэх зун Алматагийн нислэгийн тоог нэлээд нэмнэ. Дээрээс нь Улаанбаатар Ташкентийн чиглэлийн нислэгийг эхлүүлэх талаар эрчимтэй хөөцөлдөж байгаа. Шинээр нислэгийн цэг нээх бол хялбар ажил биш. Хөрөнгө оруулалт, хууль эрх зүйгээс эхлээд олон асуудал тулгарна. Тэр бүгдийг даван туулах ёстой. Бид Энэтхэг рүү тогтмол нислэг хийхээр төлөвлөж байгаа. Олон нислэг нэмэх төлөвлөгөө байгаа учраас үе шаттайгаар төлөвлөөд явж байна. Ер нь бол бидний хамгийн том зах зээл БНХАУ шүү дээ.

-Энэ жил аялал жуулчлал-агаарын тээврийн салбарт түүхэн нэг ажил болсон нь Хүннү Эйр Чандмань трэйвлз компаниуд хамтарч Солонгосоос-Хөвсгөл аймгийн Мөрөн хот руу шууд нислэгийг үйлдлээ. Улаанбаатараас хамааралтай олон улсын нислэгийг аймгуудад задлах боломжтойг харуулсан чухал ажил болсон. Цаашид энэ ажил үргэлжлэх, өөр аймгууд чиглэлүүд нэмэгдэх боломж байна уу?

-Тиймээ. Энэ талаар үргэлжлэн ажиллана. Ирэх 2026 оны зун Солонгос-Мөрөнгийн шууд нислэгийн тоогоо нэмэгдүүлэхээс гадна Солонгосоос Даланзадгад руу нислэг эхлүүлэх төлөвлөгөөтэй байна. Энэ ондоо багтаагаад УБ-Ховд-Урумчийн нислэгийг эхлүүлэхээр ажиллаж байна. Энэ мэтчилэн хийх ажил их л байна.

-Агаарын тээвэр их хэмжээний хөрөнгө оруулалт шаарддаг салбар. Хувийн хэвшлийн компанийн хувьд энэ салбарт өрсөлдөх амаргүй байх?

-Мэдээж агаарын тээврийн салбарт хөрөнгө оруулалт маш их шаардана. Амар биш. Агаарын тээврийн салбарт хөрөнгө оруулалт хийх талаар төрөөс тодорхой дэмжлэг, бодлого байдаг бол үр өгөөж нь өндөр шүү дээ. Монгол Улсын газар зүйн байрлал хоёр их гүрний дунд оршдог. Агаарын тээврээ олигтойхон шиг хөгжүүлбэл хүнд байдлуудаас гарах гарц харагдаад байдаг юм. Гэхдээ тийм ч амар биш л дээ. Энэ тал дээр холбогдох салбарынхан нийлж, хамтарч ажиллах ёстой гэж ойлгож байгаа.

-Аялал жуулчлалын салбарын хөгжил шууд ▶

► агаарын тээврээс хамааралтай. Зарим улсын жишээнээс харахад жуулчдаа нэмэхийн тулд нислэгийн татаас, нисэх буудлын татвар хөнгөлөлт зэрэг дэмжлэг байгаад байх шиг. Манайд энэ төрлийн зохицуулалт дэмжлэг бий юу?

-Ер нь нислэгийн татаас хөнгөлөлт байх ёстой. Ялангуяа манай өмнөд хөрш БНХАУ үүнийг амжилттай хэрэгжүүлдэг. Жижиг, том гэлтгүй бүх нисэх буудлуудад нислэгийн татаас, нисэх буудлын хөнгөлөлт зэрэг дэмжлэг байдаг. Харин бидэнд ийм дэмжлэг дутагдсан. Ийм дэмжлэгийг үзүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдвэл илүү амжилттай болох байх. “Орон нутгийн нислэгийг НӨАТ-аас чөлөөлөөд өгөөч” гэж олон жил ярьж байна шүү дээ. Бодит ажил болж өгөхгүй л байна. Нислэг нээгдвэл араасаа олон бизнесийг дагуулдаг. Хоёр орны хоорондох шууд тогтмол нислэг бол бусад олон төрлийн бизнесийг дэмжих, гадаадын хөрөнгө оруулалт татах хөшүүрэг юм уу гэж ойлгодог.

-Таны бодлоор Төв Азийн зах зээл Монгол Улсад хэр үр ашигтай гэж харж байна вэ?

-Энэ жилийн “ITM Mongolia”-гийн хувьд “Тогтвортой аялал жуулчлал-Төв Ази” сэдвээр зохион байгуулагдаж байгаа. “Хүннү Эйр” компани энэ арга хэмжээнд маш идэвхитэй

Шинэ нислэг нээгдвэл араасаа олон бизнесийг дагуулдаг

оролцохоор төлөвлөж байна. Төв Ази цаашдаа аялал жуулчлалын ирээдүйтэй чиглэл болно гэж ойлгож байгаа. Дээрээс нь аялал жуулчлал хурдтай хөгжиж байгаа газар нутаг. Манайх Төв Ази буюу Казахстан, Киргизийн чиглэлд анхны тогтмол нислэгүүд хийсэн. Бид цаашдаа Узбекистаны чиглэлд нислэг нээхээр төлөвлөж байгаа. Япон, Солонгос, Хятадаас ирж байгаа жуулчдыг Монгол болон Төв Азиар хамтад нь багц болгож аялуулах том ирээдүй харагдаж байна. Төв Ази маш ирээдүйтэй зах зээл гэж харж байгаа.

-Шинэ чиглэл нээх, тус чиглэлээ хөгжүүлэхэд төрийн дэмжлэг, хамтын ажиллагаа ямар түвшинд байна вэ?

-Хэрэгтэй байлгүй яахав. Яг үнэндээ шинэ чиглэл олноор нээгдэхгүй байгаагийн нэг гол шалтгаан нь төрийн зүгээс бодит дэмжлэг төдийлөн байхгүй байгаатай шууд холбоотой. Бодлогын зохицуулалт энэ тэр нь хаанаа яаж шийдэгдэх нь ойлгомжгүй л байгаад байна. Хамгийн сайн хийдэг нь БНХАУ-ын жишээ байна шүү дээ. Дэмжлэгийг бол супер хийдэг. Эцсийн дүндээ үүнээсээ маш их үр ашиг олж авч чаддаг. Аялал жуулчлалын компаниуд, агаарын тээврийнхэн болон төр үүн дээр илүү хамтарч ажиллах хэрэгтэй гэж хардаг даа. ■

Гэрэл зурагчин Л.Баяндоржийн “ГАЙХАМШИГТ МОНГОЛ ОРНООР” гэрэл зургийн үзэсгэлэн

Хэзээ: 2025 оны 11 сарын 8-12-нд

Хаана: “Norphei Art Gallery” Bluemon Center, 1 давхар



COP17

Ирээдүйн төлөө нэгдэх цаг-COP17



COP17 арга хэмжээний албан ёсны лого нь Монгол Улсын соёл, уламжлалыг агуулахын сацуу дэлхий нийтийн хамтын ажиллагааны уриалгыг хослуулжээ. Тодруулбал, дүрслэлийн дээд хэсэгт байрлах дугуй хэлбэр нь нарны туяа мэт алсран цацарсан байдалтайгаар Монголын уламжлалт тэнгэр шүтлэгийг илтгэж, мөнх хөх огторгуйг бэлгэднэ. Энэ нь НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Зорилгуудын дүрслэлтэй нийцэж, хүн төрөлхтний өмнө тулгарч буй байгаль орчны сорилтуудын шийдлийг илэрхийлж буй аж. Төв хэсэгт монгол гэрийн хэлбэрийг тодруулан дүрсэлж, оройд нь гэрийн тулгуур болох тооно дүрслэгджээ. Тооно нь хүн ба байгалийн зохицлыг бэлгэдэж нүүдэлчдийн амьдралын ухаан, газар хөрс нь эх орон, өв соёлын тогтвортой байдлыг харуулж буй.

Доод хэсэгт орших гарын дүрс нь байгаль дэлхийдээ энэрэнгүй хандах, хамгаалах, хариуцлагыг бэлгэдэх бөгөөд алганд нь ногоон соёо нахилалж буй нь тэсвэртэй, шинэчлэгдэн сэргэж буй дэлхийг илэрхийлэх юм.

Цөлжилт бол дэлхий нийтийн өмнө тулгараад буй аюулын харанга. Тэр тусмаа Монгол Улс энэ аюулд хамгийн ихээр өртөж буй орнуудын нэг юм. Тодруулбал, манай улсын нийт газар нутгийн 77.8 хувь нь тодорхой зэрэглэл бүхий байдлаар цөлжилтийн аюулд өртсөн гэх судалгаа бий.

Тиймээс Монгол Улс цөлжилттэй тэмцэх дэлхий нийтийн хүч чармайлтад идэвхтэй оролцож, дуу хоолойгоо илэрхийлсээр ирсэн бөгөөд Ерөнхийлөгч У.Хүрэлсүх НҮБ-ын индэр дээр “Монгол Улс тэрбум мод тарина” гэдгээ амалсан. Ийнхүү “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөн, “Цагаан алт” хөтөлбөр, “Хүнсний хувьсгал” болон хөрс-хөдөө аж ахуйг сэргээх

үндэсний хөдөлгөөнөөр дамжин газрын хөрс сэргээх ажлыг тэргүүлэх чиглэл болгоод буй.

Тэгвэл ирэх жил буюу 2026 оны наймдугаар сарын 17-28-ны өдрүүдэд Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын Конвенцын Талуудын бага хурлын 17 дугаар хуралдааныг (COP17) Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод зохион байгуулахаар болсон билээ. Даян дэлхийд ач холбогдолтой тус арга хэмжээнд Конвенцын талууд болох 197 улс орны 8000 гаруй зочид төлөөлөгч, төр засгийн тэргүүн, сайд нараас гадна олон улсын болон шинжлэх ухааны байгууллага, иргэний нийгэм, хувийн хэвшлийн төлөөлөл оролцох юм. Хоёр долоо хоног үргэлжлэх бага хурлын хүрээнд өндөр түвшний арга хэмжээ, тэр дундаа сайд нарын түвшний хэлэлцүүлэг, олон талт оролцогчдын чуулга уулзалт, шинжлэх ухаан ба бодлогын уялдаа, инновац, технологи, санхүүжилтийн шийдлүүдийг хэлэлцэх сэдэвчилсэн форумууд зохион байгуулахаар төлөвлөжээ. Энэхүү бага хурал нь салбар хоорондын үр дүнтэй хамтын ажиллагааг хөгжүүлж, газрын тогтвортой ашиглалт, экосистем болон газрын нөхөн сэргээлт, “Газрын доройтлыг тэглэх зорилт”-ын хэрэгжилтийг ахиулах чухал алхам болох юм.

Анх 1994 онд НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенц (UNCCD) байгуулагдаж, дэлхийн 197 улс болон Европын холбоо нэгдсэн байдаг. Конвенцын дээд удирдах байгууллага болох Талуудад зориулсан бага хурал (COP) анхдугаар чуулганаа 1997 оны аравдугаар сард Италийн Ром хотноо зохион байгуулж байжээ. 2008-2018 онд үйл ажиллагааг эрчимжүүлэх 10 жилийн стратеги төлөвлөгөөний хүрээнд цөлжилт, газрын доройтлыг зогсоох, үүнээс урьдчилан сэргийлэх дэлхий дахины түншлэлийг бий болгох зорилго дэвшүүлсэн байдаг.

2017 оны есдүгээр сард БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ордос хотноо зохион байгуулсан COP13-ын үеэр гишүүн орнууд газрын доройтлын асуудлыг шийдвэрлэх дэлхий нийтийн шинэ төлөвлөгөөг тохиролцсон юм. Цөлжилттэй тэмцэх конвенц нь 2018-2030 онд доройтсон өргөн уудам газрыг сэргээх, 1.3 тэрбум гаруй хүний амьжиргааг дээшлүүлэх, эмзэг бүлгийн хүн амд гангийн нөлөөг бууруулах зэрэгт зорин ажиллаж, газрын доройтлыг тэглэх зорилтыг биелүүлэхэд чиглэж байна. ▶

► Харин өнгөрсөн жил COP16 “Бидний газар нутаг, бидний ирээдүй” уриан дор Саудын Арабын Хаант Улсын Эр-Рияд хотноо болсон юм.

Монгол Улсын тухайд 1996 онд Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын конвенцод нэгдэн орсон байдаг. Талуудын бага хурлыг хоёр жил тутам зохион байгуулдаг бөгөөд 2022 онд болсон 15 дугаар хурлын үеэр 2026 оны бага хурлыг Монгол Улсад зохион байгуулахаар шийдвэрлэсэн юм. Бэлтгэл ажлын хувьд Засгийн газар 2025 оны эхээр Үндэсний хороог байгуулсан. Дэлхийн 197 орныг нэгтгэдэг том хурал учраас бэлтгэл хангах хүрээнд олон ажил амжуулах ёстой. Ямартай ч хурал зохион байгуулах, уулзалт хэлэлцээрүүдийг хийх барилга, байгууламжуудыг барих ажлыг Нийслэлийн ЗДТГ-тай хамтран гүйцэтгэж байгаа бөгөөд төлөвлөсөн суурь дэд бүтцийн бэлтгэл ажил дуусаж байгааг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Багбаатар онцолсон.

COP17 бидэнд юу өгөх вэ

COP17 бол зөвхөн байгаль орчны хурал биш, эдийн засгийн маш чухал боломжоос гадна Ногоон дипломат бодлогыг бэхжүүлэхэд өндөр ач холбогдолтой гэдгийг зохион байгуулагчид онцолж байна. Монголд энэ хурлыг зохион байгуулснаар дэлхийн анхаарлыг конвенцын үндсэн агуулгуудаас гадна малын бэлчээр, усны хомсдол, байгальд ээлтэй дэд бүтэц, зэрлэг амьтан ургамал, хөрс зэрэгт хандуулах ач холбогдолтой юм. Үүний зэрэгцээ олон улсын донор байгууллага, хөгжлийн банкууд, хөрөнгө оруулагчид Монгол руу ирж, нөхөн сэргээлт, усны менежмент, ойжуулалт, ногоон ажлын байр, сэргээгдэх эрчим хүч зэрэг төсөл хөтөлбөрт бодит

COP17 бол манай улсын нэр хүнд төдийгүй, уур амьсгалын хөрөнгө оруулалтыг бодит эдийн засгийн өсөлт болгон хувиргах хаалга болох нь дамжиггүй. Харин бид бэлэн үү

хөрөнгө оруулалт хийх нөхцөл бүрдэнэ. Өмнөх хурлуудын туршлагаас харахад, ийм хэмжээний хурлын дараа дараагийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын урсгалыг эрс нэмэгдүүлдэг байна.

Жишээ нь, 2022 онд Баруун Африкийн Кот-д’Ивуар Улсын Абиджан хотод болсон COP15 хурлын дараа “Great Green Wall” буюу “Агуу ногоон хана” хөтөлбөрийг эрчимжүүлж, 11 улс дамнасан 8,000 км урт ногоон зурвас байгуулан, 350 мянга гаруй ажлын байр шинээр бий болгожээ. Харин түүнээс хойш “Land Degradation Neutrality Fund” хөтөлбөрийн санхүүжилт 1.6 тэрбум ам.долларт хүрч, олон сая га талбайг нөхөн сэргээх бодит ажлууд үргэлжилж буй аж. 2024 онд Саудын Арабын Хаант Улс улс орнуудын ганд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх, сайжруулах, түншлэлийг бэхжүүлэн дэмжих хүрээнд “Тангын түншлэл”-ийг санаачлан 12 тэрбум долларын амлалтыг татаж чаджээ.

Монголын хувьд COP17 амжилттай зохион байгуулснаар олон улсын санхүүжилт татах бодит боломж нээгдэх юм. Тиймээс Монгол Улс энэ боломжийг бодит болгохын тулд COP17-гийн үеэр “Бэлчээрийн тэргүүлэх санаачилга”, “Ус ба газрын шүтэлцээ санаачилга” болон хувийн хэвшлийн салбарын оролцоотой Тогтвортой дэд бүтцийг хөгжүүлэхдээ байгальд суурилсан шийдлүүдийг ашиглахыг уриалах зорилготой санаачилгуудыг боловсруулж байгаа юм байна.

COP17 бол манай улсын нэр хүнд төдийгүй, уур амьсгалын хөрөнгө оруулалтыг бодит эдийн засгийн өсөлт болгон хувиргах хаалга болох нь дамжиггүй. COP17 бол Монголыг дэлхийд таниулах олон улсын түвшний том хурал. Бас эдийн засгаа өндийлгөх боломж. Нэг ёсондоо бид дэлхийн төв болох боломж нээгдэж буй. Гэвч хурлын үеэр зочид, төлөөлөгчдийг буулгах зочид буудал, хот дотор үйлчилгээ үзүүлэх унаа, тээврийн зохицуулалт, үйлдвэр үйлчилгээний салбар үүнд бэлэн үү. COP17 хурал болоход хэдэн сарын хугацаа үлдээд байна. Цөлжилтийг дэлхий нийтээрээ хамтдаа даван туулахаар Монголд 8000 гаруй хүн цуглах нь. Тэд дэлхийд экологи, байгаль дэлхийгээ хайрлахыг тунхаглана, шийдвэр гаргана. Харин дэлхийд Монголыг таниулах COP17-д бид бэлэн үү. ■



Нью жуулчин турс

Д.Наранцэцэг: Манай салбарт болзошгүй эрсдэлээс хамгаалах бодлого дутагдалтай



Аялал жуулчлалын салбарын ууган бөгөөд тэргүүлэх тур оператор компанийн нэг “Нью жуулчин турс” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Наранцэцэгтэй ярилцлаа.

-“Нью жуулчин турс” компани өнөөдөр хэд дэх жилдээ үйл ажиллагаа явуулж байна вэ?

-Манай компани 2002 оны 12 дугаар сард байгуулагдаж аялал жуулчлалын салбарт тасралтгүй 23 жил үйл ажиллагаа явуулж байна. Өнөөдөр бид дэлхийн 30 гаруй орноос жуулчин хүлээн авч аяллын үйлчилгээ үзүүлэхээс гадна монгол жуулчдаа дэлхийн 20 гаруй орон руу аялууулж байна. Бид зочид буудал, жуулчны бааз, олон улсын тээвэр, олон улсын болон дотоодын захиалгат нислэг зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Манай компани АНУ, БНХАУ, Испани зэрэг улсад төлөөлөгчийн газар ажиллуулан аялал, үйлчилгээгээ сурталчилж байна.

-Танай компани дэлхийн хэдэн улсаас жуулчин хүлээж авч, хэдэн улсад аялал зохион байгуулж байгаа вэ?

-Одоогоор дэлхийн 30 гаруй улсын 100 гаруй тур оператор компанитай хамтран ажиллаж гадаад жуулчин хүлээн авч үйлчилж байна. Харин гадаадын 20 гаруй орны 60 хот руу аялал

Гадаадын 20 гаруй орны 60 хот руу аялал зохион байгуулж байна

зохион байгуулж байна.

-Цар тахлын өмнөх болон дараах аялал жуулчлалын салбар болоод жуулчдын чиг хандлага нэлээн өөрчлөгдсөн гэж мэргэжилтнүүд үзэж байгаа. Тэгвэл сүүлийн жилүүдэд Монголыг зорин ирж буй жуулчдын зах зээл, нас, сонирхол хэрхэн өөрчлөгдөж, аль чиглэлүүд тэргүүлэх хандлагатай болж байна вэ?

-Цар тахлын яг дараахан жуулчид ойрын зайны буюу 4-5 цаг дотор нисээд хүрэх чиглэлд илүү их аялах хандлагатай болсон. Үүний нэг илрэл бол манай улсад ирэх Өмнөд Солонгосын жуулчдын тоо огцом өсөж, дөрвөн жил орчим үргэлжилсэн. Харин энэ жилээс Солонгос жуулчдын тоо буурах хандлагатай байна. Мөн дотоодын аялал жуулчлал эрчтэй хөгжиж Монголчууд маань эх орныхоо үзэсгэлэнт газруудаар их аялж байна. Сүүлийн хоёр жилийн хувьд Европ, АНУ зэрэг улсуудаас ирэх тансаг зэрэглэлийн үйлчилгээ авдаг жуулчдын тоо нэмэгдэж байна. Жуулчид олон хүнтэй групп аялал гэхээсээ илүү ганцаарчилсан эсвэл гэр бүлээрээ аялах нь ихэссэн.

-ОХУ-ын геополитикийн асуудал Оросоос жуулчин авдаг улсуудад ихээхэн сөргөөр нөлөөлсөн ч бидэнд давуу тал үүссэн гэж харж байсан. Гэхдээ бид энэ нөхцөлийг ашиглаж чадаж байна уу?

-ОХУ-ын геополитикийн асуудал манай аялал жуулчлалд сөргөөр нөлөөлж байна. Европын маш олон жуулчин Орос, Монгол, Хятад гурван улсыг нийлүүлсэн аяллаар их аялдаг байсан. Мөн Транссибирийн галт тэрэгний аялал бол дэлхийн олон орны жуулчдын мөрөөдлийн аялал байдаг бөгөөд энэ аяллууд энэхүү геополитикийн асуудлын улмаас бүрмөсөн хаагдаад байна.

-Цар тахал, дайн, Өвөр Монголын хямд үнийн өрсөлдөөн гэх мэтчилэн эрсдэлийг урьдчилж тооцох, олон улсын нөхцөл ▶

► байдалд дасан зохицох, даван туулах, зах зээлийн хамгаалалт хийх зэрэг бодлого, стратеги гаргаж, бизнесээ хамгаалдаг, дэмждэг тогтолцоо, бодлого манай улсад ямар нөхцөлтэй байна вэ?

-Манай салбарт маш олон төрлийн эрсдэлд автдаг болохыг цар тахал, дайн зэрэг сүүлийн жилүүдэд болсон үйл явдлууд харууллаа. Харамсалтай нь эдгээр болзошгүй эрсдэлээс хамгаалах бодлого, стратеги манайд дутагдалтай. Цаашдаа эдгээр эрсдэлийг төр, хувийн хэвшлийнхэн хамтран өргөн хүрээтэй судалгаа хийж болзошгүй эрсдэлийг тооцох, аяллын компаниуд эрсдэлийн сантай болох, хариуцлагын болон эрсдэлийн даатгалд хамрагдах, өрсөлдөөний уян хатан бодлого хэрэгжүүлж ажиллах шаардлагатай санагддаг.

-Засгийн газраас аялал жуулчлалыг эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгон хөгжүүлнэ хэмээн сүүлийн жилүүдэд онцгой анхаарч, WELCOME TO MONGOLIA, GO MONGOLIA зэрэг кампанит ажлуудыг хийж, олон улсын хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтрах, гадаадын нэр хүндтэй инфлюүсэрүүдийг Монголд авч ирэх зэрэг ажлыг хийж байна. Эдгээр ажил тус салбарт бизнес эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд үр өгөөжөө шууд өгч чадаж байна уу?

-Манай салбарын түүхэнд Монголоо сурталчилсан хамгийн өргөн хүрээтэй сурталчилгаа болсон. Эдгээр кампанит ажил, олон улсын үзэсгэлэн зэргийн үр дүн шууд харагдахгүй, 3-5 жилийн дараа мэдрэгддэг гэж бодож байна.

-Гадагшаа аялж буй Монголын жуулчдын тоо эрс нэмэгдэж, 2024 онд давтагдсан тоогоор 3,5 саяд хүрсэн үзүүлэлттэй байна. Тэгвэл Монголын жуулчдын чиг хандлагын талаар мэдээлэл өгнө үү. Аль улс руу, ямар аяллыг илүү сонирхож байна вэ?

-Манай компани 2008 оноос хойш монгол жуулчдыг гадаад улс орнууд руу аялуульж байна. Энэ урсгал цар тахлын дараа буюу 2022 оноос эрс өссөн. Монгол жуулчид Зүүн өмнөд Азийн далайн эрэг, арлууд руу аялах илүү сонирхолтой. Мөн албан байгууллагууд шилдэг ажилчдаа гадаад улс орнууд руу аялах эрхээр шагнаж байгаа нь сайшаалтай юм.

-Манай аяллын салбарын хувьд улирлын

Цар тахлаас хойш манай салбарын хүний нөөц хамгийн хэцүү асуудал болсон

хамаарал гол асуудал байдаг. Тэгвэл мэргэжлийн хүний хувьд Өвлийн аяллыг хөгжүүлэх боломжтой гэж үздэг үү? Хэрэв тийм бол ямар асуудлуудыг ойрын хугацаанд шийдвэрлэх шаардлагатай вэ?

-Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилтот зах зээлээ бид зөв тодорхойлж тухайн зах зээлүүддээ зөв сурталчилгаа явуулах шаардлагатай байна. Бусад улс орнуудад бага ачаалалтай үеийн үнэ гэж их ачааллын үеийнхээс нэлээд доогуур байдаг бол манайд энэ үнийн ялгаа тийм мэдэгдэхүйц биш байдаг. Өвлийн аялал жуулчлалыг дэмжих зорилгоор тур оператор, зочид буудал, жуулчны баазуудад татаас, урамшуулал өгөх тогтолцоо, бодлоготой болох, үзвэр үйлчилгээний төрлийг нэмэх зайлшгүй хэрэгтэй байна.

-Сүүлийн үед хүний нөөцийн асуудлыг олон компани хөндөж байна. Танай компанийн хувьд хүний нөөцийн чиглэлд тулгамдаж буй асуудлууд бий юу?

-Цар тахлаас хойш манай салбарын хүний нөөц хамгийн хэцүү асуудал болоод байна. Жуулчны бааз, зочид буудал, хөтөч, жолооч гээд бүхий л ажлын байранд дутагдалтай. Манай компанийн хувьд "Тэрбум тэтгэлэгтэй дадлагын хөтөлбөр"-ийг анхнаас нь дэмжиж жил бүр ерөнхий ивээн тэтгэгчээр оролцсон. Энэ хугацаанд жил бүр 20 орчим оюутныг жуулчны баазууд болон оффистоо ажлаар хангаж хамтран ажилласан бөгөөд эдгээр оюутнаас гурван оюутан шилдэг дадлагажигч оюутнаар шалгарсан нь бидний боловсролын болон аялал жуулчлалын салбарын хүний нөөцөд оруулж байгаа хувь нэмэр гэж бодож байна.

-Сүүлийн үед манай иргэд гадаадад баталгаагүй компаниар аялаад мөнгө санхүү, эрүүл мэндээрээ хохирох үзэгдэл бас ажиглагдах болсон. Тэгвэл аялах гэж буй иргэддээ хандаж, баталгаатай, ая тухтай, аюулгүй аяллыг хэрхэн сонгох талаар зөвлөгөө өгнө үү.

-Цар тахлаас хойш аяллын компаниудын болон цахим хуудасны тоо олноор нэмэгдсэн. Олон жуулчин багагүй хохирол хүлээсэн байсан. Аялагчид маань аяллаа сонгохдоо тухайн компани заавал судлах, аяллын гэрээ байгуулах, аяллын даатгал авахыг зөвлөмөөр байна. Аяллын компани судлахдаа ямар нэг эрсдэл гарвал энэ компани эрсдэл даах хэр чадвартай эсэхийг нь хамгийн түрүүнд мэдэх нь чухал. ■

Бүсчилсэн аялал жуулчлал



Бүсчилсэн хөгжлийн бодлого АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛД



ХЭРЭГНИХ ТӨСЛҮҮД

- Хөвсгөл нуур орчмын аялал жуулчлалын тусгай бүс
- “Төв Азийн түүх соёлын голомт” цогцолбор
- Өндөр гэгээн Занабазарын бүтээн туурвисан соёлын өвд тулгуурласан цогцолбор
- Түүх, соёлын нөөц, буйр нуурыг түшиглэсэн хил орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлэх аялал жуулчлалын тусгай бүс
- “Кино, контент үйлдвэрлэлийн цогцолбор”
- Алтай-хангайн нуруу, Увс нуурын ай сав, их нууруудын экосистемд түшиглэсэн тусгай бүс
- Алтайн нурууны байгаль соёлын өвд түшиглэсэн эко парк
- Дундговь аймгийн Цагаансуварга орчмын палеонтологийн нөөцөд түшиглэсэн аялал жуулчлалын тусгай бүс
- Сүхбаатар аймгийн Дарьганга суманд тахилгат хайрхан үүлс түшиглэсэн байгаль, соёлын өвийн цогцолбор
- “Нүүдэлчин” дэлхийн соёлын наадмын тусгай бүс
- Хөшигийн хөндийн аялал жуулчлалын тусгай бүс

Монгол Улсын Засгийн газар аялал жуулчлал бол бүсүүдийн хөгжлийн тэргүүлэх чиглэл мөн хэмээн тодорхойлсон. Ийнхүү хил орчмын аялал жуулчлал, алтайн үзэсгэлэнт байгаль, нүүдэлчдийн өв соёл, олонястны өвд тулгуурласан олон төрлийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх бодлогыг баримтлан, төсөл хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхээр болсон юм. Гол нь аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг эргэлтэд оруулахдаа байгаль экологид халгүй байх зарчмыг баримталж бүрд аялал жуулчлалын бодлогыг шингээсэн гэдгийг бүсчилсэн хөгжлийн бодлогыг боловсруулсан эрдэмтэн, докторууд онцолж байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны зургаадугаар сарын 05-ны өдрийн 64 дүгээр тогтоолоор “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” батлагдсан. Тус үзэл баримтлалд тусгасан нийт долоон бүсэд аялал жуулчлалыг хэрхэн хөгжүүлэх талаар тусгасан юм. Долоон бүсэд аялал жуулчлалыг хэрхэн хөгжүүлэхийг товчлон хүргэе.

ХОЙД БҮС

БАЙГАЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТӨРӨЛЖСӨН, АЖ ҮЙЛДВЭРИЙН ДЭД БҮС

Хөвсгөл нуур, Сэлэнгэ мөрний сав газрын эко систем, байгаль, түүх, соёлын өвд тулгуурлан аялал жуулчлал, амралт сувилал, хүнд үйлдвэрлэлээр төрөлжсөн “Аялал жуулчлал, аж үйлдвэрлэлийн хөгжлийн бүс” болно.

СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУСГАЙ БҮС, ГЕОПАРК

Бүсийн байгаль, газарзүйн онцлогийг харгалзан хил орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлж, Хөвсгөл нуурын экосистемийн нөөцөд түшиглэсэн аялал жуулчлалын тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.

- Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд “Цэнхэр сувд” байгалийн шинжлэх ухааны музейн цогцолбор байгуулна.
- Хөвсгөл аймгийн нисэх буудлыг 4С ангиллын болгон өргөтгөнө.
- Соёл, аялал жуулчлалын 4 төсөл хэрэгжүүлнэ.

ХАНГАЙН БҮС

Бүсийн хөгжлийн зорилго нь дэлхий дахинд Монголын түүх, төрт ёс, соёлын өвийг түгээн дэлгэрүүлж, Орхоны хөндий, Хангайн нурууны байгалийн онцлогт тулгуурлан аялал жуулчлал, боловсруулах үйлдвэрлэлийг дагнан хөгжүүлсэн "Дэлхийн нүүдэлчдийн соёлын голомт нутаг, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бүс" болно.

СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУСГАЙ БҮС, ГЕОПАРК

Орхон голын сав, Хангайн нурууны экосистемд түшиглэсэн түүх, соёл, рашаан сувиллын аялал жуулчлалыг уламжлалт, сэргээн засах анагаах ухаантай уялдуулан хөгжүүлнэ.

- Өвөрхангай аймагт Өндөр гэгээн Занабазарын бүтээл, соёлын өвд тулгуурлан соёлын аялал жуулчлал, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжинэ.
- Архангай аймгийн Өгийнуур орчимд археологийн нөөцөд тулгуурлан “Төв Азийн түүх, соёлын голомт” соёлын аялал жуулчлалын цогцолборыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.
- Соёл, аялал жуулчлалын 6 төсөл хэрэгжүүлнэ.

БАНГАЙН БҮС

Бүсийн хөгжлийн зорилго нь Төв Азийн орнууд болон ОХУ, БНХАУ-ын зах зээлтэй холбогдож, Дэлхийн өв Увс нуурын сав, Монгол Алтайн нуруу Хангайн нурууны байгалийн унаган төрх, олон угсаатны түүх, соёлын өвд түшиглэсэн тусгай сонирхлын аялал жуулчлалаар төрөлжиж, мал аж ахуй, газар тариалангийн нөөцөд тулгуурлан эко үйлдвэрлэлийн хоршилт бүхий "Тогтвортой хөгжлийн бүс" болно.

СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУСГАЙ БҮС, ГЕОПАРК

Монгол Алтайн нуруу, Хангайн нуруу, Увс нуурын ай сав, их нууруудын экосистемд түшиглэсэн байгалийн адал явдалт, тусгай сонирхлын, хил ▶

- ▶ орчмын аялал жуулчлалын тусгай бүс байгуулна.
 - Ховд аймгийн Эрдэнэбүрэн суманд Монгол Алтайн нурууны байгаль, соёлын өвд түшиглэсэн эко парк байгуулна.
 - Соёл, аялал жуулчлалын 4 төсөл хэрэгжүүлнэ

ТӨВИЙН БҮС

Бүсийн хөгжлийн зорилго нь олон улстай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, тээвэр логистикийн нэгдсэн сүлжээнд холбогдож, уламжлалт мал аж ахуй болон эрчимжсэн хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэлээр төрөлжиж, дотоодын хэрэгцээгээ бүрэн хангасан "Эрүүл хүнс үйлдвэрлэгч, экспортлогч бүс" болно.

СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУСГАЙ БҮС, ГЕОПАРК

Туул голын сав, Богдхан уулын экосистемд түшиглэсэн олон улсын арга хэмжээ, хотын аяллыг хөгжүүлэх Хөшигийн хөндийн аялал жуулчлалын тусгай бүс байгуулна.

- Хөшигийн хөндийд байгуулах сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолборыг түшиглэн "Кино, контент үйлдвэрлэлийн цогцолбор"-ыг байгуулна.
- Соёл, аялал жуулчлалын 4 төсөл хэрэгжүүлнэ

ЗҮҮН БҮС

ТҮҮХЭН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТӨРӨЛЖСӨН, ЭРЧИМЖСЭН ХӨДӨӨ АЖ АХУЙН ДЭД БҮС

Бүсийн хөгжлийн зорилго нь Зүүн Хойд Азийн орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, Хан Хэнтийн нуруу, Дорнод Монголын байгалийн экосистем, Дэлхийн өв Бурхан халдун, Эзэн Чингис хааны төрт ёс, түүх, соёлын өвд түшиглэсэн аялал жуулчлал, уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, уул уурхайн боловсруулах үйлдвэрлэлээр төрөлжсөн "Олон улсын худалдаа, тээвэр, логистикийн таталцлын бүс" болно.

СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУСГАЙ БҮС, ГЕОПАРК

Дорнод аймагт түүх, соёлын нөөц, Буйр нуурыг түшиглэсэн хил орчмын болон хил

дамнасан аяллыг хөгжүүлэх аялал жуулчлалын тусгай бүс байгуулна.

- Сүхбаатар аймгийн Дарьганга суманд тахилгат хайрхан уулс, түшиглэсэн байгаль, соёлын өвийн цогцолбор байгуулна.
- Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн Бурхан халдун, Буйр нуур, Алтан Овоо зэрэг түүхэн дурсгалт газруудыг холбосон аялал жуулчлалын дэд бүтцийг байгуулна.
- Соёл, аялал жуулчлалын 6 төсөл хэрэгжүүлнэ

ГОВИЙН БҮС

АЖ ҮЙЛДВЭРИЙН ТӨРӨЛЖСӨН, НОГООН ЭРЧИМ ХҮЧНИЙ ДЭД БҮС

Бүсийн хөгжлийн зорилго нь Бүгд Найрамдах Хятад Ард Улс болон Өмнөд Азийн орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, өндөр технологи бүхий уул уурхай, хүнд үйлдвэрлэлээр дагнан төрөлжсөн говийн унаган байгаль, түүх, соёлын өв, палеонтологийн нөөцөд түшиглэн аялал жуулчлал хөгжсөн "Үндэсний баялгийн санг бүрдүүлэгч бүс" болно.

СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУСГАЙ БҮС, ГЕОПАРК

Дундговь аймгийн Цагаансуварга орчимд палеонтологийн нөөцөд түшиглэсэн аялал жуулчлалын тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.

- Өмнөговь аймгийн нисэх буудлыг 4D ангиллын болгон өргөтгөнө
- Соёл, аялал жуулчлалын 5 төсөл хэрэгжинэ

УЛААНБААТАРЫН БҮС

Бүсийн хөгжлийн зорилго нь Төв болон Зүүн Хойд Азийн орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээ, байгаль орчны зохистой бүтэцтэй, 20 минутын үйлчилгээний хүртээмжтэй төвүүд бүхий хот болж "Олон улсын банк, санхүү, бизнесийн хөгжлийн төв" болно.

"НҮҮДЭЛЧИН" ДЭЛХИЙН СОЁЛЫН НААДАМ ТУСГАЙ БҮС

- Соёл, аялал жуулчлалын 3 төсөл хэрэгжүүлнэ ■



FASHION FOUND ON SUSTAINABILITY

Nomadic heritage
Luxury
Timeless
Beauty

SUSTAINABLE PRICING

Khanbogd Brand offers the highest quality, high-end cashmere knitwear at affordable and sustainable prices. Our products are crafted from the finest and most authentic fibers, sourced directly through sustainable practices that prioritize environmental care and support for herder communities.

18%

commission fee
to the travel guides

Premium products adhering to internationally
recognized certifications



KHANBOGD BRAND STORES IN ULAANBAATAR

LEFT SIDE of THE GOVERNMENT PLACE

Sukhbaatar Square 17, Baga Toiruu, 8th Khoroo,
Sukhbaatar District, 14200, Timetable: 10:00-20:00
Phone number: 7272-0666 /1/ 9451-0666

TOKYO TOWN STORE

Orgil Stadium 17011, Mahatma Ghandi Street, 15th
Khoroo, Khan-Uul District, Timetable: 10:00-20:00
Phone number: 7272-0666 /2/ 9429-0666

POLARIS DEPARTMENT STORE

Chinggis Avenue, 2nd Khoroo,
Khan-Uul District, Timetable: 10:00-19:00
Phone number: 7272-0666 /3/ 9421-0666

STATE DEPARTMENT STORE

3rd floor, Peace Avenue, 3rd Khoroo,
Chingeltei District, Timetable: 09:00-22:00
Phone number: 7272-0666 /4/ 9425-0666

ULAANBAATAR DEPARTMENT STORE

2nd floor Peace Avenue 57, Sukhbaatar District
Timetable: 09:30-21:00
Phone number: 7272-0666 /5/

INDUSTRY-19 BRANCH

Paragon 35-5 2nd floor, 19 Khoroolol,
2nd Khoroo, Khan-Uul District,
Timetable: 10:00-20:00
Phone number: 7272-0666 /6/ 9453-0666

LITTLE VENICE

Misheel complex, Chinggis Avenue,
Ulaanbaatar, Mongolia
Phone number: 7272-0666 /7/

RIVER PLAZA

17nd Khoroo, Khan-Uul District River Plaza
Ulaanbaatar, Mongolia
Phone number: 7272-0666 /8/

BAGA TENGER CITY

11nd Khoroo, Bayn-Zurkh District
Baga Tenger city, Ulaanbaatar, Mongolia
Phone number: 7272-0666 /9/

MINISTER TOWER

Olympic Street 5, Khoroo-1, Sukhbaatar District floor 9th No: 907, Ulaanbaatar, Mongolia

Tel: (976) - 7272-0666, (976) - 11 459-632

Email: marketing@khanbogdcashmere.com | www.khanbogdcashmere.com





Түнш аймаг

Монголын баруун хязгаар нутаг Баян-Өлгийд зочлоорой

Хүмүүс бид байгаль эхийн нэгэн бүтээл учраас байгальдаа ойр байх тусам амар тайван, аз жаргалтай байдаг. Тэнгэрт гэрэлтэх түмэн оддыг ширтэн, голын чимээ, нуурын давалгаа, салхины сэржигнээнд бүүвэйлэгдэн унтах, өглөө нь шувуудын ганганаагаар сэрэх үгээр илэрхийлэхийн аргагүй жаргал, амар амгаланг мэдрүүлнэ. Тэгвэл яг л ийм мэдрэмжийг Монголын баруун хязгаарт оршин байх байгалийн үзэсгэлэнт гайхамшиг бүрдсэн Баян-Өлгий аймгийг зорьж очсоноор мэдэрч болох юм. Манай улсад аялал жуулчлалын салбар эрчимтэй хөгжихийн зэрэгцээ онгон байгаль, нүүдлийн соёл иргэншил, түүх дурсгал, байгалийн үзэсгэлэнт газрыг үзэхээр гадаад, дотоодоос зорин ирэх жуулчдын тоо жилээс

жилд нэмэгдсээр буй. Жуулчдын хамгийн ихээр сонирхол татдаг, байгалийн үзэсгэлэнт бүрдсэн аймаг бол Баян-Өлгий юм.

Баян-Өлгий аймгийг зорин очсоноор байгаль, түүх, соёлын 9 гайхамшигийг үзэх боломжтой.

- Алтай таван богд уул
- Хотон, Хурган нуур
- Бага түргэний хүрхрээ
- Ёлтын сав газар
- Бага ойгорын хадны сүг зураг
- Шивээт хайрхны хадны сүг зураг
- Даян нуур
- Толбо нуур, Ачит нуур
- Цамбагарав уул ▶


▶ Эдгээр 9 гайхамшгаас гадна Сүүн гол жуулчдын анхаарлыг татна. Сүүн гол буюу Цагаан гол нь Баян-Өлгий аймгийн нутагт орших Алтай Таван Богд уулнаас эх авч 11км үргэлжлэн урсаад Ховд голд цутгадаг. Цагаан голын ус цайвар өнгөтэй байдаг нь мөстлөг ихтэй газраас эх авдагтай холбоотой аж. Нутгийн иргэд бэлэгшээн “Сүүн гол” хэмээн хүндэтгэн дууддаг бөгөөд дотоодын зарим аялагч голын усыг “сүү”-тэй зүйрлэн тахин шүтэж аягалж уух нь их тохиолддог.

Түүнчлэн Ачит нуурын талаар нэгэн домог байдаг. Эрт үед хүмүүс дайснаас дүрвэж өвс, ургамал, бэлчээр сайтай нутаг хайж яваад аяншин ядарч, өлсөж ундаасан зүдэрч байтал нэгэн томоохон нуур харагдахаар, тэнд очжээ. Гэтэл тэр нуурын мандлаас нэг том загасны сэрвээ цухуйгаад хөлдчихсөн байж. Хүмүүс түүнийг цавчин авч идэн тэнхэрч ихэд баярлан “Ээ хөөрхий Ачит нуур минь” гэж дуу алдсан гэдэг. Үүнээс хойш тэрхүү нуурыг “Ачит” нуур гэж нэрлэсэн домог бий. Энэ мэтчилэн Баян-Өлгий аймгийн онгон тагшин байгаль домог түүх агуулан өвөрмөц тогтоц, сүрлэг гайхамшигт үзэсгэлэнгээ гайхуулан оршин байна. Ийм л онгон тагшин байгаль жуулчдыг соронзон мэт татна.

Баян-Өлгий аймгийн аяллын голлох төрлүүд

- Онгон тансаг байгалийг үзэх
- Ахуйн амьдралтай танилцах
- Казах, Тува, Урианхай айлд зочлох, үндэстний ёс заншилтай танилцах
- Алтай таван богдын уулын авиралт
- Бүргэдийн наадам
- Бүргэдээр ан хийх аялал
- Явган аялал
- Морин аялал
- Спорт, загасчлах аялал
- Уулын дугуйн аялал
- Түүхэн дурсгалт газраар явах аялал
- Ховор ан амьтныг үзэх
- Машинаар аялах
- Усан спорт буюу завиар аялах
- Шувуу ажиглах аялал
- Нүүдэлчдийн амьдралтай танилцах, хамтран нүүж аялах

Гадаад, дотоодын жуулчдын тоо



ЭХ СУРВАЛЖ: Баян-Өлгий аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал залуучуудын газар

Баян-Өлгий аймагт 2024 онд гадаадын аялагчдаас **14,2** тэрбум төгрөг, дотоодоос **15,7** тэрбум төгрөгийн орлого зах зээлд эргэлджээ.

2025 оны эхний есөн сарын байдлаар гадаадын **20048**, дотоодын **27000**, нийт **47048** аялагчид Баян-Өлгий аймгийг зорин иржээ.

Баян-Өлгий аймгийн хэмжээнд **48** аж ахуйн нэгж, байгууллага аялал жуулчлалын чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

Баян-Өлгий аймгийн тэргүүлэх салбар Аялал жуулчлал

Баян-Өлгий аймгийн тогтвортой хөгжлийн хөтөлбөрт аялал жуулчлалын салбарыг эдийн засгийнхаа тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэхээр тусгажээ. Ийнхүү Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт аялал жуулчлалын салбарыг өргөжүүлэх бодлого боловсруулж, үе шаттай зохион байгуулахаар болсон байна.

- Алсын хараа 2050 “Эдийн засгийн тэргүүлэх салбар болон байршлын давуу талд тулгуурлан бүс, орон нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалыг хөгжүүлнэ”.
- Баруун аймгуудад өндөр уулын экосистем, Их нууруудын хотгорын байгаль, газарзүйн онцлог, олон ястан, угсаатны ахуй соёл, өв уламжлалд түшиглэсэн аялал жуулчлалын цогцолборыг байгуулна”
- Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 3.3.5 Дөрвөн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 1,1 Аялал жуулчлалыг ▶



► хөгжүүлэхээр хоёр зорилт, 10 арга хэмжээг тусгасан байдаг.

Баян-Өлгий аймгийн “Аялал жуулчлалын дэд хөтөлбөр”-ийн хүрээнд 2025 онд “Бүргэдийн баяр”, “Алтайн нүүдэлчдийн баяр”, “Хаврын Бүргэдийн баяр”, “Мөсний баяр”, “Наурызын баяр”, “Алтайн Урианхайн мөсөн сур харваа”, “Цагаан сарын баяр”, “Улсын их наадам”, “Алтайн бүргэдийн баяр”, Алтанцөгц сум “Бүргэдийн баяр”, Сагсай сум “Бүргэдийн баяр”, Алтай сум “Altai nomads games” festival зэрэг нийт 12 эвент арга хэмжээний жагсаалтыг гаргаж, зохион байгуулж байгаа юм байна.



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГТ 2026 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЭВЕНТ АРГА

Нэр	Байршил	Сар, өдөр
Аймгийн “Бүргэдийн баяр”	Бугат, Буянт сум	10-р сарын 03, 04
Алтайн нүүдэлчдийн баяр	Сагсай, Улаанхус сум	Жил бүрийн 2-р сар, 11-р сарын 2 дахь долоо хоног
Хаврын “Бүргэдийн баяр”	Улаанбаатар хот	3-р сарын 07, 08
Аймгийн “Тунгалаг Толбо” Мөсний баяр	Толбо нуур Сурын холбоо	2-р сарын эхний долоо хоногийн амралтын өдрүүдэд
Цагаан сарын баяр	Өлгий сум	2-р сар
Нүүдэлчдийн баяр	Өлгий сум Памук ресорт	3-р сарын 15
Наурызын баяр	Баян-Өлгий аймаг болон бүх сумын төвд	3-р сарын 21, 22
Түлэг бүргэдийн баяр	Сагсай сум	3-р сарын 21
Улсын Их баяр наадам	Өлгий сум	7-р сарын 11-15
Алтайн бүргэдийн баяр	Толбо сум	9-р сарын 21, 22
Алтанцөгц сум “Бүргэдийн баяр”	Алтанцөгц сум	9-р сарын 26, 27
Сагсай сум “Бүргэдийн баяр”	Сагсай сум	9-р сарын 17, 18
Altai nomad games	Алтай сум	09-р сарын 12, 13

ЭХ СУРВАЛЖ: Баян-Өлгий аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал залуучуудын газар

► Буянт сумын Шар нуурын "Хойлог толгой", Бугат сумын Чандмань толгойн "Саят талбай" зэрэг газарт 26 дахь жилдээ аймгийн "Бүргэдийн баяр-2025" наадмыг зохион байгуулжээ. Уг наадмын хүрээнд Бүргэдээ биедээ дасгасан байдал, Шырга, Угсаатан, Казах ард түмний үндэсний тоглоом наадгай, Кыз хуар, Тенге илүү, Көкбар буюу Тулам булаалдах, Айтыс, Сур харваа, Асаг агу буюу Шагайн харваа, Жороо морины уралдаан зэрэг уламжлал өв, соёлыг сурталчлах арга хэмжээг зохион байгуулсан байна.

Баян-Өлгий аймаг Улаанбаатар хотод жил болгон уламжлан явуулдаг "ITM Монголиа-2025" олон улсын үзэсгэлэнд түнш аймгаар оролцох тугаа гардан авч, бэлтгэл ажлаа эхлүүлжээ. Уг үзэсгэлэнд аймгийн Байгаль, түүх, соёлын өв уламжлалаа сурталчилан оролцохоос гадна, аяллын компаниуд дотоод, гадаадын аялал жуулчлалын компаниудтай хамтран ажиллах гэрээ хэлэлцээр хийж, жуулчдыг татах боломжийг эрэлхийлэх ач холбогдолтой юм.

Баян-Өлгий аймгийг аялал жуулчлалын дөрөвдүгээр бүс болгох ажлын хүрээнд Өлгий-

Сагсай-Улаанхус-Цэнгэл сумын чиглэлийн 89.13 км хагуу хучилттай авто зам, 91.1 урт метр Сагсай голын төмөр бетон гүүрний зураг төсвийг хийлгэж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төсөвт тусгажээ. Түүнчлэн Алтай Таван богд, Хотон, Хуурган нуур чиглэлд цахилгаан дамжуулах агаарын шугамын ажил нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа бөгөөд 2026 онд ашиглалтад орох юм байна. Бусад төсвийн хөрөнгө оруулалтаар аялал жуулчлалын бүсүүд 4G сүлжээнд холбогджээ. Мөн дөрвөн улирлын цогцолбор барих ажлын ТЭЗҮ-г 739 сая төгрөгөөр Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын Хотон, Хурган нуурын бүс нутгуудад хийжээ. Баян-Өлгий аймаг ийнхүү тэргүүлэх салбараа аялал жуулчлал болгож, олон талын арга хэмжээ, бүтээн байгуулалтыг хийж байна.

Аялагч та, аяллын турш байгалийн үзэсгэлэнг биширч, уулга алдаж, сэтгэл догдолж, баясах хамгийн гоё мэдрэмжийг Баян-Өлгий аймгийн үзэсгэлэнт байгалиас аваарай. ■



Baruun Beach Resort

Ц.Анхбаяр: Далайн эргийн орнууд руу урсах валютыг ЭХ орондоо үлдээх зорилготой

Аймаг, орон нутагт жуулчдад зориулсан бүтээн байгуулалт жил ирэх тусам нэмэгдэж байна. Үүний нэг нь Увс аймгийн Хяргас нуурын эрэгт байрлах “Baruun beach resort” юм. Тус жуулчны баазын захирал Ц.Анхбаяртай ярилцлаа.

-Энэ зун нийгмийн сүлжээнд олны анхаарлыг татсан, аяллын гол трэндүүдийн нэг танай бааз байлаа. Та баазынхаа үйл ажиллагааг танилцуулана уу?

-Намайг Цогийн Анхбаяр гэдэг. “Baruun beach resort”-ын захирал, “Төгс цэнхэр хязгаар” Увс аймгийн аялал жуулчлалын холбооны гүйцэтгэх захирал, мөн Увс аймгийн Засаг даргын аялал жуулчлалын асуудал хариуцсан зөвлөхөөр ажиллаж байна. Манай ресорт монголчуудын сайн мэдэх, байгалийн үзэсгэлэнт газруудын нэг Хяргас нуурын “Хэцүү хад”-нд байрладаг. Нэг ээлжиндээ 80 гаруй жуулчин хүлээн авах хүчин чадалтай.

-Нуурын эргийг түшиглэсэн олон бааз, амралтын газар байдаг. Тэдгээрээс танай тохижилт далайн эргийн үйлчилгээг санагдуулам гэдгээрээ ялгарч чадаж байна. Анх энэ санаа хэрхэн төрсөн бэ? Манайх шиг эрс тэс уур амьсгалтай, хүйтэн газар хэрэгжүүлэхэд амаргүй байсан болов уу?

-Анх 2020 онд “Baruun beach resort”-ыг барьж босгоод, үйл ажиллагаа явуулж эхлэхдээ л дэлхийн жишигт нийцсэн, үндэсний онцлогтой наран шарлагын газар байгуулахыг зорьсон. Учир нь Монгол Улсаас гадаад руу аялж буй иргэдийн дийлэнх нь далайн эрэг, наран шарлагын газарт амардаг гэсэн судалгаа байдаг. Нөгөө талаар бааз байгуулахаар шийдэж нуурынхаа эрэгт анх удаа очиход үнэхээр байгалийн үзэсгэлэн бүрдсэн, яг л гадаад далайн эрэгт ирсэн мэт сэтгэгдэл төрж, “яг



Монголд анх удаа нуурын эрэг дээр “Pool club” нээсэн

л энд наран шарлагын газар байгуулна даа” гэж өөртөө хэлсэн. Энэ ч утгаараа бид аялал жуулчлал өндөр хөгжсөн орнуудын далайн эргийн бүтээн байгуулалт, орчны тохижилт, үйлчилгээний соёлыг судалснаар, өөрийн онцлогыг бүтээн байгуулалтдаа шингээхийг эрмэлзсэн. Сүүлийн жилүүдэд Зүүн Өмнөд Азийн орнуудын далайн эргийн үйл ажиллагаатай очиж танилцах, туршлага судлахад тогтмол анхаарч байна.

Бид Увс аймгийнхаа түүхт 100 жилийн ойг угтаж нуурын эрэгт, хадан хясаан дунд “POOL CLUB”-ыг анхлан нэвтрүүлсэн нь ялангуяа манай дотоодын аялагчдын таашаалд нийцсэн шинэлэг үйлчилгээ болж чадлаа. Ер нь “Beach resort”-уудыг “Pool club”-гүйгээр төсөөлөхөд бэрх. Индонезийн Бали арлын нэг томоохон “Pool club”-ыг зорьж очиход тэнд маш олон европ жуулчин байгааг хараад “Хүний тав тухыг ийм хэмжээнд хангаж, шинэлэг орчин бүрдүүлж чадвал дэлхийн хаанаас ч жуулчид зорин ирдэг юм байна” гэсэн бодол төрсөн. Манай “Pool club”-ын үйлчилгээ хүмүүст яагаад илүү хүрсэн бэ гэхээр ▶

► Монголдоо анхдагч, хоёрдугаарт, нуур руугаа харсан харагдацтай, эргэн тойрон өндөр хадан хясаан дундах сүрлэг байршил, давстай нуурын ус, “Pool” доторх коктейл бар үйлчлүүлэгчдэд сэтгэгдэл төрүүлсэн болов уу. Мөн “Pool”-тэй залгаа байрлах хоёр давхар террасын интерьер тохижилтод зориулан мод, чулуу, зэгс, бургас зэрэг байгалийн эко материалыг Ховд, Увс, Хөвсгөл зэрэг аймгаас бэлтгэн авчирч ашигласан нь оновчтой шийдэл болсон.

-Танай баазыг зорих жуулчдын урсгал нэмэгдэх нь орон нутгийн эдийн засаг, малчдын амьжиргаанд эерэг нөлөөтэй байх. Малчид, сумынхантай хэрхэн хамтарч ажиллаж байна вэ?

-Өнгөрсөн жилийн тухайд “POOL CLUB” шинэлэг үйлчилгээ бий болсонтой холбогдуулан эрэлт огцом өссөн. Манайх амралтын байр цөөхөн учраас жуулчдын маш багахан хэсгийг багтаасан. Бусад нь буюу манайхыг зорьсон тодорхой хэмжээний жуулчид “Хэцүү хад” жуулчны бааз, “Отоглох цэг”-үүд, зөвшөөрөл бүхий нутгийн иргэдийн гэрт хоноглож, тэдний үйл ажиллагаанд бага ч болов дэм болсон болов уу. Нутгийн иргэд сүү, цагаан идээгээ боловсруулж айраг, тараг, өрөм, зөөхийгөө худалдан борлуулсан, мөн хонь, ямаагаа үнэ тохирч худалддаг. Харин цаашид нутгийн иргэд, малчид өөр өөр төрлийн нэмэлт үйлчилгээ бий болгох шаардлагатай гэж хардаг. Жишээлбэл, морь, тэмээ унуулах, “Хэцүү хад”-ны явган аяллын маршрут гаргаж хөтөч хийх, усан дээрх олон төрлийн үйлчилгээ үзүүлэх боломжтой. Энэ мэт манай ресортыг түшиглээд шинэ үйлчилгээ, бүтээгдэхүүн гаргах боломж орон нутгийн иргэдэд бүрэн бий.

-Төв суурин газар бус, алслагдсан аймаг орон нутагт хөрөнгө оруулалт хийнэ гэдэг нэг талаараа эрсдэл. Хөрөнгө оруулалт хийж, баазын үйл ажиллагааг эхлүүлэхэд ер нь хүндрэлтэй талууд юу байв? Газар олголт, санхүүгийн эх үүсвэр гэх мэт асуудал их сонсогддог?

-Хэцүү хад Ханхөхийн Нурууны Улсын Тусгай Хамгаалалттай газарт хамаардаг учраас хуульд заасны дагуу таван жилийн хугацаатай газар сунгалт хийгддэг. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, менежментийн төлөвлөгөөнд туссан ажил, үүргийг биелүүлэх ёстой гэдгээс илүү

Ирэх жил далайн эрэг, нар жаргах харууцтай илүү тав тухыг хангасан “Beach lounge” байгуулна

бид өөрийн төрсөн нутаг, байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалах ёстой. Ирээдүй хойч үедээ унаган төрхөөр нь үлдээнэ гэдэг ухамсар нэн түрүүнд байдаг. Тиймээс бүтээн байгуулалт хийхдээ байгалийн төрхийг алдагдуулахгүй, өөрчлөхгүй, сүйтгэхгүй байж, харин ч байгальдаа зохицуулж, нийцүүлж бүтээхийг эрмэлзсэн. Намайг анхлан жуулчны баазаа нээхэд “Хэцүү хад”-нд нэг л жуулчны бааз ажилладаг байлаа. Ганц бааз тэр олон хүмүүсийн эрэлтийг хангахгүй учраас алс холоос зорьж ирсэн жуулчид байгальд майхантай хоноглох, ил задгай бие засах, хог хаях зэрэг олон асуудал үүсгэсэн байсан. ►



► Тиймээс нэг талдаа эрэлт бий болсон байна. Хоёрдугаарт, өөрийн төрсөн нутагтаа, мал хариулж, отор хийж байсан газартаа шинэлэг бүтээн байгуулалт хийе гэсэн бодолтойгоор зориг шулуудан таван жилийн өмнө хөрөнгө оруулалт хийж эхэлсэн. Анх намайг энэ төслийг эхлүүлж байхад манай зарим нэг найз ирээд “Чи ийм зоригтой юм уу, эсвэл чи тэнэг юм уу” гэж гайхаж байлаа. Санхүүгийн хувьд аялал жуулчлалын бизнес улирлын хамаарал ихтэй учраас өөрийнх нь олсон орлогыг дараа жил өөрт нь зарцуулах зарчмаар бага багаар хөрөнгө оруулалт хийж эхэлсэн. Нэг дор их хэмжээгээр хөрөнгө оруулах боломж ч байхгүй байв.

Дараагийн нэг хүндрэлтэй асуудал зам харилцаа, дэд бүтэц. Манай ресортын бүтээн байгуулалтууд маш амаргүй нөхцөлд, олон хүний хамтын хүч хөдөлмөр, зүтгэлээр босдог. Холын тээвэр хийдэг, дээрээс нь бага багаар олон удаа зөөвөрлөдөг учраас өртөг зардал өндөр гардаг.

-Таныг Увс аймгийн Засаг даргын аялал жуулчлал хариуцсан зөвлөх хийдэг гэж ойлголоо.

-Увс аймгийн ИТХ-аар байгаль, соёлдоо тулгуурласан “Уул усны диваажин” аялал жуулчлалын хөтөлбөрийг боловсруулж батлуулсан. Энэ хөтөлбөрөөр бид “Уул усны диваажин” брэндийг зорилтот гадаад, дотоодын зах зээл дээр танилцуулах маркетинг, сурталчилгааны ажлуудыг шаг дараатай зохион байгуулах, өөрсдийн ондоошилдоо тулгуурласан эко этник эвэнтүүдийг хөгжүүлэх, ОХУ-ын өмнөд Сибирийн бүс нутаг буюу гурван сая хүнтэй хил орчмын бүсээс жуулчдыг татах зэрэг зорилтыг дэвшүүлсэн. Мөн Увс аймаг бодлогоор “ETHNO HARMONY” фестивалийг хөгжүүлнэ. Товчхон тайлбарлахад язгуур суурин дээр орчин үеийн хөгжмийн урсгалыг хослуулсан этно жанр, олон угсаатны оролцоо, эв нэгдлийн илэрхийлэл “harmony” цугларалтыг Увс нуурын эрэг дээр жил бүр зохион байгуулахаар төлөвлөж байна.

-Аймаг орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэх, бизнес эхлүүлэхэд төрөөс ямар зохицуулалт, дэмжлэг байдаг вэ? Төр хувийн хэвшил аль чиглэлд анхаарах шаардлагатай

Увс нуурын эрэг дээр “ETHNO HARMONY” фестивалийг тогтмол зохион байгуулна

гэж та хэлэх вэ?

-Аялал жуулчлалын салбар хувийн хэвшлийн нуруун дээр л явж ирсэн. Цаашдаа ч энэ зарчмаар явна. Анхаарал хандуулах шаардлагатай асуудал бол автозамын дэд бүтэцийн хөгжил. Ялангуяа, аялал жуулчлал хөгжсөн томоохон бүсүүд рүү автозамыг сайжруулаасай. Тухайлбал, Хэцүү хад руу зорчих хэсгийн элстэй хэсгийн замыг сайжруулахгүй бол жил бүр элсэн дээр асуудал үүсдэг. Энэ хэсгээр зөвхөн жип машинтай хүмүүс л элсэнд суулгүй гардаг. Бусад нь машинаа түлхэнэ, өөр машинаар татуулна, бүр гарч чадахгүй нь буцаад явна. Суусан машиныг татаж байгаад машинаа шатаасан, элсэнд хүчилсээр мотор, бусад явах эд ангиа эвддэг, гупер, подкирлогоо эвдэх бол энүүхэнд, нялх нойтон хүүхэдтэй, өндөр настай хүмүүс шөнө оройн цагаар элсээр гарч чадаагүйгээс болоод эрүүл мэндийн асуудал үүсдэг зэрэг олон кейс байна. Үүнээс болж амрагч жуулчид машин техник, эрүүл мэнд, эдийн засаг, цаг хугацаагаар байнга хохирч байгааг ойлгож төрийн зүгээс замыг сайжруулахад анхаарч энэ асуудлыг шийдэрлэж өгөөсэй гэж хүсмээр байна.

-Танай баазад ирж буй жуулчдын дийлэнх нь дотоодын жуулчид байсан болов уу? Дотоодын жуулчдын урсгалыг бид төдийлөн үнэлдэггүй. Таны хувьд энэ талаар ямар бодолтой байдаг вэ?

-Манайх анхнаасаа л дотоодын аялагчдын зах зээл дээр түлхүү анхаарч ирсэн. Монголын аялал жуулчлалын салбарынхан гадаадын жуулчин илүү хүлээж авахыг чухалчилдаг. Төрийн бодлого, ажил үйлчилгээ ч ихэнхдээ тэр чиглэл рүү түлхүү хазайдаг гэж хардаг. Гэтэл эсрэгээрээ дотоодын жуулчдын сонирхол, эрэлт хэрэгцээг судалж, шинэлэг үйлчилгээг бий болгож чадвал маш том зах зээл хүлээж байгаа. Энэ жил бид “POOL CLUB”-аа ашиглалтад оруулсан бол дараа жилийнхээ нууцаа задлахад хадан дээр нуур руугаа харсан шилэн фасадтай монгол гэр, дуу чимээ багатай тав тухыг хангасан, хадан дээрх далайн эргийн болон нар жаргах харагдацтай “BEACH LOUNGE” байгуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. ■




BARUUN BEACH RESORT

УТАС: 7777-0606 | 9900-1903

ИМЭЙЛ: tsogankhbayar@gmail.com

FACEBOOK: [Baruun beach resort](#)





Архангайн аялал жуулчлалын хамтын хүч "АРА"

Аялал жуулчлалын салбарын хөгжлийг хурдасгаад төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа хамгийн чухал. Төрөөс аялал жуулчлалын бодлогыг тодорхойлж, дэд бүтцийн хөгжил, хяналт зохицуулалтыг хангах, хөрөнгө оруулалтын орон зайг тэлж, хууль, эрх зүйн таатай орчныг бий болгоход анхаарч ажиллах үүрэгтэй. Харин хувийн хэвшил үйлчилгээний чанараа сайжруулах, шинэ санаачилга, бүтээгдэхүүн гарган, хөрөнгө оруулалт татаж ажиллахад анхаарах шаардлагатай.

Төр-хувийн хэвшлийн түншлэл нь аялал жуулчлалын салбарт дараах гурван чухал үр өгөөжийг бий болгодог

1. Дэд бүтцийн дэмжлэг ба чанартай үйлчилгээ-Зам, орон байр, соёлын төв, үзвэрийн орчин зэрэг бүтээн байгуулалтад хамтран хөрөнгө оруулснаар жуулчдын туршлага сайжирна.
2. Орон нутгийн эдийн засгийн эргэлт-Жуулчин ирэх бүрт орон нутгийн үйлчилгээ, хоол, тээвэр, гар урлалын салбар өсөж, аймаг, сумдын орлого нэмэгддэг.
3. Брэнд ба тогтвортой өсөлт-Хамтын хүчээр бүтээсэн бүтээгдэхүүн, арга хэмжээ нь тухайн бүс нутгийг аяллын шинэ брэнд болгож, тогтвортой хөгжлийн суурийг тавьдаг. "Түншлэл бол итгэлийн гэрээ, хөгжлийн түлхүүр" гэж бизнес судлаачид хэлдэг. Үнэхээр ч Монголын бүс нутгуудад энэ итгэлийн үр жимс тодхон ургах байна.

Байгалийн үзэсгэлэнт газрууд, түүх соёлын өв,

Өнгөрсөн онд тус аймаг 433 мянга гаруй жуулчин хүлээн авснаас 413 мянга нь дотоодын аялагч

нүүдэлчин ахуй, уламжлалт ёс, зан үйлээрээ аялал жуулчлалыг хөгжүүлэх бүрэн боломжтой Архангай аймгийн аялал жуулчлал сүүлийн жилүүдэд аймгийнхаа эдийн засгийн тэргүүлэх салбар болон хөгжиж байна. Өнгөрсөн онд тус аймаг 433 мянга гаруй жуулчин хүлээн авснаас 413 мянга нь дотоодын аялагч байжээ. Энэ нь 2022 онтой харьцуулахад хоёр дахин өссөн үзүүлэлт юм. Мөн өнөөдрийн байдлаар 124 гэр буудал, 36 жуулчны бааз, дөрвөн рашаан сувилал үйл ажиллагаа явуулж байгаа нь аялал жуулчлал орон нутгийн эдийн засгийн гол салбар болсны тод илрэл.

Архангайн аялал жуулчлалын шинэ хөдөлгөгч хүч "Ара Комплекс"


Архангай аймгийн эдийн засгийн өсөлтөд төрийн бодлого, хувийн хэвшлийн санаачилга хоёр гар гараа барилцан урагшилсны үр дүн юм. Учир юу гэвээс 2023 онд тус аймгийн түүхт 100 жилийн ойг тохиолдуулан Монголын анхны чингэлгэн цэнгэлдэх хүрээлэн "АРА комплекс" -ыг ашиглалтад оруулсан. Нийт 25 га талбайг хамарсан 1500 авто зогсоолтой, 4000 хүний багтаамжтай, босоо шоу тоглолт зохион байгуулбал 10 мянган хүн ч багтах цогцолбор аж. Мөн баяр наадмын үеэр цирк, амьтны хүрээлэн, музей, галлерей, 84 үйлчилгээ, борлуулалтын цэг, гэр буудал, майхантай буудлах хэсэг, хоолны газар, морины уяа, сурын талбай байхаас гадна 12 хэсэгт эко 00-ийн цэг байршуулж байжээ. Төслийн санаачлагч "Нутгийн хүнс трейд" ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Өлзийбаяр "Гэр ▶



2024 онд “АРА” фестивалийг зорьж 250.000 хүн очжээ

Архангай аймагт ирсэн жуулчдын тоо

2010-2024 он хүртэл



ЭХ СУРВАЛЖ: Архангай аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал залуучуудын газар

► бүлээрээ аялж буй аялагчид хүүхдүүдээ тоглуулж, цирк үзүүлэх боломжтой үйлчилгээний цогцолбор манай улсад хангалттай биш. Тиймээс уг бүтээн байгуулалтыг аймгийнхаа 100 жилийн ойг угтан эхлүүлсэн” хэмээн онцолсон. “АРА комплекс”-ын бүтээн байгуулалтын ажил хоёр сар гаруй хугацаанд үргэлжилсэн бөгөөд төрөөс ямар ч санхүүжилт аваагүй 100 хувь хувийн хэвшлийн бүтээн байгуулалт юм. Шинэ цэнгэлдэхийн үүд нээгдсэн цагаас Архангай аймаг урлаг, соёлын амьдралын төв болж, урлагийн тоглолт, шоу, арга хэмжээ зохион байгуулагддаг болсон нь дотоодын жуулчдын урсгалыг эрс нэмэгдүүлжээ. Үүний үр дүнд орон нутгийн эдийн засгийн эргэлт, үйлчилгээний салбарын орлого огцом өссөн байна.

Архангай аймгийн ЗДТГ-тай хамтран “WINTER-LAND ICE FESTIVAL” болгон өргөжүүлж, аймгийн аялал жуулчлалын холбоо, “АРА комплекс” хамтран гурван өдрийн турш монгол өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, орон нутгаа сурталчлахаар зохион байгуулжээ.

Өвлийн хахир хүйтнийг давахад малчдад нэн түрүүнд хөнгөлөлттэй үнээр өвс тэжээлээ худалдан авах хэрэгцээ үүсдэг. Энэ асуудлыг шийдэх зорилгоор “АРА комплекс”-ын хамт олон тус фестивалын үеэр хөнгөлөлттэй үнээр малчиддаа өвс, тэжээлийг нь газар дээр нь түгээх шийдлийг нэвтрүүлж, мөн Монголын анхны өвсөн түр стадион барьсан юм.

Өнгөрсөн онд “АРА” фестивалийг зорьж 250 мянган хүн очсон байдаг. “АРА комплекс” цэнгэлдэхэд нутгийн иргэдэд зориулан асар гарган түрээслүүлж худалдаа наймаа, хоол үйлдвэрлэл зэрэг үйлчилгээг явуулах боломжоор хангажээ. Хэдийгээр “Ара Комплекс” нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар баригдсан ч орон нутгийн удирдлагуудтай хамтран урлаг, соёлын төслүүдийг хэрэгжүүлж, нийгмийн хариуцлага бодитоор биелүүлдэг. Архангай аймгийн баяр наадам энэ цэнгэлдэхэд зохион байгуулагддаг бөгөөд орон нутгаас нэг ч төлбөр авалгүйгээр наадмын бэлтгэл, ашиглалтыг хариуцан хийдэг уламжлал тогтжээ. Энэ бол нийгмийн хариуцлага, хамтын хөгжил, түншлэлийн бодит илэрхийлэл юм. Ийнхүү хувийн хэвшил санаачилж, төр дэмжиж, олон нийт хамтдаа хүртэж буй энэ загвар нь Монголын бүс нутгийн хөгжлийн жинхэнэ жишиг болж байна.

“Ара Комплекс”-ийн туриллагаас дараах сургамжс тодхон харагдана.

- Хувийн санаачилга+Төрийн бодлого=Бодит хөгжил
- Нийгмийн хариуцлага=Хамтын баяр баясгалан
- Орон нутгийн брэнд =Эдийн засгийн тогтвортой өсөлт



“Ара Комплекс” нь зөвхөн барилга байгууламж биш, харин Архангай аймгийн хөгжил, төр хувийн хэвшлийн түншлэл, аялал жуулчлалын шинэ хөдөлгөгч хүч болж чадсан юм. ■

Монгол Номадик

Д.Энхбаатар: Монголчуудын нүүдлийн соёл, аж ахуйг **нэг дор харах** боломжийг бүрдүүлсэн



Монголын аялал жуулчлалын бусад улс орнуудаас ялгарах онцлог нь уламжлалт нүүдлийн соёл билээ. Нүүдлийн соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлд тэргүүлж буй “Монгол Номадик” жуулчны баазын захирал Д.Энхбаатартай ярилцлаа.

-Танай жуулчны бааз байгуулагдаад хэдэн жил болж байгаа вэ? Анх аялал жуулчлалын бизнес эхлэх санаа хэрхэн төрж байсан бэ?

-Анх 2011 онд баазынхаа үйл ажиллагааг эхлүүлсэн. Аялал жуулчлалын салбар руу орохоос өмнө нь янз бүрийн ажил хийж түүнээсээ нэлээд залхсан л даа. Арав гаруй жил барилга барих, наймаа хийх зэргээр мөнгө олъё гэсэн бодолтой явсан. Наймаа хийж үзсэн. Нэгэн хэвийн сонирхолгүй, уйтгартай байсан л даа. Харин аялал жуулчлалын бизнес бол маш органик гэж хэлж болно. Уул уурхай шиг газар ухахгүй, наймаачин шиг гадаадаас бараа татахгүй. Монгол ахуйгаа шингээж, байгаль орчиндоо ойр, зөв зохион байгуулалттай үйлчилгээг жуулчдад үзүүлье гэж бодоод бизнесээ эхлүүлж байлаа. Тэр цагаас хойш монгол ахуйг гадаадын жуулчдад үзүүлэх, үндэсний өв соёл уламжлалаа таниулахаар 15 жил ажиллаж байна. Жуулчдыг Монголдоо аялуулж,

Амьдрал баян гэдэг шиг шинэ санаа хэзээ ч дуусахгүй, бусдаас ялгарах онцлогоо тодорхойлох хэрэгтэй

байгалиа үзүүлж, үндэсний хоолоор дайлж, тав тухтай амрааж, хөтөлбөрийн дагуу сонирхолтой зүйлсийг үзүүлж байна. Тэгэхээр бидний хүсээд, яриад байдаг үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлсэн, жинхэнэ үнэ цэнтэй орлого олж байна даа.

-Жуулчны гэр бааз гэдэг Монголын аялал жуулчлалын гол онцлог бүтээгдэхүүн, харин баазууд дотроо нүүдлийн соёл ахуйг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгож хөгжүүлж буйгаараа “Монгол Номадик” жуулчны бааз ялгардаг. Уламжлал, соёл, аялал жуулчлалыг хослуулсан үйлчилгээний онцлог юу вэ?

-Манай тур компаниудын гадаад сурталчилгааны материал нь онгон байгаль, монгол ахуй боловч жуулчин зориод ирэхэд нөгөө зураг дээр харсан шиг биш, анх харснаас нь зөрдөг тохиолдол бий. Тиймээс бааздаа жинхэнэ монгол нүүдэлчний амьдралыг яг байгаагаар нь харуулъя гэж шийдсэн. Манай бааз 100 жилийн өмнөх эсгий гэртэй, доторх тавилга нь монгол айлын хэв шинжтэй, унаа хөсөг нь ч үхэр тэрэг, морин тэрэг гээд тэр чигтээ л нүүдэлчин ахуйг бүрдүүлсэн.

Үдээс өмнө болон үдээс хойш тодорхой цагт гадаадын жуулчид зочилж ирдэг. Тэр үед нь хонин сүрэг нь ойрхон бэлчээд, гаднаа 20 орчим тэмээ, сарлаг, хайнагтай, уян дээр нь морьд уяатай 100

► жилийн өмнөх дээл хувцастай малчин айл угтана.

Үүний дараа морин хуур, хөөмий, монгол ардын дуугаар ая барих, дэмбээдэх, хуруудах, харилцан дуулах зэргээр жижиг хэмжээний найр хийж зочдыг оролцуулсан тоглолт үзүүлнэ. Зочдыг айраг, цагаан идээгээр дайлна. Мөн монгол гэрээ тайлбарлана, зочдыг оролцуулан хонь, ямаа, холбож саах, цагаан идээ боловсруулах, архи нэрэхийг бодитоор үзүүлж зочдод амсуулах, нум сум харвах, зочидтой хамт үндэсний тоглоом тоглох, эсгий хийх, сур элдэх, үхэр тэрэг, сарлагийн нуруу ачаа, тэмээн тэрэг, морин тэрэг гэсэн ердийн хөсгөөр хэрхэн нүүдэл хийхийг бодитоор харуулах зэрэг олон үзүүлбэр бий. Гэхдээ хэтэрхий нуршаад, олон цаг үзүүлбэл зарим жуулчин залгах учраас хоёр цагт багтаагаад нүүдэлчин монгол айлын аж амьдралыг харуулдаг. Манайх 200 орчим тур компанитай гэрээтэй ажиллаж, жуулчдыг нь хүлээн авдаг.

Хамгийн гол нь зуун жилийн өмнөх нүүдэлчдийн амьдралыг гадны хүмүүс бодитоор харах хүсэл сонирхол хэзээ ч буурахгүй гэдгийг мэдэж авсан нь 15 жил зүтгэсний минь хамгийн гол үр дүн, үнэ цэн юм.

-Нүүдлийн соёлыг үзүүлэхдээ та бүхэн тухайн орон нутгийн иргэдтэйгээ түншилж, нэг талаар амьд соёл үзүүлэх, нөгөө талаараа малчдын орлогыг нэмэгдүүлэх ажлыг хийж байгаа гэж ойлгосон. Энэ талаараа та мэдээлэл өгнө үү?

-Эхэндээ нутгийн малчидтай хамтран ажиллах гэж их хичээсэн. Гэвч малчдын амьдрал цаг уур, малаа дагадаг учраас тогтсон цагийн үйлчилгээ хийхэд бэрх байдаг. Харин бидний үйлчилгээ тогтсон цагт эхэлдэг. Зундаа 12 удаа зохион байгуулдаг ч Монгол Улсад төрийн дээд албан ёсны айлчлал, олон улсын хурал цуглааны зочдод зориулан бэсрэг наадам хийх гэнэтийн, төлөвлөгөөгүй зүйл ч гарна. Тэр үед адуу, мал маань ойрхон бэлчээд байж байх ёстой болдог. Тиймээс бид мэргэжлийн баг бүрдүүлж, малтайгаа байнга бэлэн байдаг ажилтнуудтай болсон. Энэ нь жуулчдыг цагтаа хүлээж авч, хөтөлбөрөө бүрэн үзүүлэх, үйлчилгээгээ жуулчдын сэтгэлд ханамжтай үдэж гаргахад чухал ач холбогдолтой.

Бид нүүдлийн ахуйг зүгээр нэг үзүүлбэр гэж харах бус, монгол хүний эрх чөлөө, амьдралын хэв маяг хэмээн боддог. Хотынхон өглөө, орой цагтаа баригдан амьдардаг бол хөдөөний хүн байгаль, цаг ууртайгаа зохицон өөрийн ертөнцөд амьдардаг. Энэ нь тэдний эрх чөлөө юм. Хөдөөний хүн өглөө малдаа явах уу, үгүй юу гэдгээ өөрөө шийднэ. Хаашаа явах, хэр удах нь ч өөрийн мэдэлд. Энэ бол

Гадаадын жуулчид нүүдэлчин монгол айлын амьдралыг сонирхох хүсэл нь хэзээ ч буурахгүй

амьдралын нэгэн соёл, ухаан юм.

-Нүүдлийн соёлоос гадна бэсрэг наадмыг зуны жуулчны оргил үед тогтмол зохион байгуулж байгаа нь бас онцлог санагддаг?

-Жуулчдын улирлын үеэр зохион байгуулагддаг Монгол Улсын хамгийн том арга хэмжээ, баяр бол наадам. Наадмын үеэр ирсэн гадаадын жуулчид улс, аймаг, сумдын наадам үздэг. Харин өмнө болон дараа нь ирсэн жуулчид бас наадам үзэхийг хүсдэг. Энэ хэрэгцээг хангах зорилгоор 2017 оноос бэсрэг наадам хийж эхэлсэн. Зундаа 6-9 сар гартал 12 удаа зохион байгуулдаг. Бэсрэг наадмын орчин нөхцөл, асар майхан, уралдах морьд, барилдах бөх, айраг цагаа гээд бүгдийг нь урьдчилан бэлдэнэ. Бөхчүүдтэй гэрээ байгуулаад хамтран ажилладаг. Мөн сур, шагайн харвааны тэмцээн болно. Түүнчлэн Монголын дүрслэх урлагийг жуулчдад харуулах, мэдээж тодорхой хэмжээнд борлуулалт хийх зорилгоор уран зургийн галерей нээсэн. Зундаа 20-30 уран бүтээлчийн монгол ёс уламжлал, ахуйг дүрсэлсэн 200 гаруй уран зураг, гэрэл зургийг дэлгэн харуулдаг. Үүнийгээ Улаанбаатар хотод үргэлжлүүлэн “Dugut” арт галерейд үзэсгэлэнгээ зохион байгуулна. Энэ нь соёлын аялал жуулчлалын нэг хэсэг болж чадсан.

-Та жуулчны баазын үйл ажиллагаа явуулж байгаа эсвэл явуулахаар төлөвлөж байгаа хүмүүст хандаж анхаарах шаардлагатай асуудал, зөвлөгөө өгнө үү?

-Агуулгаа хамгийн түрүүнд бодох хэрэгтэй. Тэрнээс таван гэр бариад жуулчин хүлээж аваад өөрийгөө аялал жуулчлалын салбарын хүн гэдэг байдал хоцрогдсон. Амьдрал баян гэдэг шиг шинэ санаа хэзээ ч дуусахгүй бусдаас ялгарах онцлог өөрсдийн брэнд бүтээгдэхүүнтэй болох хэрэгтэй. ■



Өвлийн аялал жуулчлал

Монголын өвлийн аяллын шинэ зүрх-Хөвсгөл

Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд аймгаас 200-250 сая төгрөгийн санхүүжилт баталсан

Өвөл бол дэлхийн жуулчдад аяллын хамгийн олон сонголт, хамгийн гүн сэтгэгдэл төрүүлдэг онцгой улирал. Европын уулархаг бүсүүд цанын баярт бэлдэж, харин өмнөд нутгууд халуун наранд бялхан байх хооронд Монголын уудам тал, цэнхэр нуур, мөнх цаст уулсын орон өөрийн өвөрмөц “хүйтний аялал”-аараа дэлхийн анхаарлыг татах бүрэн боломжтой. Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх нь зуны аялал жуулчлалын чанарыг бэхжүүлэх, өндөр түвшинд хүргэх бодлогын дамжин өнгөрөх зам юм. Өвлийн аяллыг хөгжүүлснээр жуулчлалын улирлыг уртасгах, хүний нөөцийг барьж тогтоох, орон нутагт эдийн засгийн үр өгөөж өгөх, улмаар олон улсын жуулчдыг өвлийн улиралд татах, зочлох үйлчилгээг тасралтгүй явуулах, тэдний үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой.

Аялал жуулчлал тогтвортой хөгжих нэгэн чухал хүчин зүйл тухайн орон нутаг, газарт нь тохирсон аяллын бүтээгдэхүүн, арга хэмжээг

зохион байгуулж, жуулчдын тасралтгүй урсгал бий болгож, жуулчны баазуудыг ашигтай ажиллах бололцоог бий болгох явдал юм. Иймд аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг тухайн орон нутгийн газарзүйн байршил, эдийн засгийн онцлог, байгалийн өвөрмөц тогтоц, түүхийн болон угсаатны зүйн дурсгалт газарт тулгуурлан бий болгож, арга хэмжээ зохион байгуулах нь зүйтэй гэдгийг салбарын мэргэжилтнүүд онцолдог. Хэрвээ Финландын “Лапланд” Санта Клаусын нутаг бол, Монголын Хөвсгөлийг “Цэнхэр мөсний ордон” хэмээн тодорхойлж болно.

Монгол орны хойморьт орших Хөвсгөл нуур нь дэлхийн хамгийн тунгалаг нууруудын нэг бөгөөд өвөлдөө цэнхэр мөсөн толь болон хувирдаг. Арванхоёрдугаар сараас эхлэн Хөвсгөл нуурын мөс зузаарч, жуулчдад мөсөн ертөнцийн хаалгаа нээдэг. Монгол орны дүн өвлөөр аялдаг жуулчдын ихэнх нь Хөвсгөлийн “Хөх сувд” мөсний баяр, Өмнөговийн “Түмэн тэмээний



► баяр”, Баян-Өлгий аймаг, Улаанбаатар хотод болдог “Бүргэдийн баяр”-ыг зорин ирдэг. Энэ дунд хамгийн хүлээлттэй баяр бол Хөвсгөл нуурын толин цэнхэр мөсөн дээр жил бүр зохион байгуулдаг “Хөх сувд” арга хэмжээг нэрлэж болно.

Хөвсгөл аймагт өвлийн аялал жуулчлалын хөгжлийн суурь эртнээс тавигдаж Тайгын аяллыг 1990-ээд оны эхээс хийж эхэлсэн. Анх нутгийн иргэдийн санаачлагаар 2000 онд Мөсний баярыг зохион байгуулж эхэлснээс хойш 25 жил болж байгаа аж. “Хөх сувд” мөсний баяр нэг талаараа үр хойчдоо өв уламжлалаа танин мэдүүлэх, нөгөө талаар орон нутгийн иргэдийн орлогыг дэмжих ач холбогдолтой.

Хөвсгөл аймаг мөнх цаст сүрлэг уулс, ян сарьдгууд, гүн цэнхэр Хөвсгөл нуур, хөвч тайга, цаатан иргэд, байгалийн үзэсгэлэн гоо цогцолсон нутаг юм. Хөвсгөл нутгийн өвлийн байгаль яг л үлгэрийн орон мэт үзэсгэлэнтэй, гайхамшигтай учраас сүүлийн жилүүдэд аялагчдын тоо нэмэгдсээр байна.

Мөн Цаа, Цасны баяр эвент арга хэмжээг 2017 онд тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөлтэй хамтран Рэнчинлхүмбэ суманд анх зохион байгуулж, түүнээс хойш жил бүр Цагааннуур суманд үргэлжлүүлэн



хийж байгаа аж. Хөвсгөлийн “Мөсний баяр” нь дэлхийд ховор соёлын өв. Нуурын мөсөн дээгүүр морин уралдаан, мөсөн баримал, уламжлалт тоглоомуудыг зохион байгуулдаг нь Монголын өв соёл, байгаль хоёрын хослолыг илтгэдэг.

Хөвсгөл аймаг газарзүйн хувьд дөрвөн улирлын аялал жуулчлал, тэр дундаа өвлийн аялал жуулчлал хөгжих хамгийн тааламжтай бүс нутагт тооцогддог. Тайга, Дархадын хотгор, Жаргантын гол, Ар босготын хавцал, Хөвсгөл нуур, Даян дээрх чиглэлд өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлснээр, жуулчдын тоо жил бүр нэмэгдэж байна гэдгийг тус аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газраас онцолсон. Эдгээрээс Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын урд орших Жаргантын гол -50 хэмд хөлддөггүй учраас нутгийн иргэд амьд устай хэмээн ярьдаг. Гол доторх ургамал нь ногооноороо, цэцэглэж, голын уур манан ойр орчмын мод бутыг цантуулж өвлийн улиралд үзэсгэлэнтэй болдог учраас иргэд сонирхон очиж зургаа авахуулж аялдаг байна.

Түүнчлэн Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын баруун, зүүн тайгад очсоноор Хөвсгөл аймгийн зургаа дахь хошуу мал цаа, цаатан иргэдийн аж амьдралтай танилцах боломжтой юм. Цаст тайгад цаатан иргэд олон зууны туршид

Шинэ оноо
Хөвсгөлд угтаж
цасны гэрэлд
мөрөө үлдээ


► нүүдэллэн, байгаль дэлхийтэйгээ зохицон амьдарч ирсэн ёс заншилтай жуулчид танилцаж, цаа унаж, урцанд хонох боломжтой. Жуулчдын дийлэнх нь Дархадын хотгорын өвлийн байгалийн үзэмж, цаатны ахуй амьдралыг сонирхож ирдэг гэдгийг аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын Захиргаа удирдлагын хэлтэсийн дарга Д.Дуламсүрэн хэлсэн.

Мөн “Хөвсгөл аймгийг зорих жуулчдын 80 орчим хувь нь зун, 20 орчим хувь нь намар, өвлийн улиралд ирдэг” гэв. Иймээс аймгийн зүгээс өвлийн улиралд ирж байгаа жуулчиддаа зориулан Рэнчинлхүмбэ суманд дархад зоны соёл, хувийн хэвшлийн санаачлагаар “Маанар соёл”, тайгын цаа цаатны ахуй амьдрал, соёлыг харуулсан цаа цасны баярыг энэ бүсэд зохион байгуулдаг аж.

Аймгийн хэмжээнд бүртгэлтэй зочид буудал найм, 133 жуулчны бааз мөн 110 гэр буудал бүртгэлтэй үйл ажиллагаа явуулдаг аж. Харин өвөлд 4-6 жуулчны бааз л үйл ажиллагаа явуулдаг байна. Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд аймгаас 200-250 сая төгрөгийн санхүүжилт баталсан гэдгийг Д.Дуламсүрэн дарга онцоллоо.

Өвлийн улиралд Монголд ирэх жуулчдын тоо цөөн ч, ирсэн хүмүүс “гайхамшигтай” гэж сэтгэгдлээ үлдээдэг байна. Хөвсгөлд өвлийн аяллыг хөгжүүлэх нь зөвхөн аяллын шинэ

Хөвсгөл аймагт ирсэн жуулчдын тоо /мянган хүн, жилээр/



ЭХ СУРВАЛЖ: Хөвсгөл аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал залуучуудын газар

“Хөх сувд” мөсний баяр ирэх оны 03-р сарын 2-4-ний өдөр болно

бүтээгдэхүүн биш, нутгийнхны орлогын эх үүсвэрийг бий болгоно. Байгалийн үзэсгэлэн, нутгийн соёл, эко амьдрал, цэвэр агаарыг хослуулбал дэлхийн аль ч орны жуулчдын сонирхлыг татахуйц “өвлийн брэнд” болно. Засгийн газар, орон нутгийн бодлогоор Хөвсгөлийг “эко аялал жуулчлалын бүс” болгон хөгжүүлэх зорилт тавьсан. Дэд бүтэц сайжирч, мэдээллийн төв, замын нөхцөл, баазууд шинэчлэгдэж байна.

Хөвсгөлд шинэ жилийн үеэр тайгын аялал, Ар босготын хавцал, Жаргантын гол, Хөвсгөл нуурын эрэгт шинэ оноо угтах боломжтой. Энэ чиглэлд аяллын маршрут ч бий. Шинэ жилийн үдэш Хөвсгөл нуурын мөсөн дээр асаасан галт зулын дөл, мөсөн баазын цагаан гэрэл, цаана нь гялтганах ододтой тэнгэр. Энэ бол зүгээр нэг баяр биш, амьдралын нэгээхэн гайхалтай мөчийг нээж буй агшин юм. Улаанбаатарын утааг ардаа орхиод, цасан дундах амар амгалан ертөнцөд шинэ онтой хамт сэтгэлээ цэнэглэхийг хүсвэл Хөвсгөлийг зориорой гэж уриалья.

Өвлийн шөнө нуурын мөсөн доороос гарах хангинаа, тэнгэрт бүжих туйлын туяа мэт гэрэл, цасан дээрх зөөлөн гялбаа энэ бүгд Хөвсгөлийн өвлийн аяллыг ер бусын болгодог. Шинэ оноо Хөвсгөлд угтаж цасны гэрэлд мөрөө үлдээе. ■

2026 оны өвөл зохион байгуулагдах эвент арга хэмжээ

Эвентийн нэр	Зохион байгуулагдах газрын байршил	Ерөнхий зохион байгуулагч	Хугацаа
“Маанарын соёл”	Рэнчинлхүмбэ сум Жаргант гол	Самгалдай төв	2026 оны 01-р сарын 17-19 өдөр
Цаа, Цасны баяр	Цагааннуур сум	Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар Цагааннуур сумын Засаг даргын Тамгын газар	2026 оны 02-р сарын 27-28-ны өдөр
Хөх сувд мөсний баяр	Хатгал тосгон	Соёл, Спорт, Аялал жуулчлал, Залуучуудын яам, Аймгийн Засаг даргын Тамгын газар	2026 оны 03-р сарын 2-4-ний өдөр
“Хөвсгөлийн цом” спорт загасчлалын тэмцээн	Ханх сум	Саян Радиан жуулчны бааз	2026 оны 03-р сарын 13-16 өдөр



Photo by Bayar




Мөсөн нуурын гайхамшгийг мэдэрч, цас мөсний орон Хөвсгөлөөр аялах гэж байгаа танд дараах баазуудыг санал болгож байна



Jargant Lodge in the Darkhad Valley

📍 Хөвсгөл аймаг, Ренчинлхүмбэ сум


☎ 8004 8283



Леона ресорт

📍 Хөвсгөл аймаг, Хатгал тосгон

☎ 8070 8799



New Roots Coffee

📍 Хөвсгөл аймаг, Их уул сум

☎ 8868 9050



Toilgot Camp

📍 Хөвсгөл аймаг, Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон

☎ 9909 2273, 9905 8406



Captain Tourist Camp

📍 Хөвсгөл аймаг, Алаг-Эрдэнэ сум


☎ 9000 3030



MS Guest House (MS Guesthouse)

📍 Хөвсгөл аймаг, Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон

☎ 9979 6030



Mountain view guest house

📍 Хөвсгөл аймаг, Мөрөн сум


☎ 8855 8399



Хөвсгөл Эко Тур

📍 Хөвсгөл нуур 65231 Hatgal, Mongolia 9838 9494

☎ 8855 8399



Хун Одод амралтын газар

📍 Хөвсгөл аймаг, Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон

☎ 8811 4321



SDayan guest house

📍 Хөвсгөл аймаг, Хатгал тосгон

☎ 8888 2617

Бодь даатгал ХК нь 1995 онд байгуулагдсан бөгөөд өдгөө 30 дахь жилдээ орон даяар 21 аймаг 330 сум 26 салбарт 200 гаруй ажилтан, албан хаагч, 1000 гаруй төлөөлөгчид 250 мянган харилцагчиддаа даатгалын үйлчилгээг хүргэн, тогтвортой үйл ажиллагаагаа явуулж байна.

“ГАДААДАД ЗОРЧИГЧДЫН АМЬ НАС, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ” ГЭЖ ЮУ ВЭ?

Гадаадын улс оронд аялж, амарч буй аялагчдад зориулсан аяллын иж бүрэн даатгал нь аяллын явцад тохиолдож болох гэнэтийн санхүүгийн эрсдэлүүдээс хамгаалагдаж, дэлхийн аль ч улс оронд, байрлалын хязгааргүй үйлчлэх 24/7 хамгаалалт бүхий даатгал

ДАВУУ ТАЛ БА ОНЦЛОГ

Bodi+SOS иж бүрэн даатгал нь дэлхийн тэргүүлэх International SOS эрүүл мэндийн байгууллагын давхар хамгаалалттай бөгөөд эмнэлгийн яаралтай тусламж эмчилгээ,

International SOS тусламж үйлчилгээ нь


- Утсаар эмнэлгийн зөвлөгөө авах
- Эмнэлэг болон эмчийн талаар мэдээлэл авах
- Эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх
- Эм тариа хүргүүлэх
- Орон нутгийн эмч дээр цаг авах


Монголын Анхны “Даатгалын цогц үйлчилгээ”-ний аппликэйшн

- Иргэдийн даатгалын 14 бүтээгдэхүүн, үйлчилгээг онлайнаар авах
- Иргэдийн бүх төрлийн даатгалын нөхөн төлбөрийн хүсэлт илгээх
- Нөхөн төлбөрийн явцын мэдээллийг бодит цагийн горимоор хянах, мэдээлэл авах



ТӨВ ОФФИС:

 15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Жигжиджавын гудамж-9, Сүхбаатарын талбай, Бодь Цамхаг

 +976-75054800

 www.bodi-insurance.com



Qr уншуулж
апп татаарай

Gobi Caravanserai Lodge: The Ultra Escapist Destination

Хязгааргүй говийн гүнд орших Говь Каравансерай лодж



Анх харахад Монголын уламжлалт гэр жуулчны баазуудаас тэс өөр ч, говийн нууцлаг бөгөөд сүнслэг мөн чанар “Говь Каравансерай” лоджийн булан тохой, хана туурга, халбага сэрээнээс нь хүртэл мэдрэгддэг нь ер бусын. Анх эрчим хүчний шугам ч яваагүй, ханьгүй хоосон талд “Говь Каравансерай”-г төсөөлж байсан үүсгэн байгуулагчдын хувьд энэ нутгийнх. Тиймдээ ч бодлын шуурга намдаан хоослогч тэрхүү говийн сүнслэг мөн чанарыг мэдрэх нь энэ цаг үеийн дээд тансаглал гэж итгэдэг. Тэд баазаа уран бүтээлчдийн говиос авсан мэдрэмжээ тэр дор нь буулгасан бүтээлүүдээр тохижуулсаар, уудам говийг бүхэлд нь дүрсэлсэн албан бус урлан болгожээ.

Сэргээгдэх эрчим хүч, хог, хаягдлын менежмент, соёлын өвийн хамгаалал, байгаль хамгаалал, нутгийн иргэдийн оролцоо гээд олон талаар тогтвортой хөгжлийн сайн жишиг болж буй “Говь Каравансерай” лоджийн гүйцэтгэх захирал, хамтран үүсгэн байгуулагч Г.Нинжинтэй бид ярилцаж, туршлагыг нь хуваалцаж байна.

-Говьд баазын үйл ажиллагаа эрхлэхийн хамгийн хүнд хэцүү ба сайхан нь юу вэ?

-“Говь каравансерай” лодж нь “Ultra Escapist” концепци буюу мэнд оршихуйнхаа төлөө одоогийн нөхцлөөс гарч, говь нутгийн нам гүм сүнслэг орчинд ирж, тэрхүү хүчтэй эрчмээр бие сэтгэлээ цэвэрлэж, оюун санааны алжаалаа тайлах газар юм.

Энэ зорилгод хүрэхийн тулд бид өдөр бүр элсэн шуурга, хуурай халуун цаг агаар, дэд бүтэцгүй алслагдмал оронзайн сорилтуудтай нүүр тулж байдаг хэдий ч маш сайн багийн ажил хийгээд зочид, хамтын ажиллагаатай байгууллага, хувь хүмүүсийн зүгээс ирэх талархал хүндлэл нь бидэнд урам зориг, эрч хүчийг хайрладаг.

-Яагаад Дундговийг сонгосон юм бэ?

-Дуу хуурын өлгий нутаг Дундговь бол говийн тойрон аяллын эхний цэг. Жуулчид Дундговь аймгийн Бага газрын чулуугаар дайраад Цагаан суврага үзээд дараа нь Өмнөговь руу аялдаг үндсэн жимтэй. Бидний үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэр бол Дундговь аймгийн Өлзийт суманд харьяалагддаг бөгөөд Цагаан суварга байгалийн үзэсгэлэнт тогтоцоос 5 км, Монголын хамгийн том сүг зургийн байгалийн ил галерей гэгддэг Дэл хөнжлийн уулаас 32 км зайд оршдог. Өлзийт сумын нутаг бол аймагтаа хамгийн олон урлагийн бүтээл, гавьяатууд төрсөн баримтыг харахад л утга уянгын онцгой энергитэй газар. Үнэхээр сонирхолтой.

-Та бүхэн тогтвортой хөгжил, байгальд ээлтэй аялал жуулчлалын хүрээнд ямар туршлагауд хэрэгжүүлдэг вэ?

-Бид үйл ажиллагаа явуулж буй газар нутгийнхаа онгон дагшин байдлыг хадгалан хамгаалах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах үүднээс НҮБ-ийн мянганы хөгжлийн зорилгод багтсан Байгаль орчны тогтвортой байдлыг хангах менежментийн цогц бодлогыг хэрэгжүүлдэг. Тухайлбал, бид нэг удаагийн хуванцрын хэрэглээнээс татгалзсан анхны лодж. Цаашлаад химийн орц найрлага ихтэй бүтээгдэхүүний хэрэглээг багасгаж, байгалийн гаралтай ахуйн бүтээгдэхүүн болон тохижилтын материал хэрэглэдэг. Мөн бид эрчим хүч болон усны нөөцийн хадгалалт ба хамгаалалт, хог хаягдалтай харьцах зарчмуудаа дагаж ажилладаг.

-Та бүхэн монголын уран бүтээлчидтэй хамтран ажилладаг туршлагаасаа хуваалцаач? Энэ хүсэл сонирхол юунаас, хэнээс үүдэлтэй вэ?

-“Говь Каравансерай” лоджийн уриа бол “Байгаль эх өөрөө уран тансаг, үзэсгэлэн гоо, төгс төгөлдөр нь билээ”. Байгаль эхийн үнэ цэнийг өөрөөс нь урган дэлгэрсэн урлаг соёлоор дамжуулж хүн шууд сэтгэлдээ хүлээн авдаг юм билээ. Уран бүтээлч байгаль эх хоёр нь яг л арга билиг мэт хослох бөгөөд үүгээрээ хүнд нэгийг бодогдуулж нөгөөг ухааруулж, ямар ч хатууг уяраан зөөллөж хайрлан энэрэх сэтгэлийг үүсгэх чадалтай юм шиг санагддаг. Энэ утгаараа суурин, завгүй амьдралтай энэ цагийн хүмүүст байгалийн эрчим, үнэ цэнийг мэдрүүлэх хамгийн оновчтой арга зам ч байж болох юм. Дорнын их говиор аялагчдад Монголын тал хээр нутгийн мөн чанарыг бид урлаг соёлоор дамжуулан таниулан, мэдрүүлж үнэ цэнийг нь түгээн дэлгэрүүлэх ▶

► чин хүсэлтэй. Төслийн нэр ч үүнтэй холбогддог. “Каравансерай” гэдэг үг нь ЮНЕСКО-д бүртгэлтэй өнөө цагт ашиглагдахаа больсон түүхэн нэршил бөгөөд мянганы туршид “Тэмээн жингийн зам” дагуу аянчин, жинчид сүлжин буудаллан амардаг соёлын солилцоо өрнөдөг төв цэг байжээ. Ийм ч учраас бид дүрслэх урлаг, соёлын элементүүдийг лоджийн орчинд үнэ цэнтэйгээр дэглэн толилуулахаас гадна үндэсний уран бүтээлчид, биет бус соёлын өв тээгч нартай хамтран ажиллаж төрөл бүрийн урлагийн арга хэмжээг зохион байгуулахыг чухалчилдаг.

-Та бүхэн эвент аялал жуулчлалыг Монголд хөгжүүлэхээр тодорхой ажлууд хийдэг. Хөгжим ба одны арга хэмжээг яагаад хийж эхэлсэн бэ? Ямар үзэл санаа мэдрэмжийг хуваалцахыг зорьдог вэ?

-Нүүдэлчин түмний байгаль эхээ шинжин судалж, тэр дундаа шөнийн тэнгэр, оддыг ажин орчлонгийн зүй тогтлыг танин мэдэж аж төрөх ёсондоо шингээн өвлүүлж ирсэн гүн ухаан, өв соёлын онцлогоо таниулан дэлгэрүүлэх зорилгоор бид “Сэтгэшгүй оддын чуулган” соёлын одон орны аяллын эвент арга хэмжээг жил бүрийн

6-дугаар сарын 24, 25 өдрүүдэд уламжлал болгон зохион байгуулж байна. Онгон дагшин байгальд үлгэр домог, дуу хуураар хөглөгдөж бүжин байгаль эхтэйгээ ахин давтагашгүй холбоос мэдрэмжийг энэ л арга хэмжээний үеэр зочид маань үүсгэн мэдрдэгээрээ онцлог.

-Жуулчдыг Монголд юу үзэж, ямар мэдрэмж аваасай гэж хүсдэг вэ?

-Бид өв соёлдоо эзэн нь байж улам илүү өргөн хүрээнд хэрхэн таниулах арга ухаанаа уралдуулж хөгжүүлэх нь чухал байна. Жуулчид Монголд үзэж харж, бахдан бишрэх аугаа баялаг өв, мэдлэгийн сан байна. Түгээмэл нэг жишээ бол Монгол хүний хүнлэг сэтгэл, уужуу талбиун ухаан байна. Энэ зан чанар нь надад бусад соёл иргэншийнхээс онцгой санагдаж би хувьдаа биширч явдаг юм. Үүнийгээ бид магадгүй илүү тодлож тордож таниулах аваас энгийн боловч хүчтэй ялгаралыг үүсгэж ч чадах юм. Энэ мэт байгаль дэлхий, өв соёл, монгол хүний онцлогоо бид тодотгон тордож эргэлтэнд оруулж сэргээж явахгүй л бол чимээгүйхэн алгуурхан мартагдаж устах эрсдэл ямагт дагаж байна...■

Үргэлжлэлийг www.mongolianeconomy.mn сайтаас уншаарай

GOBI
CARAVANSERAI

ADDRESS: Mongolia, Dundgobi province, Tsagaan Suvraga
/White Stupa/ Natural Landscape, Mandalgovi, Mongolia

MOBILE: 7709 1232
EMAIL: gobi@seraidesk.mn

Дотоодын аялал жуулчлал



Б.ЕРБАХЫТ

Евразийн Үндэсний Их Сургуулийн докторант, Отгонтэнгэр Их Сургуулийн аялал жуулчлалын багш

Дотоодын аялал жуулчлал **ЭДИЙН** **ЗАСГИЙГ ТЭТГЭГЧ** том салбар байх ёстой

Монгол Улс хэдийгээр уул уурхай, хөдөө аж ахуй голлосон эдийн засагтай ч экспортын орлогоороо аялал жуулчлалын салбар дэд байранд багтдаг. Харин аялал жуулчлалын салбарын эдийн засгийн орлогыг зөвхөн гадаад жуулчдын орлогод тулгуурлан тооцоолдог тул нийт эдийн засгийн хэмжээ үүнээс хэд дахин их байх боломжтой. Харамсалтай нь бидэнд бодит судалгаа, тоо баримт алга. Дотоодын аялал жуулчлал бол Монгол Улсын эдийн засгийг тэтгэгч том салбаруудын нэг юм. Үүнийг дараах байдлаар задалж тайлбарлах боломжтой.

Монгол Улс сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд зөвхөн гадаадаас ирэх жуулчны урсгал буюу inbound аялал жуулчлалд анхаарч, гадаад жуулчдын тоог нэг саяд хүргэх зорилт дэвшүүлсэн. Мөн 1994 оноос хойш гадаад жуулчдын эдийн засагт оруулж буй орлогыг тооцоолж ирсэн боловч өнөөдрийг хүртэл дотоодын аялал жуулчлалын эдийн засгийн орлогыг тооцох байтугай тоон үзүүлэлтийг ч гаргаж чадахгүй байна. Гадаад жуулчид 2024 онд 1.7 тэрбум долларын орлогыг Монгол Улсын эдийн засагт оруулсан бол дотоодын аялал жуулчлалын орлого хэд бэ гэдэг асуулт үлдэж байна.

Аялал жуулчлал хөгжсөн орнуудад ажиглагддаг нэг аксиом байдаг. Энэ нь дотоодын жуулчдын тоо болон эдийн засгийн үзүүлэлт гадагшаа чиглэсэн аялал жуулчлалаас давдаг зүй тогтол юм. Уг аксиом олон улс оронд хэрэгждэг бөгөөд тухайн улсын аялал жуулчлалын салбарын гол орлогыг дотоодын аялал жуулчлал бүрдүүлдэг. Хэрвээ уг аксиом зөв гэж үзвэл дотоодын жуулчдын тоо 2.6 сая орчим болж, эдийн засгийн эргэлт 1.7 тэрбум долларыг давах ёстой. Бид статистик тоо баримтыг гаргаж



Дотоодын аялал жуулчлал гадаадын жуулчдын нийт орлогын 31.6 хувьтай тэнцэхүйц байна

чадахгүй байгаа болохоос биш бодит байдал дээр дотоодын аялал жуулчлал Монгол Улсын эдийн засагт жинтэй нөлөө үзүүлж байж болзошгүй. Үүнийг баримтаар хайгаад үзье.

Монгол Улсын дотоодын аялал жуулчлалын өнөөгийн байдал

Дотоодын жуулчдын тоог тооцоолсон судалгаа байдаггүй боловч 2023 оны судалгаагаар зөвхөн 7-8 дугаар сардулсын хэмжээнд нийт 1.440.000 хүн аялж, эдийн засагт хамгийн багадаа 211.9-220.8 тэрбум төгрөгийн эргэлт үүсгэснийг тогтоосон. Уг үзүүлэлт нь хамгийн бага нөхцөлийг тодорхойлж, албан ёсоор баталаж байгаа. Бодит байдал дээр нэг их наяд орчим төгрөгийн эдийн засгийн эргэлт байх боломжтой гэж дүгнэсэн. Харин Дэлхийн Аялал жуулчлалын зөвлөлөөс 2022 онд Монголын дотоодын жуулчдын зарцуулалт 736.8 тэрбум төгрөг, орон нутгийн аялал жуулчлалын ▶

▶ зарцуулалт 1,149.3 тэрбум төгрөг ба нийт нэг их наяд 886 тэрбум буюу 538 сая ам.доллар гэж тооцоолжээ. Өөрөөр хэлбэл дотоодын аялал жуулчлалын зарцуулалт нь гадаадын жуулчдын нийт орлогын 31.6 хувьтай тэнцэхүйц байгаа ба цаашид эдийн засгийн эргэлтийн шууд, шууд бус, дам нөлөөллийг нийлүүлж тооцоолвол гадаадын жуулчдын орлогоос давах магадлалтай. Мөн дээрх судалгаануудын аль аль нь дотоодын аялал жуулчлалын хамгийн бага нөхцөлийг тодорхойлсон.

Дотоодын аялал жуулчлал бол алдагдаж буй боломж юм. Аялал жуулчлал өндөр хөгжсөн орнууд гадагшаа чиглэсэн аялал жуулчлалыг бодлогын түвшинд хязгаарлаж, дотоодын аялал жуулчлалыг дэмжих замаар эдийн засгийг тэтгэдэг. Цар тахлын жилүүдийн эдийн засаг зогсонги байдалд орсон хугацаанд олон улс дотоодын аялал жуулчлалыг бодлогоор сэргээж, эдийн засгийнхаа эргэлтийг хадгалж байв. Жишээлбэл, Румын улс цар тахлын жилүүдэд төрийн албан хаагч нарт амралтын өдрүүдэд улсынхаа амралтын газруудаар үнэ төлбөргүй, хөнгөлттэй үнээр үйлчлүүлэх эрхийн бичиг олгож, ард иргэдийн эрүүл мэндийг дэмжингээ нийгмийн стрессийг багасгах аргуудыг хэрэгжүүлж байв. Үр дүнд нь аялал жуулчлалын салбар зогсонги байдалд ороогүй. Хятад гэхэд цар тахлын үеэр хамгийн хатуу бодлого баримталж, хилээ удаан хугацаанд хаалттай байлгасан. Гэвч энэ хугацаанд иргэдээ дотооддоо аялахыг уриалж, эдийн засгийн эргэлтийг сайжруулах механизм болгож ашиглав. Үүний дүнд 2023 он гэхэд улс даяар дотоодын аялагчдын тоо 400 сая давж, эдийн засгийн үзүүлэлт нь нэмэх дүнтэй гарав. Хүн амын тоотой харьцуулбал Монгол Улсад дотоодын аялагчдын хувь харьцангуй өндөр учир гадагшаа алдагдаж буй валютыг хэмжээг бууруулж, шүүрэлтийг багасгах боломжтой. Энэ нь дотоодын аялал жуулчлалын алдагдаж буй хамгийн том боломж нь юм.

Нэн тэргүүнд юу хийх шаардлагатай вэ?

Монгол Улсад аялал жуулчлалыг хөгжүүлж, улирлын хамаарлыг багасгая гэвэл хамгийн түрүүнд дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, эмх цэгцтэй зохион байгуулах, эдийн засгийн үр өгөөжийг тодорхой болгоход анхаарах

Дотоодын жуулчдын тоо 2.6 сая орчим болж, эдийн засгийн эргэлт 1.7 тэрбум ам.доллар давах ёстой

шаардлагатай. Өөрөөр хэлбэл, эдийн засгийг тэтгэгч нэг салбарын хэмжээнд авч үзэж тодорхой бодлогын хүрээнд хөгжүүлэх шаардлагатай. Мэдээж том зургаараа ингэж авч үзэх ч хамгийн түрүүнд дараах ажлуудыг хэрэгжүүлж, дотоодын аялал жуулчлал эдийн засгийн томоохон салбар болох үндсийг бэхжүүлэх болно. Үүнд

- Дотоодын аялал жуулчлалыг олон улсын аргачлалын дагуу “domestic” болон “internal” гэж ялган, жуулчдын тоог нарийвчлан гаргах аргачлалыг батлуулж, мөрдүүлэх
- Дотоодын аялал жуулчлалын зарцуулалт, эдийн засгийн эргэлтийг тодорхойлох аргачлалуудыг баталж, эдийн засгийн үр нөлөөг бодитоор тооцоолж, үр дүнг ашигладаг болох
- Одоо явж буй улс ардын эрүүл мэндийг сайжруулахад чиглэсэн зарим тэтгэмжийг дотоодын аялал жуулчлалд холбон урамшууллын систем болгон өөрчлөх. Тухайлбал, бусад улс оронд байдаг, төрийн албан хаагчид амралтын хугацааны хасагдсан цалинд дотоодын аялал жуулчлалын байгууллагаар үйлчлүүлэх эрхийн бичиг авах, дотоодын аялал жуулчлал эрхлэгчдийн үзэсгэлэн яармагийг зохион байгуулах, аялал жуулчлалын маршрутуудыг нэгдсэн байдлаар сурталчлах, дотоодын аялал жуулчлал эрхлэгчдийг жижиг дунд үйлдвэрлэгч нарын эгнээнд бүртгэж, бойжуулах гэх мэт олон ажлыг хэрэгжүүлэх боломжтой.

Дотоодын аялал жуулчлалын салбарт анхаарахын тулд дээрх ажлуудыг хамгийн түрүүнд хийж гүйцэтгэх шаардлагатай. Дотоодын аялал жуулчлал зөвхөн эдийн засгийн үр өгөөж биш нийгмийн эерэг үр өгөөжүүдийг авчирдаг. Хотын иргэдийн стрессийг бууруулах, хүн амын эрүүл мэндийг дэмжих хамгийн чухал хүчин зүйл аялал жуулчлал байдаг ба үүнийг дотоодын аялал жуулчлалаар дамжуулан гүйцэтгэх боломжтой. Нийгмийн стрессийг бууруулахаас гадна хүүхэд багачуудыг байгаль орчныг хамгаалах арга ухаанд сургах, ард иргэдийн байгаль орчинд хандах хандлагыг дээшлүүлэх зэрэг маш олон эерэг төлөвшилийг нийгэмд түгээдэг. Дүгнэж хэлбэл, дээрх хүчин зүйлс, тоо баримтууд бидэнд ганцхан зүйлийг хэлж байна. Энэ бол “Монголын аялал жуулчлалын салбарт бодлого нь, тоо нь, үр ашиг нь тодорхой аялал жуулчлалын салбарын хөгжил хэрэгтэй” гэдэг ойлголт юм. ■

Хүний нөөц



Ч.Буянбадрах

Гаид төв, “Монголиан гаид тур”
ХХК-ийн гүйцэтгэх захирал

Дотоод нөөц боломжоо эхлээд харцгаая

Монгол Улс жуулчин хүлээж авах зах зээлийн чадавхиа бүрэн тодорхойлж чадаагүй, мөн нөөцөө бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байгаа орон юм. Аялал жуулчлалын нөөцийг эргэлтэнд оруулснаар олон талын ач холбогдол үүсэх ба түүний нэг нь хүний нөөц юм.

Өнгөрсөн хугацаа руу эргэн харвал, хэд хэдэн зүйл ажиглагдсан. Монгол Улсад аялал жуулчлалын хүний нөөцийн бодлого байхгүй, бодлогын баримт бичигт зөвхөн хүний нөөцийг “сургалтад хамруулна”, “ур чадварыг сайжруулна” гэсэн тунхагийн шинжтэйгээр тусгаж ирсэн. Тухайлбал, Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 4.4.1.Хүний нөөцийн эрэлтэд нийцүүлэн сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, 4.4.2. Хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, дадлагажуулах, чадавхжуулах ажлыг зохион байгуулах, 6.1.4.1.Сургалтын хөтөлбөрийг олон улсын түвшинд хүргэсэн байна... зэргээр тусгасан.

Хоёрдугаарт, аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн талаар хийсэн бодитой судалгаа байхгүй. Хурал, чуулган, илтгэл мэдээлэлд нэг жуулчныг хүлээж авахад ард нь 20 ажлын байр бий болдог гэж давтан өгүүлдэг. Хүний нөөцийн анхны том гэгдэх судалгаа 2010 онд “ТАСИС” хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн болов уу. Тэр үед 50 тур оператор хамрагдаж түүний 80 хувь нь 11-100 хүртэл байнгын ба түр ажилтантай, нийт ажиллагсдын 40 хувь нь эрэгтэй, 60 хувь нь эмэгтэй, хамгийн эрэлттэй нь хөтөч тайлбарлагч, үйлчилгээний менежер, аяллын тогооч гэж хариулсан байсан. Жижиг хүрээний судалгааны төслүүдийн тайланд хүний нөөцийн 30 хувь нь салбарт хамааралтай мэргэжилтэн, 30 хувь нь гадаад хэлний орчуулагч, 40 хувь нь салбарын бус



Ур чадвартай мэргэшсэн боловсон хүчнээ уул уурхайн салбарынханд алддаг

мэргэжилтнүүд гэж дурдсан байдаг.

Гуравдугаарт, салбарын хүний нөөц тогтворгүй. Мэдээлэл солилцоо муу учраас нэг байгууллагаас халагдсан хүн дараагийн компанид мөн адил хариуцлагагүй ажиллаж “ажлын байр дамнан явах” хандлагатай. Тэдгээр “дамжин явагсад” эцэстээ нэг жижиг тур оператор байгуулаад нуугдмал үлгэн салган оршоор байдаг нь худал зүйл биш юм. Мөн өндөр ур чадвартай ажилтнуудаа уул уурхай, олон улсын хөрөнгө оруулалттай байгууллага руу алддаг бөгөөд аялал жуулчлалын салбар нь тэдгээрийн хүний нөөцийг “бэлтгэгч бааз” маягтай байсаар ирсэн. Энэ нөхцөлийг улирлын хамаарал, цалингийн хэмжээтэй холбон үздэг.


Гарц шийдэл

“SAP Concur Global Business Travel” судалгаагаар дэлхийн аялал жуулчлалын менежерүүдийн 35 хувь нь аяллын хөтөч, ажилчдынхаа чадварт тулгуурласан аяллын хөтөлбөрт гол анхаарлаа хандуулж, 32 хувь нь аяллын зардлыг бууруулахад анхаарч байгааг тогтоосон. Тухайлбал, иог бясалгал хийдэг, цэцэг ургамал, ан амьтан, хорхой шавьж сонирхон судалдаг, ууланд алхдаг, урлаж бүтээдэг ажилтнуудынхаа чадварт тулгуурласан бүтээгдэхүүнүүд рүү илүү анхаарч байна гэсэн үг юм. Мөн тус судалгаагаар аяллын компанийн санхүүгийн менежерүүдийн 58 хувь нь компанийн тодорхой бус бодлогоос үүдэлтэй илүү зардал ▶



A STAR MONGOLIA

EGYPT 



ЭХЛЭХ ҮНЭ
7,490,000



ПИРАМИДЫН НУУЦТАЙ АЯЛАЛ 🌟
ГИЗА ПИРАМИД, НИЛ МӨРӨН, УЛААН
ЭРЭГ — ЭРТНИЙ СОЁЛ, АДАЛ ЯВДАЛ ТЭ
БАЙНА.

GEORGIA 





ЭХЛЭХ ҮНЭ
5,890,000



ТҮҮХБА ДАРСНЫ ОРОН 🇯🇪
КАВКАЗЫН ҮЗЭСГЭЛЭНТ
ЭРТНИЙ СҮМ ХИЙДҮҮД, АМТАТ ДАРС,
НАЙРСАГ ХУМУУС ТАНЫГ УГТАНА, УУЛС.



11/22
12/27
02/17

 **ШЧУД НИСЛЭГТЭЙ АЯЛЛУЧД** 
2025/12-2026/04

HAINAN, CHINA



ЭХЛЭХ ҮНЭ
3,990,000

TURKEY



ЭХЛЭХ ҮНЭ
5,490,000

BALI, INDONESIA



ЭХЛЭХ ҮНЭ
6,490,000

KAZAKHSTAN



ЭХЛЭХ ҮНЭ
6,290,000

VIETNAM



ЭХЛЭХ ҮНЭ
3,990,000

SINGAPORE




ЭХЛЭХ ҮНЭ
6,290,000

MALDIVES



ЭХЛЭХ ҮНЭ
8,590,000

CAMBODIA



ЭХЛЭХ ҮНЭ
5,690,000

OUR CONTACT
7200 - 9200



► гардаг гэж үзжээ. Салбарын хүний нөөцийн бодлого төлөвлөлт, стратегийг бий болгохын тулд дээр дурдсан тунхаг маягийн хэлбэрээс илүү нарийвчилсан, бодитой үйл ажиллагаа руу анхаарал хандуулах хэрэгтэй. Тухайлбал, салбарт нэн шаардагдаж буй мэргэжилтний өнөөгийн бодит эрэлт хэрэгцээг судалгааны үндсэн дээр тодорхойлох ёстой юм. Салбарт хүч түрэн орж ирсэн 1981-1996 оны Миллениалс, 1997-2012 онд төрсөн Жен-Жи үеийнхний ажил мэргэжилд хандаж буй нөхцөл, тэдний онцлогийг олон улсын түвшинтэй харьцуулан судлах, тэдэнд тохируулж болох ажлын байрны тодорхойлолтуудыг бий болгох ёстой.

Нийслэлийн Яармагт барьж байгуулсан аялал жуулчлалын МСҮТ-ийг салбарын хүний нөөцийг бүрдүүлэхэд чухал үүрэгтэй сургалтын байгууллага болгох бодлого хэрэгжүүлэх. Жуулчны баазуудад цахилгаанчин, мужаан, талх нарийн боовчин, массажист, үсчин, гоо сайханч зэрэг үйлчилгээний олон ажил мэргэжлийн хүмүүс хэрэгтэй. Үйлчилгээний менежер, бармен, бариста, зөөгч нарыг бэлдэхдээ дээрх мэргэжлүүдтэй уялдуулан 2-3 ажлын байр руу хөрвөх чадвартай бэлтгэх бодлого барих, мөн урлаг уран сайхан, эвент менежмент, энтертайнмент чиглэлийн мэргэжлүүдийг ч орхигдуулж болохгүй.

Их, дээд сургуулийн бакалаврын сургалтын хөтөлбөрийг салбарын ажил олгогчдын дунд хэлэлцүүлэх, бодит байдалтай уялдуулах, зарим мэргэжлийн индексүүдийг шинээр бий болгож боловсролын яамтай хамтран ажиллах, хууль журмуудад тусгуулах шаардлагатай. Байгууллага болон ажилчдын дунд ахмад болон гадаад ажилчнаар хангах ажил зуучлалын үйлчилгээг бий болгож стандартыг нь боловсруулах нь зүйтэй. Ажил олгогчдын санал хүсэлт, зорилгод нийцүүлэх замаар хүний нөөцийн ур чадвар, туршлагыг сайжруулах, үнэлэх хэмжүүр тогтоох. Улаанбаатар зочид буудал, Блю спот Тэрэлж ресорт гэх мэт зочлох үйлчилгээний газруудад ажиллаж буй гадаадын ажиллах хүчний давуу, сул талыг судлах, гадаадаас ажиллах хүч авсан тухайн байгууллагад татварын хөнгөлөлт үзүүлэх бодлогыг дэвшүүлэн тавьж шийдвэрлүүлэх шаардлагатай.

Ажилтнууд компанийхаа аялал жуулчлалын бодлогыг бүрэн ойлгоогүй байдгаас үүдэж компаниудын зардлыг нэмэгдүүлэхэд хүргэдэг. Тийм учраас, менежерүүд аяллын баг бүрдүүлэгч хөтөч, жолооч, тогооч гэх мэт ажилтнуудтайгаа хамтран тухайн аялалд тулгарч болох нөхцөл

байдлыг тодорхойлж, аяллын үед мөрдөх бодлогыг боловсруулж хэвших нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, ажилтнуудыг удирдах түвшний бодлогын хуралд оролцуулах нь ажилдаа хандах үнэ цэнийг нэмэгдүүлж, хүний нөөцөө туршлагажуулах, тогтвортой байлгахад эерэг нөлөөлнө.

Ажилчдын сэтгэл ханамж, туршлагыг үнэлэхэд анхаарч чадвал ажилчдын ёс суртахуун, бүтээмж, ажлын байрыг хадгалахад нөлөөлдөг. Аяллын хөтөч нь ахмад настнуудын асран хамгаалагч, зарим тохиолдолд эцэг эхийн үүрэг гүйцэтгэгч маягийн шинж чанарыг агуулсан байдаг учраас аяллын үедээ стрессдэж бухимдах нөхцөл үүсдэг. Тийм учраас хөтчүүдэд сонголт хийх, хувийн нөхцөл байдлаа харгалзан тухайн аяллын үйл ажиллагаанд оролцох эсэхээ шийдэхэд нь цаг өгөх нь чухал.

Компанийн цахим хуудас, дундын социал харилцааны аппликейшнд ажилтнууддаа зориулсан тухайн аяллын мэдээллийн сан, аяллын үед орон нутагт шинээр үүссэн, эсвэл өөрчлөгдсөн нөхцөл байдлыг дор нь мэдээллэх цонхуудыг нээж өгөх, аяллын эцсийн тайлан дүгнэлтийг бөглөх судалгааны асуултуудыг байршуулах зэрэг санал хүсэлтээ илэрхийлэх талбар бий болгох. Энэ нь аяллын хөтөч, бусад туслах ажилтнуудын цаг завьг хэмнэхээс гадна тэдний тухайн аялалд өгч буй үнэлгээг байнга сонсох нь цаашдын хамтын ажиллагаа, тогтвортой байдалд эерэгээр нөлөөлнө.

Салбарын улирлын шинж чанарыг хүлээн зөвшөөрч, жуулчны бус улиралд компанийн удирдлагууд манлайлал үзүүлж бие бялдарын эрүүл мэндийг сайжруулах хөтөлбөрүүдэд хамруулах, гадаад хэлний, хөтчийн мэдлэг чадвар, зочлох үйлчилгээний ажилтны ур чадварыг дээшлүүлэх сургалтуудыг компани дотроо зохион байгуулах хэрэгтэй. Түүнчлэн өөрсдөөр нь багшлуулах, туршлагыг сонсох, байгаль орчныг хамгаалах чиглэлд сайн дурын үйл ажиллагаа үйлсэд оролцох зэргээр ёс суртахуунтай манлайлал үзүүлэх нь ажилтнуудынхаа сэтгэл ханамжийг дээшлүүлэх, урам өгөх, компанийн үнэ цэнэтэй ажилтан гэдгийг мэдрүүлэх боломж юм.

Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг тогтвортой хөгжүүлэх нь тухайн салбарын бизнес эрхлэгчид, Засгийн газар, төрийн байгууллага, сургууль, улмаар олон улсын байгууллагуудын хамтын хүчин чармайлт юм. Эхлээд бүгдээрээ дотооддоо өөрсдийнхөө боломж нөхцөлийг эргэн харж хүний нөөцийн бодлогоо сайжруулахын төлөө хичээцгээе. ■

Их, дээд сургуулийн хөтөлбөрийг салбарын ажил олгогчдын дунд хэлэлцүүлж бодит байдалтай уялдуулах нь чухал.



ЖУУЛЧДАД ЗОРИУЛСАН 2026 БЭСРЭГ НААДАМ

6 сарын 6, 16, 27

7 сарын 4, 19, 25

8 сарын 3, 14, 28

9 сарын 6 -ны өдрүүдэд тус тус зохион байгуулагдана. Дээрх өдрүүдэд таарахгүй тохиолдолд та бүхний хүссэн өдөр захиалгаар хийж үйлчилнэ. tel: 88324411. 98118573. 99118573

MONGOL
NOMADIC
TOURIST CAMP



INTERNATIONAL TRAVEL MART

ITM

2026 оны 10-р сарын 23, 24, 25-ны өдөр



БҮРТГЭЛ ЭХЭЛЛЭЭ

